

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2017 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

2017 оны 11 дүгээр сарын 30

№	Агуулга	Бүгд	Зорилго 1 Иргэдийн оролцоотой Сүхбаатар дүүрэг	Зорилго 2 Боловсролд ээлтэй Сүхбаатар дүүрэг	Зорилго 3 Амьдрахад таатай Сүхбаатар дүүрэг	Зорилго 4 Иргэндээ үйлчлэх Сүхбаатар дүүрэг	Зорилго 5 Дэвжин дээшлэх Сүхбаатар дүүрэг
1	<b>Нийт заалтын тоо</b>	<b>150</b>	<b>15</b>	<b>28</b>	<b>32</b>	<b>35</b>	<b>40</b>
2	Үүний дотор:	100%	112	12	25	24	25
3		90%	18	1	3	2	4
4		70%	17	-	-	5	5
5		40%	3	2	-	1	-
6		Үнэлэх боломжгүй	-	-	-	-	-
7		Хугацаа болоогүй.	-	-	-	-	-
		<b>Нийт хувь</b>	<b>94.4%</b>	93.1%	98.9%	92.8%	94.5%



		байгууллагаас ирүүлсэн нийт 9,2 тэрбэм төгрөгийн дараах чиглэлийн 201 төсөл, арга хэмжээг төлөвлөн, боловсруулж, улс, нийслэлийн төсвийн задаргаа болон, дүүргийн төсвийн төсөл бэлтгэхээр ажиллаж байна.				
2	НЗДҮАХ-ийн 1.6.3 дахь заалт; 1.1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажлын саналыг иргэдээс хууль тогтоомжийн дагуу авч, иргэдийн оролцооны түвшинг дүүргийн хэмжээнд нэмэгдүүлнэ.	Сангийн сайдын 244 дүгээр тушаалын дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг тухайн хорооны иргэдийн санал, хэрхэн тохижуулах тухай ерөнхий зураглалыг авч, зөвшилцөн шийдвэрлэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТГХШХ	Хороодын ажлын алба
		Дүүргийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн А/111 дүгээр захирамжийн дагуу 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөх зорилгоор иргэдээс авах нээлттэй санал асуулгыг бүлгийн ярилцлага хэлбэрээр дүүргийн хороодод 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 15-ны өдрүүдэд 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 6/766 албан бичгээр хүргүүлсэн. Нээлттэй санал асуулгыг дүүргийн 20 хороонд хороодын Засаг дарга нар, ажлын албатай хамтран зохион байгуулж, хороод 100% идэвхи оролцоотой хамрагдлаа. Нийт нээлттэй санал асуулгад 20 хорооны 1006 иргэн оролцсон бөгөөд 2018 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 469 байршилд ажил хийх санал гаргасан. Нийт 469 санал ирснээс хасагдах болон бусад эх үүсвэрээр хийгдэх ажил 262, хийгдэх боломжтой 207 санал ирсэн байна. Сүхбаатар дүүргийн газрын албанд 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 6/887 дугаартай албан бичгээр 134 байршилд газрын давхцыг шалгуулахаар явуулахад 41 байршилд ажил хийгдэх боломжтойг хариу мэдэгдсэн. Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газарт Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 166 дугаар тогтоолоор батлагдсан Нийтийн эдэлбэр газрыг дахин төлөвлөн байгуулах тухай журмын 3 дугаар бүлгийн 3.1.1 дүгээр зүйлд заасны дагуу дараа оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 41 ажлын саналыг боловсруулан холбогдох архитектур төлөвлөлтийн даалгавар, зураг төслийн даалгавар авахаар хүргүүлсэн болно. Хороодын иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалтыг гаргаад байна.				100%
<b>1.2 Төрийн үйлчилгээг иргэдэд нээлттэй, ил тод мэдээлнэ.</b>						
3	1.2.1 Шилэн дансны хуулийн дагуу дүүргийн төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан мэдээлэлж, тайлагнаж ажиллана.	Шилэн дансны хуулийн дагуу дүүргийн төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан улирал бүр тогтмол мэдээлж, тайлагнаж ажиллана	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	Бүх байгууллагууд,	ДАА
		Шилэн дансны тухай хуулийн дагуу дүүргийн төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан Засаг даргын 142 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 181 тушаалын хувийг shilendans.gov.mn сайтад шивж оруулсан бөгөөд дүүргийн цахим хуудсанд байршуулсан. ДАА-аас Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад харьяалагдах байгууллагуудын шилэн данс тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны I-IV улирлын байдлаар дотоод аудит хийх нэгдсэн удирдамж”-ийн дагуу				100%

		<p>шалгахад Сүхбаатар дүүргийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 62 байгууллага 2016 оны мэдээллийг 100 % байршуулсан бол дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал 75.8%-тай мэдээллийг байршуулсан. Шилэн дансны холбогдох мэдээллийг “Аудит дотоод” фейсбуук хаягаар нийтэд мэдээлэн шуурхай ажилласан. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ил тод байдлыг хангахад хяналт тавьж мэдээллээ байршуулаагүй, хугацаа хоцорсон 14 байгууллагад зөвлөмж өгч гаргасан зөрчлийг залруулсан.</p> <p>2017 оны 05 дугаар сарын 09-ны өдөр дүүргийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Захиргааны шинэ санаачлага төрийн бус байгууллагуудтай хамтран дүүргийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний төрийн болон орон нутгийн өмчит 63 байгууллагуудын нягтлан бодогч нарт, 2017 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр дүүргийн ЗТДГ-ын байрны ТЭЗ-ын хамрах хүрээний төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нягтлан бодогч нарт шилэн дансны тухай болон, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар сургалт хийсэн. Дүүргийн санхүү, төрийн сан, Дэвшил ОНӨААТҮГ, 11 дүгээр сургууль, 16 дугаар сургууль, 25 дугаар сургууль, 42 дугаар цэцэрлэг 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг мэдээлээгүй байсныг хяналт тавьж зөрчлийг залруулсан. Ахмадын хороо, 248 дугаар цэцэрлэгийг Сангийн яаманд хүсэлт гарган шилэн дансны эрх нээлгэсэн.</p> <p>Мөн 2017 онд 41 байгууллагад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийхдээ аудитын төлөвлөгөө хөтөлбөрт Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар тусган зөвлөгөө өгч гүйцэтгэлийг шалган ажиллалаа.</p>				
4	1.2.2 Алслагдсан хороодод төрийн үйлчилгээг Хөдөлгөөнт оффис-оор үзүүлнэ.	<p>Алслагдсан хороод болох 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороодын иргэдэд зайлшгүй шаардлагатай үйлчилгээний жагсаалт, холбогдох бүртгэл судалгааг гарган хөдөлгөөнт оффисын үйл ажиллагааг жигдрүүлнэ.</p> <p>Дүүргийн Засаг даргын зөвлөх, орлогч, ЗДТГ-ын хэлтэс, албадын дарга нар, холбогдох мэргэжилтнүүдээс бүрдсэн “Хөдөлгөөнт оффис”-н 2 баг 2017 оны 04 дүгээр сарын 21, 26-ний өдрүүдэд дүүргийн 1-20 дугаар хороодод дараах 5 чиглэлийн дагуу ажиллан албан хаагчид, хэсгийн ахлагч нар, иргэдийн төлөөлөлтэй уулзаж хороодод тулгамдсан асуудлууд болон иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч боломжтой асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэн ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хороодын ажлын байрны ажиллах нөхцөл байдалтай танилцаж, санал хүсэлтийг хүлээн авах.</li> <li>• Ажлын байрны ашиглалт, хамгаалалт, өмчлөлийн байдалтай танилцах.</li> <li>• “Камержуулалт” болзолт уралдааны талаар танилцуулах.</li> <li>• Хороодын албан хаагчид, хэсгийн ахлагч нарын үйл ажиллагаатай танилцах</li> <li>• Хороодын иргэдээс санал, хүсэлтийг авах , боломжтой асуудлыг шийдвэрлэх</li> </ul> <p>Уулзалтын үеэр иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг бичгээр болон амаар хүлээн авч гарсан санал хүсэлтүүдийг шийдвэрлэх ажлын төлөвлөгөө гарган нийт 82 иргэний санал хүсэлтийг</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ААТ
						100%

		холбогдох хэлтсүүд шийдвэрлэн иргэдэд хариу өгч ажиллалаа.				
5	НЗДҮАХ-ийн 1.6.3 дахь заалт; 1.2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг үр дүнтэй, иргэдэд нээлттэй ил тод болгоно.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын гүйцэтгэлийн мэдээг сангийн яамны сайт болон шилэн дансны сайтад байршуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	СТСХ	
		2017 оны орон нутгийн хөгжил сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, дүүргийн орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр хийгдсэн 2013 оноос хойшхи батлагдсан төсөв, тогтоол, болон дэлгэрэнгүй мэдээллийг сар бүрийн 08-ны өдрийн дотор сангийн яамны сайт болон шилэн дансны сайтад байршуулан ажиллаж байна.				100%
6	1.2.4 Дүүрэг, хороодын иргэний танхимын үйл ажиллагааг идэвхжүүлэх, төр засгийн шийдвэрийг тогтмол мэдээлэлж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба болон хороодын иргэний танхимын зохион байгуулагч нартай хамтран иргэний танхимын үйл ажиллагааг идэвхжүүлж, иргэдэд зориулсан иргэдийн чадавхыг сайжруулах сургалтуудыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	
		Иргэдийн хууль эрх зүйн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадвар дадалтай болгох зорилтын хүрээнд хороодын Засаг даргын ажлын алба, дүүргийн Цагдаагийн хэлтсүүд хамтран Хар тамхи болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Хамтарсан баг-ийн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Батлах хамгаалахын шинэчилсэн хууль, Иргэний хэргийн хууль, Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, "Эрүүл мэнд эрхэм баян" өдөрлөгийн хүрээнд дүүргийн нарийн мэргэжлийн эмч нартай хамтран үнэ төлбөргүй үзлэг оношилгоо, Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдэд чадваржуулах, Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, төсөл боловсруулах арга зүй, "Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" дэд бүтцийн, Агаарын бохирдлыг бууруулах зэрэг 80 гаруй удаагийн сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран хороодын Иргэний танхимдуудад зохион байгуулж нийт 3780 гаруй иргэн хамрагдсан байна. Монголын Үндэсний брэндийн зөвлөлтэй хамтран Монгол Улсын үнэлэмж, байр суурь, монгол хүний үнэ цэнэ, өөрийн орныг дэлхийд таниулах, үндэсний брэндээ Монгол хүн өөрөө хэрхэн тодорхойлох талаарх мэдээлэл өгөх үйл ажиллагааг 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж 150 гаруй иргэн хамрагдлаа. Нийслэлийн Иргэний танхимд зохион байгуулсан Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн хэлэлцүүлэгт хороо тус бүрээс 15 иргэн хамрууллаа.				100%
7	1.2.5 Иргэний танхимын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана.	Шинээр хорооны цогцолбор байртай болсон 9, 14 дүгээр хороонд иргэний танхим байгуулж, ажиллах нөхцөл боломжоор хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ААТ
		Дүүргийн 9,14 дүгээр хороод шинээр хорооны цогцолбор байртай болсонтой холбогдуулан 9 дүгээр хороонд 438970 төгрөгөөр интернет, кабель, утас, 954000 төгрөгөөр хорооны дотоод				90%

		тохижилт болон Иргэний танхимын тохижилтуудыг хийж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. 14 дүгээр хорооны Иргэний танхимд 250000 төгрөгийн төсөвт өртөг бүхий хаягийг хийж байрлуулсан.				
8	1.2.6 Иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээг төвлөрүүлэн хүргэх, төрийн захиалгатай бараа ажил, үйлчилгээг иргэд, Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулахдаа мэдээллийн санг бий болгон ашиглаж ажиллана.	Иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээг төвлөрүүлэн хүргэх, төрийн захиалгатай бараа ажил, үйлчилгээг иргэд, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулахдаа мэдээллийн санг бий болгон ашиглаж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	
		Нэг цэгийн үйлчилгээний түргэн шуурхай байдлыг хангахын тул Улаанбаатар хотын банк, сүхбаатар дүүргийн нотариат, Монгол даатгал зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж иргэд, аж ахуйн нэгжид үйлчилгээг хүргэхийн зэрэгцээ тухайн байгууллагын мэдээллийн санд байршуулан иргэдэд лавлагаа мэдээллийг хүргэн ажиллалаа.				40%
9	НЗДҮАХ-ийн 1.6.5 дахь заалт; 1.2.7 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг хуульд заасан хэрэгслээр ил тод мэдээлнэ.	Худалдан авах ажиллагааг ил тод мэдээлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТГХШХ	ХААА
		Дүүргийн ИТХ-аар батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хүрээнд Захиалагчийн 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан дүүргийн Засаг даргаар батлуулан мөрдөн ажиллав. Батлагдсан төлөвлөгөөг Сангийн яамны tender.gov.mn, дүүргийн sbd.gov.mn, shilendans.gov.mn сайтуудад байршуулсан бөгөөд өдөр тутмын Өдрийн сонинд хэвлэн нийтлүүлж олон нийтэд нээлттэй ил тод мэдээлсэн. Мөн худалдан авах ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгийн мэдээллийг shilendans.gov.mn, sbd.gov.mn сайтад тогтмол байршуулж мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь 2017 онд 7876,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 143 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж 95 хувийг хэрэгжүүлээд байна				100%
10	НЗДҮАХ-ийн 1.6.3 дахь заалт; 1.2.8 Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээнд иргэд, олон нийтийн оролцоог хангаж, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулна.	Сангийн сайдын 39 дүгээр тушаалын дагуу иргэдийн бүлгийн жагсаалтыг үүсгэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТГХШХ	Хороодын ажлын алба
		Сангийн сайдын 2013 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Журам, жишиг баримт бичиг батлах тухай 39 дүгээр тогтоолын дагуу олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд оролцох сонирхолтой бүлгүүдээс ирүүлсэн хүсэлтэд үндэслэн “Иргэдийн бүлэг”-ийн жагсаалтыг үүсгэсэн бөгөөд 43 иргэдийн бүлэг, 149 иргэн бүртгүүлсэн. Иргэдийн бүлгүүдийг чадавхижуулан мэдээллээр хангах зорилгоор дүүргийн хариуцсан хэлтэс, албадын хамтарсан сургалтыг зохион байгуулж, иргэдэд олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны зөвөлгөө өгсөн.				100%
<b>1.3 Эко дүүрэг бий болгоход иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.</b>						
	1.3.1 Иргэдийн оролцоотой	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Эко орчин	Үйл	100	ТНААХ	

11	“Ногоон хөгжил-Сүхбаатар” хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ.	бүрдүүлэх чиглэлээр ухуулга, сургалт, сурталчилгаа явуулна.	ажиллагааны хэрэгжилт, хувиар			
		Мод тарьж ургуулах сонирхолтой айл өрх, иргэдэд Дүүргийн засаг даргын тамгын газар Ногоон хөгжил цэвэр агаар-нэг мод хөдөлгөөн ТББ-тай хамтран ногоон байгууламж, мод тарих аргачлалын талаар сургалт зохион байгуулж 64 иргэн хамрагдлаа. Мөн 10 дугаар сарын 13 ны өдөр Dream Green service ХХК-тай хамтран мод тарих арчлалтын талаар сургалт зохион байгуулж 26 иргэн хамрагдлаа.			100%	
12		Бүх нийтийн мод тарих өдрийг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ	
		Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн Мод тарих үндэсний өдрийг зарлах тухай 63 дугаар зарлигийн биелэлт хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2017 оны 04 дугаар сарын 28-ны өдрийн А/143, 2017 оны 10 дугаар сарын 11 өдрийн А/329 дүгээр захирамж гарч, захирамжаар Бүх нийтээр мод тарих өдрийг 2017 оны 05 дугаар сарын 13, 10 дугаар сарын 13-ны өдөр амжилттай зохион байгуулж 284 аж ахуйн нэгж байгууллагын 300 гаруй иргэн албан хаагчид 8000 ширхэг мод ,7531м2 зүлэг, 307м2 цэцгийн мандал шинээр тарьж цаашид арчлалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байна.			100%	
13	1.3.2 Ногоон байгууламж шинээр бий болгосон иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжиж ажиллана.	Хашаандаа мод тарьсан иргэдийг урамшуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ	
		Хашаандаа мод, бут сөөг тарьсан 11-20 дугаар хороодын 30 өрхийн судалгааг гарган Нийслэлийн Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.			40%	
14	1.3.3 Ногоон байгууламж тэдгээрийг арчлан хамгаалах ажилд иргэдийн оролцоог хангаж ажиллана.	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн мод бутыг хэлбэржүүлэх, шохойдож шуулт хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ	
		Дүүргийн нутаг дэвсгэр дээрх нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хашаан доторх мод бутыг хэлбэржүүлэх ажлыг 2017 оны 04 дүгээр сарын 14-ны өдрөөс 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хооронд зохион байгууллаа. Мод хэлбэржүүлэх ажлыг 5 багц болгон хувааж “Дус монголи” ХХК, “Эм Ти Ай Повер” ХХК, “Цац толгойн төгөл” ХХК, “Бодьмон” ХХК, “Өсөн дэвшин дээшлэх” ХХК-аар хийлгэн нийт 2765 ширхэг мод, ургамлан хашлагыг хэлбэржүүлэн шохойдсон.			100%	

15		Рашаан булгийн эх хамгаалах гэрээт ажилтан ажиллуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ	
	15 дугаар хороо зуун модны рашаан, 16 дугаар хороо Дамбадаржаагийн рашаан, 20 дугаар хороо Гүнжийн булгийн эхийг хамгаалах, орчны хог хаягдлыг цэвэрлэх сайн дурын идэвхтэй байгаль хамгаалагч 3 иргэнтэй гэрээ байгуулж сар бүр 100000 төгрөгийн урамшуулал олгон ажиллаж байна. Он гарсаар 3,600,000 төгрөгийн урамшуулал олгосон байна.					100%
<b>Хоёр. Боловсролд ээлтэй сүхбаатар дүүрэг</b>						
<b>2.1 Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын чанарыг сайжруулна.</b>						
16	НЗДҮАХ-ийн 4.1.1 дахь заалт; 2.1.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөх болон шинээр барих ажлыг улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлнэ.	Дүүргийн 54 дүгээр цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Ажлын явц, хувиар	50	ТГХШХ	
		Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн Худалдан авах ажиллагааны албаны захиалгаар 54 дүгээр цэцэрлэгийн барилгын буулгаж барих ажлын НХААГ/201700016 дугаар бүхий нээлттэй тендер шалгаруулалтыг 2017 оны 02 дугаар сарын 16-нд нээж 14 оролцогч тендер ирүүлсэн ч шаардлагад нийцсэн тендер нэг ч тендер ирээгүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.1-т заасны дагуу бүх тендерээс татгалзсан. Мөн хуулийн 30.4.1-т заасны дагуу 2017 оны 08 дугаар сарын 14-ний өдөр нээлттэй тендер шалгаруулалтыг дахин зарлаж 2017 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр нээж 16 оролцогч тендер ирүүлсэн. Тендер үнэлгээний шатанд хүчинтэй байх хугацаа дуусч нэг удаа 30 хоногоор сунгасан бай нийслэлийн Худалдан авах ажиллагааны албанаас 2017 оны 11 сарын 16-ны өдрөөр Тера линк ХХК-д эрх олгох мэдэгдэл хүргүүлэн, зөвлөмж гаргасан. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газартай 2017.11.24-ий өдрөөс 2018.08.30-ий өдрийн хооронд гэрээ байгуулан ажиллаж байна. Мэдээллийг холбогдох байгууллагаас тогтмол хүлээн авч, удирдлагыг мэдээллээр хангаж байна.				
17	НЗДҮАХ-ийн 4.1.1 дахь заалт; 2.1.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэн, сургуулиудыг хоёр ээлжээр хичээллүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын	71 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилгын ажлын саналыг дээд шатны байгууллагад уламжилна.	Санал боловсруулах үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТГХШХ	
		Монгол улсын Засгийн газрын гишүүдийн дүүрэгт ажилласан ажлын хүрээнд 71 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилгын асуудлыг танилцуулсан бөгөөд холбоотой саналыг харьяа				



	хувийг нэмэгдүүлнэ.	яамны сайд болон нийслэлийн Засаг даргын Тамгын газарт дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2017 оны 03 дугаар сарын 22-ны 3/622 албан тоотоор саналыг нэмэлт тайлбарын хамт хүргүүлсэн. Үүний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн нийслэлийн дүүргүүдэд ажилласан мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан бөгөөд 71-р сургуулийн өргөтгөлийн асуудал Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан. Сургуулийн барилгын өргөтгөлийн барилгын 1,500,000 мянган төгрөгийн эх үүсвэр 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2019 онд он дамжин хэрэгжихээр батлагдсан.				
18		13 дугаар хороонд шинээр баригдаж буй цэцэрлэгийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	Ажлын явц, хувиар	70	ТГХШХ	100%
		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13 дугаар хороонд 3 бүлэг 75 хүүхдийн ортой 248 дугаар цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгчээр Виртуалсофт ХХК ажилласан. Улсын комисс ажиллуулах мэдэгдэл 2017.08.24-ний өдөр өгч барилгыг 2017.09.22-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн. Сургалтын үйл ажиллагаа явуулахад БСШУСЯамнаас 15567.0 мянган төгрөгийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, дүүргийн орон нутгийн төсвөөс 19020,4 мянган төгрөгийн зөөлөн эдлэл, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн. Уг цэцэрлэгт 13 дугаар хорооны 149 хүүхэд хамрагдаж байна.				
19	2.1.4. Сургууль, цэцэрлэгийн засвар, тохижилтын хөрөнгө оруулалтыг тухай бүр шийдвэрлэнэ.	Сургалтын орчныг сайжруулах зорилгоор засварын ажлыг гүйцэтгэнэ.	Ажлын явц, хувиар	100	ТГХШХ	100%
		Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Дүүргийн 2017 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 02 дугаар тогтоолын дагуу 14 сургууль, цэцэрлэгийн засвар тохижилтын нийт 290,769.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээний худалдан авалтын захиалгыг боловсруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2017.06.27-ны өдрийн 6/1564, 2017.07.16-ны өдрийн 6/1661, 2017.07.28-ны өдрийн 6/1842, 2017.08.02-ны өдрийн 6/1893 дугаар албан тоотуудаар ХААА-нд шилжүүлсэн. Дүүргийн ХАААлба худалдан авах ажиллагааг 2017.07.17-ны өдрөөс 2017.09.14-ний өдрийн хооронд зохион байгуулж, дүүргийн Засаг даргын Тамгын газар 2017.08.14-ний өдрөөс 2017.10.17-ны өдрийн хооронд хяналт тавин ажиллаж, гэрээний хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.				
20	2.1.5. Сургуулийн өмнөх боловсрол, Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын чанарт тавих хяналтыг сайжруулна.	Сургалт-судалгаа, хөгжлийн бодлогын зөвлөлөөс сургалтын үйл ажиллагаа, чанарын ахицыг сайжруулах, зөвлөн туслах ажил зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	БХ
		Бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн сургалт удирдамж, хуваарийн дагуу 08 сарын 28-29-ны өдрүүдэд зохион байгуулагдсан сургалтуудад дүүргийн хэмжээнд 23 сургагч багш, 10 захирал, 1 сургалтын менежер 1 багш нийт 13 чиглүүлэгч, 2 зочин багш хамтарч ажиллалаа. Ирцийн нэгтгэлээр нийт 547 багш оролцохоос 458 багш оролцсон, ирцийн гүйцэтгэл <b>83,7%</b> байна.				90%

		Сургалт-судалгаа, хөгжлийн бодлогын зөвлөлийн журмыг Монгол Улсыг 2016-2020 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэл, эрх зүйн орчны шинэчлэл, Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлал, Нийслэл-2020 хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт үндэслэн багшийн хөгжлийг дэмжих замаар сурагчид хүүхэд багачуудын эрүүл, аюулгүй байдлыг хангах, зөв дадал хэвшилтэй Монгол хүүхдийг хөгжүүлж, төлөвшүүлэхэд зориулж боловсруулсан. Бүрэн дунд боловсролын сургалтын чанарт тавих хяналтыг сайжруулах ажлын хүрээнд дүүргийн 2017 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгийн судалгаанд суурилсан сургалтын удирдамж боловсруулан, 10 судлагдахуун /хими, биологи, математик, физик, англи хэл, нийгмийн тухай мэдлэг, газар зүй, монгол хэл, орос хэл, монгол улсын түүх/ тус бүрээр хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлгийг ЭЕШ-ын дүнгийн үзүүлэлтээр улсад тэргүүлсэн 11-р сургууль дээр зохион байгуулж, нийт 75 удирдлага, багш оролцон, ЭЕШ-ын дүнгийн үзүүлэлтээр өндөр амжилт үзүүлсэн 10 багшийн туршлагыг түгээн дэлгэрүүлж, сургалтын чанарт нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлж, 2018 онд хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тодорхойллоо.						
21	2.1.6. Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтыг дэмжиж ажиллана.	Цэцэрлэгт хамрагдаагүй 5 настай хүүхдүүдийг хувилбарт сургалтад хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	БХ		
		Цэцэрлэгт хамрагдаагүй 5 настай 143 хүүхдийн судалгааг хороо тус бүрээр гаргаж, мэдээллийн сан бүрдүүлсэн. Хувилбарт сургалтыг 3-5 дугаар сард хамран сургах тойргийн цэцэрлэг дээр 7 хоногийн 2 хүртэлх өдөр 1-2 цагийн хугацаатай зохион байгуулж, сургуульд бэлтгэх ажлыг зохион байгуулсан. Төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж чадаагүй 246 хүүхдийг нэмэлт элсэлтээр төрийн бус өмчийн 14 цэцэрлэгт хамруулсан. -14, 171-р цэцэрлэг хувилбарт сургалтаар 50 хүүхэд, 13-р хорооны 19 хүүхдийг 150-р цэцэрлэг Дэлхийн банкны итгэлцлийн сан, Японы Нийгмийн Хөгжлийн Сангийн санхүүжилтээр Хүүхдийг Ивээх сангаас Боловсрол Соёл Шинжлэх Ухааны яамтай хамтран хэрэгжүүлсэн “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төслийн хүрээнд хэвлэгдсэн “Дасгал ажлын дэвтэр “-ээр хүүхдээ хэрхэн хөгжүүлэх сургалтыг эцэг, эхчүүдэд зохион байгуулав. Боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Сосорбарам эцэг, эхэд сургалт явуулж, “Танай хүүхэд сургуульд элсэхэд бэлэн үү?” нэртэй 28 ширхэг номоо бэлэглэж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг дэмжин ажилласан.				100%		
<b>2.2. Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжинэ.</b>								
22	НЗДҮАХ-ийн 4.6.2 дахь заалт; 2.2.1. Залуучуудыг хотын соёлд суралцуулах, сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулна.	Залуучуудыг хотын соёлд суралцуулах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажил хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	Хороодын ЗДАА, ТББ		
		-“Гэр бүлийн өдөрлөг”-ийн хүрээнд 3 дугаар сард 10 залуу гэр бүл, хосуудад чиглэсэн хосын харилцаа, хандлага сэдвээр мэдээлэл хүргэж, сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн. -2017 оны 03 дугаар сарын 20-оос 04 дүгээр сарын 28-ны өдрийн хооронд дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран 2, 4, 35, 58 дугаар сургуулийн 8-11 ангийн нийт 500 сурагчдад өсвөр				90%		

		<p>насны хүүхдүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол сэдвээр сургалт уулзалт зохион байгуулсан.</p> <p>-2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр “Үнэт Зүйлсийн Боловсролын Академи”-ийн тэргүүн Р.Мөнхцэцэгтэй хамтран 13, 15, 17, 19-р хороодын 15 залуу хос гэр бүлд “Хосын харилцааны ур чадвар” сургалт зохион байгууллаа.</p> <p>-2017 оны 05 дугаар сарын 17-ны билэгт сайн өдөр Гэрлэх ёслолын ордон, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран 3,9,11,12,16,18 дугаар хорооны шинээр гэр бүлээ батлуулж, гал голомтоо бадрааж буй 6 хосдоо гэрлэлтийн баталгааг гардууллаа. Гэрлэх ёслолын ордны зүгээс хосуудад зориулан “Хосын харилцааны үнэ цэнэ” сэдэвт сургалт зохион байгуулав.</p> <p>-2017 оны 05 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс хамтран дүүргийн ерөнхий боловсролын 46 сургуулийн 12 дугаар ангийн нийт 900 сурагчдыг хамруулан “Ирээдүйн эзэд” сургалт зохион байгуулав.</p> <p>-Олон улсын охидын эрхийг хамгаалах өдрийн хүрээнд Хөөрхөн Зүрхнүүдийн Аян ТББ, жүжигчин П.Баттөр, Залуу Хатагтай Ноёдын Сургууль, Нандин Ертөнц сэтгэл судлалын төвтэй хамтран ерөнхий боловсролын 2,3,4-р сургуулийн охидод сургалт зохион байгууллаа.</p> <p>-2017 оны 10 дугаар сарын 19-ны өдөр Оюутан, залуучуудыг эерэг хандлагад уриалж, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйлийг сурталчилах, эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг ойлгуулж, даатгал, сайн дурын үзлэг оношилгоонд сайн дураараа хамрагдах сэдлийг бий болгох зорилготой “Эерэг хандлага-Эрүүл оюутан” аяныг Чингис хаан дээд сургууль, МУИС-ийн оюутны 5-р дотуур байрны оюутнуудад зохион байгууллаа.</p>					
23	2.2.2. Дүүргийн залуучуудын хөгжлийг дэмжин ажиллана.	Залуучуудын чуулган, өдөрлөг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	Хороодын ЗДАА, ТББ	
		<p>-Ерөнхий боловсролын 2, 58 дугаар сургуулийн 8-11 дүгээр ангийн нийт 8 бүлгийн 160 сурагчдад Харилцаа хандлага, ёс зүйн талаар мэдээлэл хүргэх сургалт зохион байгуулсан.</p> <p>-2017 оны 08 сарын 25-ны өдөр Нийслэлийн залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан залуучуудын хөгжлийг дэмжих хууль, зөрчлийн тухай хуулиудыг сурталчилан таниулах, эерэг сэтгэлгээний давалгаа сургалт, нийслэлийн иргэний дагаж мөрдөх 10 дадал сэдэвт “Бид зорилготой залуучууд” форум уулзалтад 1-20 хороодын 40 залуучуудыг хамруулсан.</p> <p>-Нийслэлийн Залуучуудын Хөгжлийн Газраас зохион байгуулж буй эерэг сэтгэлгээ аяны хүрээнд “Эрдэнэ тав” ТББ, дүүргийн ГБХЗХХ-тэй хамтран 2017 оны 10 дугаар сарын 05,06-ны өдөр 35,71,58,АЗЭСургуулийн сурагчдад “Эерэг амьдарцгаая нийслэлийн иргэний зөв 10 дадал” сэдэвт сургалт зохион байгуулж, нийт 226 сурагч хамрагдлаа. Уг сургалтад хамрагдсанаар хүүхэд залуус хүмүүстэй зөв боловсон харилцах, харилцааны сөрөг хандлагыг өөрчлөхөд өөрсдөөсөө эхлэх, нийгмийн оролцоо, ёс суртахуун, харилцааны эерэг соёлын талаарх мэдлэг боловсрол, санал санаачлага нэмэгдэж эерэг хандлагатай болж төлөвшсөн.</p>				100%	
	2.2.3. Дүүргийн хэмжээнд	Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Хараа	Үйл	100	НХХ	ХГБХТ,	

24	Хүүхдэд ээлтэй-Улаанбаатар хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	<p>хяналтгүй хүүхдийг илрүүлэх" ажлыг урьдчилсан суурь судалгаанд тулгуурлан зохион байгуулна. Жич: Тухайн хороонд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудад хараа хяналтгүй хүүхдүүдийг хариуцуулж өгөх тусгай хөтөлбөр боловсруулж ажиллах,</p>	ажиллагааны хэрэгжилт, хувиар			Хороодын ЗДАА
		<p>"Хараа хяналтгүй хүүхэд-1" арга хэмжээг 01 дүгээр сарын 04-ны өдрөөс 02 дугаар сарын 01-ны өдрийн хооронд зохион байгуулж, нийт 14 хүүхдийг илрүүлж, гэрийн хаяг, эцэг эх, асран хамгаалагчийг тогтоон ажилласан. Үүнд: -Ар гэр, асран хамгаалагч нарт нь хүлээлгэн өгсөн- 9 -Хүүхэд залуучуудын тусгай цогцолборт хүлээлгэн өгсөн- 4 -Налайх дүүргийн Хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтэст хүлээлгэн өгсөн-1 2017 оны 06 дугаар сарын 15-16-ны хооронд нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон зах, худалдааны төв, кино театр, Сэлбэ голоор эргүүл хийж ажиллан, дүүргийн харьяалалтай хараа хяналтгүй, гуйлга гуйсан, хөдөлмөр эрхэлж буй хүүхэд илрээгүй ба РС тоглоомын газар цаг хэтрүүлэн тоглож байсан 15 хүүхдийг гэрт нь, Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст хүлээлгэн өгсөн-2, Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс болон ар гэрт нь – 3, Баянзүрх дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст 1 хүүхдийг тус тус хүлээлгэн өгсөн байна. 2017 оны 10 дугаар сарын 5,6-ны өдрүүдэд Цагдаагийн 1 дүгээр хэлтэстэй хамтран 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй РС тоглоомын газруудад хяналт шалгалт хийж нийт 5 хүүхдийг ар гэрт нь хүлээлгэн өгч хууль, эрхзүй, сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэн ажилласан. 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран Орон гэргүй иргэдийг бүртгэлжүүлэх, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж нийт 10 хүүхдийг бүртгэлжүүлэн зөвлөгөө өгч, эцэг эхтэй нь гэрээ байгуулан дулаан хувцас өгч, халуун хоолоор үйлчиллээ.</p>			100%	
25		<p>Дүүргийн оны шилдэг хүүхэд шалгаруулах арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг уламжлалт ажлыг тухайн сургууль, цэцэрлэгт явуулж боловсронгуй болгох оролцоог нэмэгдүүлнэ.</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ХГБХТ
		<p>Өөрийн авъяас, хичээл зүтгэлээрээ тэргүүлэн сурлага, спорт, урлагийн болон бусад төрлөөр амжилт гарган манлайлсан Оны шилдэг хүүхэд болон хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага шалгаруулах үйл ажиллагаа зохион байгуулах 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/372 дугаар захирамжийн дагуу ажлын хэсэг 5 номинацаар "Дүүргийн шилдэг хүүхэд" шалгаруулан, "Нийслэлийн шилдэг хүүхэд"-д 5 хүүхдийг тодорхойллоо. 8 номинацаар "Дүүргийн гэр бүлд ээлтэй байгууллага"-аа шалгаруулан, "Нийслэлийн гэр бүлд ээлтэй байгууллага"-д 8 байгууллагыг тодорхойллоо.</p>			100%	
		"Хүүхдэд ээлтэй-Улаанбаатар" хөтөлбөрийн	Үйл	100	НХХ	Хороодын

26		хэрэгжилтийг ханган ажиллаж, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр тэмдэглэнэ.	ажиллагааны хэрэгжилт, хувиар			ЗДАА
		Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд хороо бүр өөрийн онцлогт тохируулах өдөрлөгийн үйл ажиллагаа зохион байгуулсан. ЗДТГ-аас зорилтот бүлгийн /бүтэн өнчин, хагас, өнчин, хөгжлийн бэрхшээлтэй/ нийт 20 хорооны 1847 хүүхдэд гарын бэлэг гардууллаа.				100%
27	НЗДҮАХ-ийн 4.5.8 дахь заалт; 2.2.4. Гэр бүлийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.	Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр тэмдэглэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ТГХШХ ХААА, Хороодын ЗДАА
		Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан дүүргийн Алдарт эхчүүдэд хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг 03 дугаар сарын 05-наас 07-ны өдрүүдэд зохион байгуулав. Хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд дүүргийн Алдарт эхийн I дүгээр одонтой 1956, II дугаар одонтой 4766 нийт 6722 одонтой эхчүүдийн судалгааг хороодоос авч нэгтгэв. Хорооны Засаг дарга хорооны байран дээрээ одонтой эхчүүдийг хүлээн авч, аарцны ундаа, зөөлөн чихрийн цуглуулганы бэлгийн багцыг нийт одонтой 6722 эхчүүдэд өгч хүндэтгэл үзүүллээ.				100%
28	НЗДҮАХ-ийн 4.5.10 дахь заалт; 2.2.5. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллээс татгалзах хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх нөлөөллийн ажлуудыг эрчимжүүлнэ.	Сургалт, сурталчилгааны ажил, гарын авлага гаргана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	Хороодын ЗДАА
		<p>-Дүүргийн ГБХЗХХ, Цагдаагийн 1 дүгээр хэлтэстэй хамтран томоохон худалдааны төвүүдэд “Хонх дарж, хаалга тогшье” 2 өдрийн өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгийн хүрээнд иргэдэд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын талаар сурталчилж, хууль эрх зүйн зөвлөгөө өгч, гарын авлага тараасан.</p> <p>-“Хүүхдийн тусламжийн утас-108”-аас ирсэн нийт 86 дуудлага хүлээн авч, хамтарсан багийн хүрээнд гэр бүл, хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн, нөхцөл байдлын үнэлгээ хийж, аюулын зэргийг тодорхойлон, холбон зуучилж ажилласан.</p> <p>-2017 оны 2,3 сард 1-20 дугаар хороодын ажилчид, албан хаагчид, цэцэрлэгийн хүүхдүүдийн ар гэр, багш ажилчдын дунд “Хүүхдийн түлэгдэлт эцэг эхээс” нэртэй сургалтын хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хуулийн хүрээнд гарын авлага бэлтгэн тараасан.</p> <p>-2017 оны 04 дүгээр сараас 05 дугаар сард Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиар 29, 58, 71, 116-р сургуулийн 250 сурагчдад сургалт явууллаа.</p> <p>-2017 оны 03 дугаар сараас 05 дугаар сарын хооронд Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хүчирхийлэлд өртөж буй болон өртөх эрсдэлтэй иргэн, хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг иргэд, аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг сурталчлах багийг ГБХЗХХ-ийн</p>				100%

		<p>2017 оны 03 сарын 17 -ны өдрийн А/03 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан нийт сургалт, зөвлөгөөн, урьдчилан сэргийлэх ажлуудыг олон хэлбэрээр зохион байгуулан нийт 380 иргэнг хамруулан зохион байгуулсан. Хуулийн ерөнхий ойлголттой болгох, өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгаалах талаар мэдлэгтэй болгох зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдэвт сургалтыг 1-20 хорооны иргэдэд хорооны хамтарсан багийн гишүүдтэй хамтран зохион байгуулж, хороо тус бүр 45 буюу нийт 864 иргэдийг хамруулсан.</p> <p>-Дүүргийн Цагдаагийн I,II дугаар хэлтсээс гэмт хэрэгт өртсөн хүүхдийн ар гэрт нөхцөл байдлын үнэлгээ хийх, гэрч хохирогчоор оролцохтой холбоотой нийт 3 албан бичиг ирсний 3 хүүхдэд үйлчилгээ үзүүлэн, хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>-Цагдаагийн 1 хэлтэстэй хамтран дүүргийн 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг, байнга архи дан согтуурч, гэр орондоо түгшүүр төрүүлдэг иргэдийн гэр бүл, үр хүүхдүүдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчдэд хуулийн дагуу хариуцлага тооцохын зэрэгцээ тэдний зан үйлд нөлөөлөх сэтгэл засал, зөвлөгөө өгөх, эвсэг гэр бүлийг бий болгоход гэр бүлийн гишүүдтэй хамтран ажиллах зорилготой “Захидал” арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээнд нийт 46 иргэнийг хамруулж ар гэрээс нь нөхөртөө, эхнэртээ, аавдаа бичсэн захидлыг цагдаагийн албан хаагчидтай хамт хүргэн өгч, гарын бэлэг, захидалын хамт өглөө.</p>							
29	<p>НЗДҮАХ-ийн 4.5.6 дахь заалт; 2.2.6. Хорооны хамтарсан багуудын гишүүдийг чадавхжуулж, хараа хяналтгүй болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг шуурхай хамгаалах үйлчилгээг сайжруулна.</p>	<p>ШУТИС-тай жишиг хороо байгуулах гэрээ байгуулан ажиллана.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	НХХ	<p>ШУТИС, Хороодын ЗДАА</p>			
		<p>ШУТИС-тай хамтран хороодын нийгмийн ажилтны чадварыг сайжруулах, давтан сургах, мэргэшүүлэх, нийгмийн үйлчилгээний жишиг хороо бэлтгэж сургалтын үйл ажиллагааг хамтран зохион байгуулах зорилгоор дүүргийн ЗДТГ, ШУТИС-ын Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуультай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хамтын ажиллагааны №94 тоот гэрээ байгууллаа. Гэрээний дагуу БНСУ-ын Сөүл хотод 2017 оны 09-р сарын 18-наас 22-ны хооронд Нийгмийн ажилтаны сургалтад 20-р хорооны нийгмийн ажилтан Н.Мягмархүү оролцлоо.</p>				100%			
<b>2.3 Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг сайжруулна.</b>									
30	<p>НЗДҮАХ-ийн 4.1.13 дахь заалт; 2.3.1. “Насан туршийн боловсролын төв”-өөр олгох сургалтын чанар, хүртээмжийг сайжруулж, сургуульд суралцах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд сургалтыг онлайн хэлбэрээр явуулах үйл ажиллагааг дэмжин, шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана.</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, иргэдэд зориулан онлайн сургалт зохион байгуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	НХХ	<p>БХ, НТБТ</p>			
		<p>Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад 134 суралцагч хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 12 суралцагчид зориулан онлайн сургалт зохион байгуулав. Насан туршийн боловсролын төвөөр олгох сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 19-р хорооны 2 иргэн бага боловсролын шатанд онлайн аргаар, хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн онлайн аргаар 7 хоногт 4 цагаар хичээллэж, 128 цагийн онлайн сургалтад хамрагдсан байна.</p>				100%			
31		<p>Иргэдийн насан туршийн боловсролыг дэмжин гэр бүлийн, иргэний, ёс суртахууны, гоо зүйн, амьдрах ухааны боловсрол эзэмшүүлэх сургалтыг зохион</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт,</p>	100	НХХ	<p>НТБТ</p>			

		байгуулна.	хувиар			
		-Насан туршийн боловсролын төвд 9-р ангийн 2, 12-р ангийн 12 суралцагч онлайн хэлбэрийн сургалтад, хөгжлийн бэрхшээлтэй 4-9-р ангийн 12 суралцагч танхимын сургалтад тус тус хамрагдаж байна. -Нийгэмшүүлсэн циркийн сургалтад энэ хичээлийн жилд 25 суралцагч хамрагдаж байгаа нь өнгөрсөн жилийнхээс 8-аар нэмэгдсэн үр дүнтэй байна. -Гэр бүлийн боловсролын агуулгын хүрээнд зохион явуулсан сургалтад 18 удаа 306 иргэн, Иргэний боловсролын агуулгын хүрээнд 18 удаа 306 иргэн, Төлөвшил-ёс суртахууны боловсролын агуулгын хүрээнд 18 удаа 288 иргэн, Гоо зүйн-мэдрэмжийн боловсролын агуулгын хүрээнд 5 удаа 121 иргэн, нийт 9 удаа 190 иргэн хамрагдлаа.				90%
		Японы хүүхдийг ивээх сантай хамтран "Нийгэмшүүлсэн цирк" төсөл хэрэгжүүлнэ.	Төслийн хэрэгжилт, хувиар	100	НХХ	БХ, НТБТ
32		"Японы хүүхдийг ивээх сан"-гийн санхүүжилтээр "Нийгэмшүүлэх цирк"-ийн сургалтыг Насан туршийн боловсролын төвд 2 дахь жилдээ зохион байгуулж байна. "Нийгэмшүүлэх циркийн сургагч багш бэлтгэх" 2 удаагийн сургалтад тус төвөөс давхардсан тоогоор 10 багш хамрагдаж, сургагч багш болсон. Нийгэмшүүлэх цирк сургалтад 25 хүүхэд хамрагдан суралцсан. Нийгэмшүүлэх циркийн урлагаар дамжуулан хүүхдийг хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагаа явагдаж байдаг. Үүнд: Дээс, жонглёр, цацагт саваа, таваг, дамар гэх мэт маш олон хэрэгслүүд дээр ажиллаж, шинэ сонирхолтой тоглоомууд сурч байна. Нийгэмшүүлэх циркийн сургалтад хамрагдсанаар хүүхдүүд өөртөө итгэх итгэлтэй, зөв төлөвших, бусдад санаа бодлоо чөлөөтэй илэрхийлдэг болсон. Мөн хүүхдүүд найз нөхдийнхөө хүрээг тэлж чадсан. Сургалт тоглоомын аргаар явагдсан нь хүүхдүүдийн нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлсэн их үр дүнтэй сургалт болсон. -Нийгэмшүүлсэн циркээр дамжуулсан сургалтын үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд 2017 оны 05 дугаар сарын 11-нд "Боловсролд ээлтэй Сүхбаатар дүүрэг" үзүүлэх ажлын хүрээнд сурталчилсан нь дүүргийн төдийгүй Насан туршийн боловсролын түвшинд онцлох ажлаар шалгарлаа.				100%
33	2.3.2. Иргэдийн хөдөлмөр эрхлэх, бизнесээ эхлүүлэхэд нь туслах сургалтуудыг төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	Ажил мэргэжилгүй залуучуудад Адра олон улсын байгууллагатай хамтран үсчин, гоо сайхны сургалт зохион байгуулна.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо, хувиар	100	НХХ	БХ, НТБТ
		Үсчний сургалтын 3 удаа 72 иргэнд, гоо сайханы сургалтыг 1 удаа 21 иргэнд тус тус зохион байгуулсан.				100%
34	2.3.3. Мэргэжил олгох, давтан сургалтанд зорилтот бүлгийн иргэдийг хамруулна.	Ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэдийг хөдөлмөрийн зах зээлд бэлдэх зөвлөгөө мэдээллийн үйлчилгээнд хамруулж, ажил олгогчийн захиалгад тулгуурлан ажилд зуучилна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ХөХҮХ
		Дүүргийн 20 хороодод Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг танилцуулж, мэргэжил олгох				100%

		болон давтан сургалтын 42 мэргэжлийн чиглэлээр 20 хорооноос хэрэгцээний судалгаа авсан. Судалгаанд давхардсан тоогоор 1881 иргэд хамрагдсан. 2017 оны эхний 11 сарын байдлаар нийт 234 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгсөн бөгөөд үүнээс 198 иргэн ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэн байна. Ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэдэд ажил олгогчоос ирүүлсэн нийт 1447 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг сурталчилж 1004 иргэнийг ажлын байранд зуучилсны 1117 иргэн байнгын ажлын байранд орсон байна.						
		Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад мэргэжлээ хэрхэн сонгох, ажил олоход хүндрэлтэй иргэдэд бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээлэл, хөдөлмөрийн харилцааны талаарх зөвлөгөө өгч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	HXX	ХөХҮХ		
35		<p>Ганцаарчилсан мэдээлэл, зөвлөгөөг 234 иргэнд өгч Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сангийн Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний модульд бүртгэсэн. Мэргэжлийн сургалтын талаар 35, гадаад улсад ажиллах хүсэлтэй 43, ажилгүй 156 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн. Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг эрх бүхий сургалтыг гүйцэтгүүлэхээр 4 сургалтын төвийг сонгон шалгаруулж, 900 иргэнд бүлгээр Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>ЕБС-ийн төгсөх ангийн 3 сурагчид эцэг, эхийн хамт мэргэжлээ хэрхэн сонгох мэдээ, мэдээлэл, зөвлөгөө өгсөн. Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг эрх бүхий сургалтын байгууллага гүйцэтгэх бөгөөд ХХҮЕГазар дээрх эрх бүхий сургалтын төвийг сонгон шалгаруулсан. Одоогоор ХХҮЕГ-аас сургалтын төвүүд хэрхэн зөвлөгөө, мэдээлэл өгөх талаар удирдамж боловсруулж байна.</p> <p>-Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс хамтран 05 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аяныг ерөнхий боловсролын нийт 46 сургуульд зохион байгуулж, 400 гаруй хүүхдэд мэргэжил сонголтын зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.</p> <p>-Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сангийн Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ модульд 120 иргэнд ганцаарчилсан мэдээлэл зөвлөгөө өгсөн. Мэргэжлийн сургалтын талаар 15, гадаад улсад ажиллах хүсэлтэй 33, ажилгүй 72 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн.</p> <p>-Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн 3 сурагчид эцэг, эхийн хамт мэргэжлээ хэрхэн сонгох, ажил олоход хүндрэлтэй 6 иргэнд ганцаарчилсан хэлбэрээр хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээлэл, хөдөлмөрийн харилцааны талаарх зөвлөгөө өгсөн.</p>						100%
36	2.3.5. Сургалтын орчинг сайжруулах чиглэлээр олон улсын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Дэлхийн зөн олон улсын байгууллага, өвсний үндэс хөтөлбөрүүдтэй хамтран төсөл хэрэгжүүлэн ажиллана.	Төсөл боловсруулах ажлын явц, хувиар	100	HXX	ОУБ		



		<p>-Япон улсын засгийн газрын “Өвсний үндэс” буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн санхүүжилтээр 17 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгч, аудитыг сонгон шалгаруулах тухай дүүргийн Засаг даргын 2017 оны А/48, А/66 дугаар захирамжийн дагуу Ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав. Засварын ажлын зургийг Измон ХХК гүйцэтгэсэн. Зурагтай холбоотой 2 удаагийн тодруулгыг хөтөлбөрийн газарт хүргүүлсэн. Тайваны хүүхэд гэр бүлийг дэмжих санд 25, 116 дугаар тусгай сургуульд тайвшруулах өрөө, лингафоны танхим байгуулах тухай төсөл боловсруулж, хамтран ажиллах саналаа хүргүүлсэнээр 25 дугаар тусгай сургуулийн тайвшруулах өрөөнд 4 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар тохижилт хийлгэлээ.</p> <p>Дэлхийн зөн олон улсын байгууллагын санхүүжилтээр 248, 166 дугаар цэцэрлэгийн салбар бүлэгт тус бүр 2 гэр шийдвэрлүүлээ.</p> <p>Цэцэрлэг: Дэлхийн банкны санхүүжилтээр “Цэвэр агаар төсөл”-төслөөс агаарын бохирдолтой ихтэй 1,2-р бүсэд байрладаг 17 цэцэрлэгт /51, 69, 150, 234, 130, 109, 17, 75, 166, 171, 175, 186, 205, 225, 216, 217, 248 / 89 ш агаар цэвэршүүлэгч хүлээлгэн өгснөөр томуу болон томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй ажил боллоо.</p> <p>Сургууль: Дэлхийн банкны зээлийн тусламжаар БСШУЯ-наас хэрэгжүүлж буй Боловсролын чанарын шинэчлэл төслийн “СУРГУУЛИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР”-ийн 3 шатанд дүүргийн төрийн өмчийн 34 /давхардсан тоо/ сургуулийн 36 төсөл амжилттай хэрэгжиж байна. Төсөл хэрэгжсэнээр: Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, сургуулийн хөтөлбөр амжилттай хэрэгжихэд, сургууль, орон нутаг, эцэг эх, сурагчдын хамтын ажиллагаа, оролцоо сайжирч, сурагчид амьдрах ухаанд суралцах, асуудал дэвшүүлэх, түүнийгээ шийдвэрлэхийн төлөө хамтран ажилладаг соёл бий болоход, суралцагчдын суралцах идэвх оролцоо, агуулга, хүртээмжид эерэгээр нөлөөлөхүйц “Хүүхэд хөгжлийн хөтөлбөр”-ийн шинэ жишиг гарахад тус дөхөм болно.</p>	100%			
<b>2.4 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.</b>						
37	НЗДҮАХ-ийн 4.1.18 дахь заалт; 2.4.1. Хүүхэд, залуучуудын номын санг шинээр байгуулна.	<p>58 дугаар сургуулийн дэргэд байгуулагдсан дүүргийн номын сангийн үйл ажиллагааг сайжруулна.</p> <p>-Алслагдсан хороодын хүүхэд багачуудад номын сангийн үйл ажиллагааг ойртуулах зорилгоор дүүргийн номын санг 15 дугаар хорооны нутаг дэвсгэр 58 дугаар сургуулийн дэргэд байгуулсан. Тус номын санд 2017 оны байдлаар давхардсан тоогоор 1300 гаруй хүүхэд үйлчлүүлсэн байна. Номын сангийн байрны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 2017 оны 8 дугаар сард урсгал засварын ажлыг 9,8 сая төгрөгийн санхүүжилтээр “Бил хаус” ХХК хийж гүйцэтгэлээ.</p> <p>-Тайваны хүүхэд гэр бүлийг дэмжих сангийн монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран хүүхэд залуучуудад чөлөөт цагаа өнгөрүүлэх тав тухтай орчинг бүрдүүлж, хүүхэд багачуудын ном унших сонирхолыг нэмэгдүүлэх зорилгоор “Номын өргөө” төслийг хэрэгжүүлэхээр дүүргийн 2,11 дүгээр хороодын нутаг дэвсгэрт байрлах 31, 131 дүгээр сургуулиудын номын санг тохижуулах төсөл боловсруулан 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Тайваны гэр бүлийг дэмжих санд хүргүүлсэн.</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТГХШХ	НХХ  100%

38	НЗДҮАХ-ийн 4.4.6 дахь заалт; 2.4.2. Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлэн дэмжинэ.	Өсвөрийн шигшээ багийн спортын 10 төрлөөр хичээллүүлж, тэмцээн уралдаанд оролцох нөхцөлөөр хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	БТСХ
		<p>-Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг спортын 9 төрөл /Шатар, зуун буудалт даам, сагсан бөмбөг, хөл бөмбөг, чөлөөт бөх, ширээний теннис, жүдо бөх, дугуй, тэшүүр/-ээр нийт өсвөрийн 300 тамирчин хичээллэж, спортын 13 төрлөөр нийт 66 дугуйланд 2500 гаруй хүүхэд хамрагдан хичээллэж байна.</p> <p>Өсвөрийн шигшээ багийн материаллаг баазыг бэхжүүлэх зорилгоор чөлөөт бөхийн танхимд 15 сая төгрөгийн хэрэгсэл авч, бокс, дугуйн 2 баг тамирчидад тус бүр 300 000 төгрөгийн хувцас хэрэглэл олгосон.</p> <p>-Дүүргийн өсвөр үеийн аварга шалгаруулах Хонхот бөмбөгийн тэмцээн 2017.03.06-нд Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р тусгай сургуулийн спорт зааланд зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 16 багийн 60 гаруй тамирчид 2 насны ангиллаар өрсөлдөж тэргүүн байрт шалгарсан баг тамирчид Өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналаар шагнав.</p> <p>-Дүүргийн Засаг даргын 2017.03.22-ны өдрийн А/92 дугаар захирамжаар өсвөр үеийн сагсан бөмбөгийн "Алтан од" охидын баг тамирчид Оросын холбооны улсын Пермь хотод 2017 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс 23-ны өдрүүдэд зохион байгуулагдах Олон Улсын Кэс Баскет шигшээ тэмцээнд оролцоход замын зардалд 8 000 000 төгрөг шийдвэрлэсэн.</p> <p>-Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн ширээний теннисний баг тамирчид 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 22-ны өдрүүдэд зохион байгуулагдах MONGOLIA CUP Олон Улсын тэмцээнд оролцоход дүүргийн Засаг даргын 2017.04.19-ний өдрийн А/123 дугаар захирамжаар 500 000 төгрөг шийдвэрлэсэн.</p> <p>-Дүүргийн Засаг даргын дэргэдэх Таеквондогийн өсвөрийн шигшээ Эхлэл клубын баг тамирчид 2017.05.27--ны өдөр улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахад 450 000 төгрөгийн дэмжлэг үзүүлээ.</p> <p>-Тусгай сургалттай 29 дүгээр сургуулийн багш, сурагчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Монгол туургатны Олон Улсын наадамд 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 10-ны өдрүүдэд оролцоход дүүргийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын А/201 дүгээр захирамжаар 570000 төгрөг шийдвэрлэсэн.</p>				100%
39	2.4.6. Хүүхдийн аюулгүй орчны зураглал гаргаж сургууль, цэцэрлэг бүрт хэрэгжүүлнэ.	Хүүхдийн аюулгүй орчны зураглал гаргана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ТГХШХ БХ
		Ерөнхий боловсролыг сургууль, цэцэрлэгийн 47 захирал, 67 эрхлэгч нарын үр дүнгийн гэрээнд хүүхдийн аюулгүй орчны зураглал гаргах ажлыг тусган ажиллаж байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүйн зураглалыг хийх зөвлөх үйлчилгээ авахаар төсвийг боловсруулсан. Төрийн өмчийн 33 цэцэрлэгийн 219 анги, дотор талбайд 567 камер суурилуулан ажиллуулснаар орчны осол, аюулгүй байдлыг бүрэн хянаж, эрсдэлээс урьдчилан				100%

		сэргийлэх нөхцөл бүрдүүлээд байна.				
<b>2.5 Хүүхэд, эцэг эх, багшийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.</b>						
40	НЗДҮАХ-ийн 4.1.10 дахь заалт; 2.5.1. Цэцэрлэгт “Эцэг эхэд зөвлөгөө өгөх төв” байгуулж, эцэг эхчүүдийг хүүхэдтэй ажиллах арга зүйд сургах ажлыг эхлүүлнэ.	Дүүргийн "Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төв"-ийг 1 дүгээр цэцэрлэгийн дэргэд байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	БХ
		Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төвийг нийт 65 цэцэрлэгээс байгуулсан 8 тусдаа өрөөтэй 10, Заах аргын нэгдлийн өрөөтэй хамт 28 цэцэрлэг, огт байгуулаагүй 27 цэцэрлэг тус тус байна. Биелэлт 41%-тай байна. Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан 2333 эцэг, эхэд зөвлөгөө, 3766 эцэг, эхэд сургалт зохион байгуулан, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үр дүнтэй шийдэл боллоо. Мөн 149, 150, 54-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн эцэг эхчүүдэд “Танай хүүхэд сургуульд элсэхэд бэлэн үү” сэдэвт сургалт-хэлэлцүүлэг зохион байгуулж, сургуульд хүүхдээ бэлтгэх талаар зөвлөн тусаллаа.				100%
41	НЗДҮАХ-ийн 4.5.4 дахь заалт; 2.5.4. Өсвөр насны хүүхдүүдийн Эрүүл мэндийн боловсролд анхаарч халдварт өвчин, хорт зуршлаас урьдчилан сэргийлж ажиллана.	Өсвөр насны хүүхэд, залуучуудыг халдварт өвчин болон хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа явуулж, эрүүл мэндийг боловсролыг сайжруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ЭМТ
		-Өсвөр үед ээлтэй орчин бүрдүүлэн, ЭМТ-ийн Өсвөр үеийн кабинетыг тохижуулан, бүрэн орон тоогоор ажиллуулж, сургалт сурталчилгааны 7 загвар боловсруулав. Өсвөр үеийн кабинетаар 362 хүүхэд эрүүл мэндийн үзлэгт хамрагдсанаас 263 хүүхдийг эмчилгээнд хамруулж, 88,9 % буюу 234 хүүхдийг эрүүлжүүлсэн. -Япон улсын Жайка байгууллагын дэмжлэгээр 2015-2019 онд хэрэгжүүлэх "Өсвөр үеийнхнийг эрүүл аж төрөх дадалд суралцуулах тогтвортой систем байгуулах" төслийн хүрээнд ЭМТ-ийн өсвөр үеийн кабинет, НЭМГ хамтран 71-р сургуулийн 35 идэвхтэн сурагчид “Бэлгийн хоёрдогч шинж буюу бэлгийн бойжилт”, “Бэлгийн замын халдварт өвчин, ДОХ Сарын тэмдэг, жирэмслэлт, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх аргууд” сэдвээр сургалт зохион байгуулсан. -Өсвөр үе залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр дүүргийн ЗДТГ, ГБХЗХХ, Цагдаагийн 1 дүгээр хэлтэс хамтран ЕБС, их, дээд сургуулиудад 122 удаа сургалт зохион байгуулж, 2451 хүн хамруулсан. -Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор улирал бүр ЕБС, цэцэрлэгийн эмч нартай уулзалт зохион байгуулж хэвшсэнээр 4 удаагийн уулзалтаар 70 эмчийг цаг үеийн мэдээллээр хангаж, мэдлэгийг дээшлүүлсэн. -“Өсвөр үеийнхний дунд мансууруулах болон сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ” судалгаанд дүүргийн 7 ЕБС-ийн 12-18 насны 800 хүүхдийг хамруулсан. Судалгааны үр дүнг нийслэлийн Эрүүл мэндийн газрын болон, “Эх хүүхдийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлье” Онол практикийн эрдэм шинжилгээний бага хуралд илтгэл тавин хэлэлцүүлж, тус тус II байр эзэлсэн. -ЭМЯ, Люксембургийн Засгийн газар хамтран хэрэгжүүлж байгаа “Зүрх судасны төв, Эх				100%

		<p>хүүхдийн эрүүл мэнд, цахим өргөжил МОН 005” төслийн хүрээнд Шинэ нийгмийн эрүүл мэнд ТББ, СБЭМТ-тэй хамтран 58-р цогцолбор сургуулийн сурагчдын дунд А бүлгийн бетта стрептококкын эсрэг төрөгч илрүүлэх хурдавчилсан шинжилгээ, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг зохион байгуулсан. Үзлэг шинжилгээнд нийт 2968 сурагчдын 2781 буюу 93,7%-ийг хамруулж, 291 буюу 10,5%-д стрептококкын эсрэг төрөгч илэрсний 96,6% буюу 281 хүүхдэд зүрх судас, чих хамар хоолой, хүүхдийн эмч нар үзлэг хийсэн.</p> <p>-Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйчилгээний чанарыг сайжруулахад салбар дундын хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдөр “Өсвөр үеийн эрүүл мэндийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” уулзалт зөвлөгөөн зохион байгуулж, ЭМТ, ЕБС-ийн эмч мэргэжилтэн 41 хүн оролцсон. Тус зөвлөгөөнөөр дүүргийн өсвөр үеийн эрүүл мэнд, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл өгч, зөвлөмж гаргасан.</p> <p>- Дүүргийн өсвөр үеийнхнийг эрүүл аж төрөх дадалд суралцуулахад чиглэсэн тогтвортой систем бэхжүүлэх төслийн хүрээнд АШУҮИС-ийн 30 оюутан, 71, 35-р сургуулийн 38 сурагчийг үе тэнгийн сургагчаар бэлтгэснээр “Бид үе тэнгийнхэн” сонин хэвлүүлсэн. 2017 оны 6,7,8 дугаар сард АШУҮИС-ийн 14 оюутан, 71 дүгээр сургуулийн 23 сурагч, 9 эмч, багш ахисан шатны сургалтанд хамрагдсан. 2017 оны 05 дугаар сард 35,58-р сургуулийн зохицуулагчийн сургалтад удирдлага, эмч, нийгмийн ажилтан, багш нарыг хамруулсан. Төслийн хэрэгжилтийн дунд шатны үнэлгээгээр үр дүн сайн байсан тул төслийг 35-р сургуульд хэрэгжүүлэхээр зохион байгуулалт, сургагч багш бэлтгэх ажлууд хийгдсэн.</p> <p>-Нийслэлийн Засаг даргын А/577, ЭМС-ын А346, дүүргийн Засаг даргын 1/2775 дугаар зөвлөмж, дүүргийн Засаг даргын уриалга, ЭМТ-ийн даргын А/61 дугаар тушаалын дагуу НХХ, БХ, ЭМТ хамтран “ТТТӨ-ний эмнэлзүйн шинж тэмдэг, урьдчилан сэргийлэлт”, “Цэгэн массаж хийх зөвлөмж”, “Гарын ариун цэвэр”, Ханиад томуугаас сэргийлье” сэдвээр харьяа 27 ерөнхий боловсролын сургуулийн 7870 сурагч, эрүүл мэндийн сайн дурын 47 туслагчдад томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг хийн, зөвлөгөө өгч 123 удаагийн сургалт зохион байгуулж, цэгэн массаж хийж хэвшүүлсэн.</p> <p>-ЭМТ-ийн Өсвөр үеийн кабинет, “Гүн Мэдрэмж” ӨЭМТ-тэй хамтран 58-р сургууль дээр Хөвгүүдэд зориулж “Урьдчилан сэргийлэх нь эмчлэхээс чухал өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр өсвөр үеийн кабинетын эмч, сувилагч нар “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх талаар сургалт явуулж, 10-12 дугаар ангийн нийт 89 хөвгүүдийн өсөлт хөгжлийн үнэлгээ, назофарангитийн үзлэг тус тус хийсэн. Өөрчлөлттэй илэрсэн 7 хүүхдийг дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлэн бүрэн эмчлэгдсэн. “Өсвөр үеийнхний архи, тамхи, мансууруулах, сэтгэц идэвхт бодисын хэрэглээ, хор уршиг” сургалтыг ахлах ангийн нийт 39 хүүхдэд зохион байгуулсан.</p> <p>-Өсвөр үе, хүүхэд залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилгоор дүүргийн Засаг даргын 2017.09.15-ны өдрийн А/304 дүгээр захирамжаар Өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих Эрүүл залуус 2 сарын аян зарлалаа. Аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн ахлах 11,12 дугаар ангийн хамрагдвал зохих 4800 хүүхдээс 1,3,2,4,16,31,71 дүгээр сургуулийн 1007 сурагчдыг дотор, эмэгтэйчүүд, сүрьеэ, БЗДХ, чих хамар хоолойн эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулаад байна. Үзлэгээр сүрьеэгийн</p>	
--	--	--	--

		сэжигтэй 5 тохиолдол илрүүлж, эмчилгээнд хамрууллаа.				
<b>2.6 Соёл, урлагийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.</b>						
42	НЗДҮАХ-ийн 4.3.1 дахь заалт; 2.6.1. Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд, залуучууд, иргэдийн авьяасыг нээн хөгжүүлж, урлаг соёлын үйл ажиллагааг дэмжинэ.	Дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгүүдийн сурагч, хүүхэд, багачуудын авьяас чадварыг нээн хөгжүүлэх, иргэдэд соёлын боловсрол олгоно.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	БХ
		<p>-Дүүргийн хэмжээнд “Уран жиргээ-2017” уралдааны шалгаруулалтыг 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулж, 4 насны ангилалд нийт 153 хүүхэд оролцсоноос насны ангилал тус бүрт эхний гурван байр эзэлсэн нийт 12 хүүхэд Монголын хүүхдийн ордонд зохион байгуулагдсан нийслэлийн шатны шалгаруулалтад оролцож, цэцэрлэгийн насны ангилалд дүүргийн 69 дүгээр цэцэрлэгийн Б.Бүжинлхам 3 дугаар байр, Б.Болорчимэг тусгай байранд тус тус шалгарсан. Тус уралдаанд 1,214,000 төгрөг зарцуулсан байна.</p> <p>-Дүүргийн ЗДТГ, Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний холбоо ТББ-тай хамтран тусгай сургалттай 25, 29, 116 дугаар сургуулийн сурагчдын дунд “Бид өөрчлөгчид” гар зургийн уралдаан зохион байгууллаа. Уралдаанд нийт 30 гаруй хүүхдийн бүтээл ирснээс эхний 4 байрт шалгарсан хүүхдүүдэд өргөмжлөл, мөнгөн шагнал, бүтээлээ ирүүлсэн хүүхэд бүрт хүүхдийн баярын гарын бэлэг гардуулав.</p> <p>-Нийслэлийн Соёл урлагийн газартай хамтран хүүхдүүдэд сонгодог хөгжмийн боловсрол олгох зорилгоор 2017 оны 6 дугаар сарын 03-ны өдөр АНУ-ын Филадельфийн симфони найрал хөгжмийн чуулгын утсан хөгжмийн дөрвөлийн тоглолтыг 29 дүгээр сургуулийн 31 сурагчид, 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдөр БНХАУ-ын Шинжан Уйгарын Карамай хотын соёл урлагийг иргэдэд сурталчилан таниулах зорилгоор Улаанбаатар хотын чуулгын уран бүтээлчидтэй хамтарсан тоглолтыг дүүргийн 7,8 дугаар хорооны 50 иргэнд, 8 дугаар сарын 19-ний өдрийн Япон Улсын үндэсний урлагийн тоглолтыг 20 иргэнд тус тус үзүүлсэн.</p> <p>-Дүүргийн Соёлын өвийг өвлөн тээгчдийн бүртгэл, судалгааг гаргаж, нийслэлийн Соёл урлагийн газарт хүргүүлээ.</p> <p>-Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит Хүүхдийн найрал дууны уралдааны дүүргийн шалгаруулалт 2017 оны 10 сарын 11-ний өдөр зохион байгууллаа.</p>				100%
43	НЗДҮАХ-ийн 1.4.5 дахь заалт; 2.6.2. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хөшөө, дурсгалт газруудын соёлын аялал жуулчлалын ажлыг дэмжинэ.	Нутаг дэвсгэрт байрлах хөшөө дурсгалт газруудын арчлалт хамгаалалтыг сайжруулах хяналт, шалгалт хийж, холбогдох газартай хамтран угаалга, цэвэрлэгээний ажил зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	НСУГ
		<p>-Цэргийн нэрт зүтгэлтэн, Батлан хамгаалах яамны нэгдүгээр орлогч сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга асан дэслэгч, генерал Чойдонгийн Пүрэвдоржийн мэндэлсний 80 жилийн ойд зориулж, 5 дугаар хорооны 5 дугаар байрны хананд хүндэтгэлийн самбар байршуулах асуудлыг 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан.</p> <p>-Улсын нийслэлд хөшөө дурсгал хүндэтгэлийн самбар байрлуулах журамд өөрчлөлт,</p>				100%

		<p>шинэчлэлт оруулахтай холбогдуулан нийслэлийн Хот төлөвлөлт, Ерөнхий төлөвлөгөөний газарт 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 9/770 дугаар албан тоотор санал боловсруулан хүргүүлсэн.</p> <p>-Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын дурсгал бүхий 51 хөшөө баримал, байшин барилга, түүх соёлын дурсгалт газруудын судалгааг нийслэлийн Аялал жуулчлалын газарт хүргүүллээ. Мөн сэргээн засварлах шаардлагатай 4 хөшөө, барималын судалгааг нийслэлийн Тохижилт, хог хаягдлын удирлагын хэлтэст хүргүүлсэн.</p> <p>-Хөшөө дурсгалыг угааж цэвэрлүүлэх ажлын дагуу дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 3 хөшөө, барималыг Хот тохижилтын газарт уламжлан угаалгаж, 8 хөшөөнд маск зүүлгэсэн байсныг Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ болон хорооны ажлын албатай хамтран авч, цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулсан.</p> <p>-Дүүргийн ЗДТГ-ын 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар 2017 оны 04 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хөшөө дурсгалыг тоолж, бүртгэлжүүлэв.</p>			
<b>Гурав. Амьдрахад таатай сүхбаатар дүүрэг</b>					
<b>3.1 Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.</b>					
		2, 7 дугаар хорооны цогцолбор барилгын ажлыг эхлүүлнэ.	Ажлын явц, хувиар	50	ТГХШХ
44	НЗДҮАХ-ийн 5.4.11 дахь заалт; 3.1.1. Төрийн үйлчилгээг иргэдэд нэг цэгээр үзүүлэх хороо, ӨЭМТ, цагдаагийн хэсгийн цогцолбор байрыг шинээр барина.	<p>2 дугаар хорооны цогцолбор барилга: Дүүргийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Ажлын хэсэг байгуулах А/154 дүгээр захирамжийн дагуу 2 дугаар хорооны Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн цогцолбор барилгын ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдан барилгын ажилтай холбоотойгоор 2017.05.11-ний өдрөөс 2017.05.29-ний өдрийн хооронд газар дээр 3 удаа ажиллаж, иргэдэд болон холбогдох байгууллагуудад мэдээлэл өгч ажилласан. Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр газрын асуудлыг цуцалсан тул цогцолбор барилгын ажил зогссон. Одоогоор нийслэлийн газрын албанаас санал болгосон байршлууд дээр 1а байрны зүүн талын газар дээр иргэнтэй зөвшилцөх түвшинд ажиллаж байна.</p> <p>7 дугаар хорооны цогцолбор барилга: Дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийслэлийн Засаг даргын 2013 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/1051 дүгээр захирамжаар дүүргийн Засаг даргын тТамгын газарт олгосон 7 дугаар хорооны цогцолбор барилга барих газарт Өсөх таван эрдэнэ ХХК нь барилгын суурийн байгууламж цутгасан бөгөөд суурийг Монгол улсын Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бБарилга, Архитектурын сругууль, Оношлогоо, зураг төсөл, судалгааны Реконстракшн төвийн 2015 оны 11 дүгээр сарын экспертизийн дүгнэлтээр ашиглах боломжгүй нь тогтоогдсон, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 001/ХТ2017/00704 дүгээр тогтоолоор барилгын ажил үргэлжлүүлэлхийг тус дүүргийн Засаг дагын Тамгын газарт даалгах тцхай нэхэмжлэлийн шаардлагагы хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тул Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагааны 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 01 дүгээр мэдэгдэл, дүүргийн Засаг даргын 2017 оны 08 дугаар</p>		40%	

		сарын 01-ний өдрийн 1/1866 мэдэгдэл, дүүргийн Газрын албаны 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 170905/001 дугаар шаардах хуудас зэргийг хүргүүлсэн боловч Өсөх таван эрдэнэ ХХК нь газар чөлөөлөөгүй тул дүүргийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн Газар албадан чөлөөлөх тухай А/354 дүгээр захирамж гарган хуулийн хүрээнд газар чөлөөлөтийн алыг хэрэгжүүлж байна.				
45	НЗДҮАХ-ийн 5.4.4 дахь заалт; 3.1.3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, хяналтын камерыг нэмэгдүүлнэ.	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлэг, камерын засвар үйлчилгээг хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ	100%
		Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбай, орон сууц, гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлгийн нэг дүгээр бүс 1-8 дугаар хороог “Гэрэлтүүлэг чимэглэл” ХХК хариуцан ажилладаг гэрэлтүүлгийн асалтын дундаж 97.5%, 2 дугаар бүс “Би Эм Жи Эл” ХХК хариуцан ажилладаг гэрэлтүүлгийн асалт 96,8%-тай, 3 дугаар бүсэд “ДМТМ” ХХК хариуцан ажилладаг гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлгийн асалтын 98.3%-тай байна. 2017 онд дүүргийн гэр хороололд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 245 ширхэг гэрэл, Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1130 ширхэг гэрэлтүүлгийг шинээр хийлээ. Дүүргийн нутаг дэвсгэр дээрх 124 байршлын 276 камерын ашиглалтыг “Инно Солюшн” ХХК хариуцан ажиллаж байна.				
46		Зөвшөөрөлгүй рекламн самбарыг буулгаж, хяналт тавьж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ	100%
		2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдаанаар шинэчлэгдэн батлагдсан журмын дагуу дүүргийн нутаг дэвсгэрт шинээр гадна зар сурталчилгааны байгууламж байгуулах, хугацааг сунгах зөвшөөрлийг Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас өгөхөөр болоод байна. НЗАА-аас өгсөн үүрэг даалгаврын дагуу дүүргийн нутаг дэвсгэрт байгаа гадна зар сурталчилгааны самбарын судалгааг гарган мэдээллээр ханган ажиллаж байна.				
47	НЗДҮАХ-ийн 3.3.3, 3.3.4 дахь заалт: 3.1.5. Иргэдийн саналын дагуу нийтийн эзэмшлийн талбай дахь авто зогсоол, ногоон байгууламж, сул шороон хучилт, явган хүний зам, гүүр, шат, худаг усан сангийн хэмжээг нэмэгдүүлнэ.	Дүүргийн хөрөнгө оруулалтаар ногоон байгууламж, сул шороон хучилт, явган шат, замын ажлыг хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТГХШХ	СТСХ ТНААХ, ХААА
		Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Дүүргийн 2017 оны төсөв батлах тухай 12, 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Дүүргийн 2017 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 02 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын А/340, дүүргийн Засаг даргын А/334 дүгээр захирамжийн дагуу тус тус 5 байршилд орц дундын ногоон байгууламж, 31 байршилд сул шороон талбайн хучилт, 3 байршилд ундны усны гүний худаг, 6 байршилд явган хүний гүүр, 10 байршилд явган хүний зам, 8 байршилд явган хүний шат, 1 байршилд ус зайлуулах хоолойн ажлын нийт 64 байршилд 706,364.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээний худалдан авалтын захиалгыг боловсруулж, дүүргийн Засаг				

		<p>даргын Тамгын газрын 2017.03.27-ны өдрийн 6/654, 2017.05.30-ны өдрийн 6/1318, 2017.06.27-ны өдрийн 6/1565, 6/1566, 2017.10.13-ны өдрийн 6/2826 дугаар албан тоотуудаар ХААА-нд шилжүүлсэн.</p> <p>Үүнээс дүүргийн ХАААлба 26 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2017.04.27-ны өдрөөс 2017.11.13-ны өдрийн хооронд зохион байгуулж, 1 төсөл, арга хэмжээ тендерийн зохион байгуулалтын түвшинд хэрэгжиж байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газар 24 төсөл, арга хэмжээг 2017.06.05-ний өдрөөс 2017.11.29-ний өдрийн хооронд хяналт тавин ажиллаж, гэрээний хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр батлагдсан 2 төсөл, арга хэмжээнд нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар хяналт тавин ажиллаж, гэрээний хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан</p> <p>Тохижилтын 17,301.90 мянган төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжихээр төлөвлөгдөж байна.</p>				
48	3.1.6. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын чанар, үр ашгийг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажиллана.	Чанар, үр ашгийг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалт, засвар үйлчилгээ хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ	90%
		<p>Дүүргийн 1-20 дугаар хороонд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 143 байршлын 120554,34 м2 талбайн 149 сүүдрэвч, 4405м2 хүүхдийн тоглоом , 380 ширхэг чийрэгжүүлэлтийн төхөөрөмж, 801 ширхэг сандал, 425 ширхэг хогийн сав, 16786м2 спорт талбайн тохижилт бүтээн байгуулалтын ажлын цэвэрлэгээ засвар үйлчилгээг хийлгэхээр 10 аж ахуйн нэгж байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.Үүнд: 1 дүгээр хороо-Цац толгойн төгөл ХХК, 2 дугаар хороо-Их дуурсах өртөө ХХК, 3, 4 дүгээр хороо-Сафира ХХК, 5 дугаар хороо-Данисти маунт ХХК, 6, 7 дугаар хороо-Ти Жи Жи сервис ХХК, 8 дугаар хороо-Дорнын сайхан тал ХХК, 10, 11,12, 13 дугаар хороо-Могод Жи Би ХХК, 14,15, 16, 17 дугаар хороо Эрхэт гүн бюлдинг ХХК, 18 дугаар ЧЭМЧ ХХК, 19, 20 дугаар хороо Анута дөлгөөн ХХК хийж гүйцэтгэж байна.</p>				
49	3.1.8. Сууц өмчлөгчдийн холбоодын хариуцлагыг өндөржүүлж, үйл ажиллагааг дэмжиж ажиллана.	Сууц өмчлөгчдийн холбоод болон шилдэг тохижилттой иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулж урамшуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ	100%
		<p>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, барилга хот байгуулалтын яамны бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2017 оны 1 дүгээр сарын 23-ний өдрөөс 2017 оны 2 дугаар сарын 23-ны өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 29 сууц өмчлөгчдийн холбоонд хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг сууц өмчлөгчдийн холбооны захирлуудад шинжилгээ судалгаа сургалт хэрэглэгч төвтэй хамтран сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн орчин, өнөөгийн байдал сэдэвт сургалт зохион байгууллаа. Дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг сууц өмчлөгчдийн холбоодын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнд дүүргийн Засаг даргын</p>				



		орлогч Ц.Шижир, Төлөвлөлт гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтсийн дарга М.Бямбасүрэн, Онцгой байдлын хэлтсийн гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, хошууч С. Хатанболд, цагдаагийн нэгдүгээр хэлтсийн урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах Б. Саруултуяа, 70 сууц өмчлөгчдийн холбооны удирдах ажилтан нар оролцож ажлын уялдаа холбоогоо сайжруулж ажиллах талаар ярилцаж сууц өмчлөгчдийн холбоотой уялдаатай ажиллах байгууллагуудын талаар мэдээлэл өглөө.				
50	3.1.9. Гэр хорооллын гудамж, замыг тохижуулах ажлыг тухайн хорооны иргэдийн саналыг авч хэрэгжүүлнэ.	Иргэдийн саналд үндэслэн хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийг боловсруулна.	Зураг төсвийг боловсруулах ажлын явц, хувиар	100	ТГХШХ	
		Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Дүүргийн 2017 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 02 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын А/224, А/344, А/337 дугаар захирамжийн дагуу 91 баршилд зураг төсөв шинээр хийх болон шинэчлэх нийт 202,791.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй зөвлөх үйлчилгээний 8 төсөл, арга хэмжээний худалдан авалтын захиалгыг боловсруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2017.07.24-ний өдрийн 6/1730, 2017.10.16-ны өдрийн 6/2839, 2017.10.20-ны өдрийн 6/2900, 2017.11.27-ны өдрийн 6/3295 дугаар албан тоотуудаар ХААА-нд шилжүүлсэн. Үүнээс дүүргийн ХАААлба 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2017.06.28-ны өдрөөс 2017.11.28-ны өдрийн хооронд зохион байгуулж, 2 төсөл, арга хэмжээ тендерийн зохион байгуулалтын түвшинд хэрэгжиж байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газар 2017.08.14-ний өдрөөс 2017.09.14-ний өдрийн хооронд 4 төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан. 2 төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.				100%
51	3.1.11. Тохижилт бүтээн байгуулалт хийх ажлын байршлуудыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулна.	Газартай холбоотой хөрөнгө оруулалтын ажлуудыг дараа оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, батлуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТГХШХ	ГА
		Хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд 8-р хорооны нутаг дэвсгэр арслантай гүүрнээс Орчлон сургуулийн зүүн урд талын гүүр хүртэл 1,16га газарт тохижилтын ажил, 9-р хорооны Ногоон нуурын цэцэрлэгт хүрээлэнгийн 6,2 га газарт цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, 20-р хороо сэлхийн 3-р гудамжинд /Иргэдийн оролцоотойгоор/ 0,05 га газарт худгийн тохижилт, 15-р хороо Архустайн зусланд 0,06 га газарт худгийн тохижилт, 15-20 хороодын нутаг дэвсгэрт 5.0 га газарт спорт талбай 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулсан. 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг 12 сард батлуулна.				70%
<b>3.2 Иргэдийн аюулгүй байдлыг хангаж, хэв журмыг сахиулна.</b>						
52	НЗДҮАХ-ийн 5.4.7; 5.4.10 дахь заалт; 3.2.1. Гэнэтийн гамшиг осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлнэ.	Зуслангийн бүсэд гал унтраах аврах анги байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	30	ТГХШХ	ОБХ
		Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хорооны Хуурай мухарын аманд Нийслэлийн төсвийн хөрөнгө				70%

		оруулалтаар гал түймэр унтраах, аврах ангийн барилгын ажилд Жи-Жи-Ай ХХК шалгарч барилгын ажлыг 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлүүлэн суурийн болон 1,2 давхарын цутгалт хийгдэн барилгын ажил 50 хувьтай явагдаж байна. 2017 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 1 тэрбум төгрөг батлагдсан төсвийн ажил 100 хувь хийгдсэн байна.				
		Гэнэтийн гамшиг, осол, аюулт үзэгдлийн эрэмбийг тогтоож, даван туулах төлөвлөгөө гаргана.	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ОБХ
53		Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/11 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/15 дугаар захирамжийн хэрэгжилт, дүүргийн хэмжээнд гэнэтийн гамшиг, осол, аюулт үзэгдлийг хохирол багатай даван туулах, албад, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн харилцан ажиллагааг сайжруулах зорилгоор дүүргийн хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулж сургуулийн удирдагчийн зүгээс 91 буюу “А” үнэлгээтэй дүгнэгдэн ажилласан. Гэнэтийн гамшиг, осол, аюулт үзэгдлийн эрэмбийг тогтоож, даван туулах зорилгоор СБДүүргийн гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөө, ЗДТГ-н байрны гамшгаас хамгаалах төлөвлөгөө, 10 албад, 4 мэргэжлийн анги, 54 аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинээр боловсруулан баталгаажуулан ажилласан.				100%
		Дэд бүтэц, тохижилтын хэлтэс, газрын албатай хамтран онцгой байдлын шуурхай албаны авто машин саадгүй хүрэлцэн очих нөхцөлийг бүрдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ	ОБХ, ГА
54		Дүүргийн 6-р хороо, Хүүхдийн урлан бүтээх төвийн урд талд Хурд интернэйшнл” ХХК нийтийн эзэмшлийн замд зөвшөөрөлгүй хаалт байрлуулж, бусдын эзэмшил газар дээр төлбөртэй зогсоол ажиллуулсан, 6-р хороо, МТ барилгын зүүн талд “Асира” ХХК зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн хаалт байрлуулсан, 6-р хороо 27, 28 дугаар байрнуудын орчим нийтийн эзэмшлийн зам талбайг хааж гинжилсэн 7 дугаар хороо Улаанбаатар чуулгын зүүн талд зөвшөөрөлгүй нийтийн эзэмшлийн зам талбайг хааж хашаалсан зэрэг зөрчлүүдийг арилгаад байна. Энэ ажил нь үргэлжлэн явагдаж байна. 2017 оны 04 дугаар сарын 28-ны өдөр Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга Б.Анхбаяр, гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн нар хамтран тус дүүргийн 9,13,14,16,17 дүгээр хороодын нутаг дэвсгэр дэх ус зайлуулах далан сувгийн ашиглалтын байдал, ус нэвтрэх, үерт автаж болзошгүй айл өрх, цаашид авах арга хэмжээний талаар үзлэг шалгалтыг зохион байгуулан ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/11 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/15 дугаар захирамжийн хэрэгжилт, дүүргийн хэмжээнд гэнэтийн гамшиг, осол, аюулт үзэгдлийг хохирол багатай даван туулах, албад, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн харилцан ажиллагааг сайжруулах зорилгоор дүүргийн хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулж сургуулийн удирдагчийн зүгээс 91 буюу “А” үнэлгээтэй дүгнэгдэн ажилласан. Гэнэтийн				100%

		гамшиг, осол, аюулт үзэгдлийг тогтоож, даван туулах зорилгоор дүүргийн гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөө, ЗДТГ-н байрны гамшгаас хамгаалах төлөвлөгөө, 10 албад, 4 мэргэжлийн анги, 54 аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинээр боловсруулан баталгаажуулан ажилласан.				
55	3.2.2. Хороодод үүсэн байгуулагдсан Хөршийн холбоог нэмэгдүүлэх чиглэлээр дэмжиж ажиллана.	Байгуулагдсан хөршийн холбоог чадавхижуулах, зарим хороодын холбоог шинээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ЦХ-1,2
		<p>Цагдаагийн 1 дүгээр хэлтэс: Одоогийн байдлаар дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулагдсан хөршийн хяналтын бүлэг 3, өсвөрийн сэргийлэгчдийн бүлгэм 6, эцэг эхийн төлөөллийг сургуулийн орчмын аюулгүй байдлыг хангах зорилгоор эргүүлд татан оролцуулж байгаа 17 ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Цагдаагийн 2 дугаар хэлтэс: “Хөршийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хороодын оршин суугчдад сурталчлах ажлыг эрчимжүүлэх зорилгоор дүүргийн 10, 11, 15, 16, 17, 20 дугаар хороодын нутаг дэвсгэрт хэсгийн байцаагч, хороон цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан, урамшилт эргүүлийн ажилтан нарын 110 хүний хүчээр 28 цэгт 2017 оны 04 дүгээр сарын 24-нөөс 29-ний өдрүүдэд иргэдтэй уулзалт, яриа, зөвлөгөөн зохион байгуулж ажилласан. Хөршийн хяналтын ахлагч нарт 17 дугаар хорооны засаг даргын ажлын албанаас “Хөршийн холбооны ахлагч”-ын үнэмлэх 14 иргэнд олгож цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хамтран гаргав. Дүүргийн 20 дугаар хороо “Хөршийн хяналт”-ын бүлэгтэй харилцах дэвтэр хүлээлгэн өгч, тогтмол мэдээлэл солилцон 21 гудамжинд Хөршийн хяналт гэсэн бичиглэл бүхий дарцагыг байршуулж ажиллаж эхэлсэн. Дүүргийн 9-20 дугаар хороодод зохион байгуулагдсан 128 хөршийн хяналтын нэгдлүүдэд цагдаагийн хоёрдугаар хэлтсээс “Хөршийн хяналт”-ын үйл ажиллагаа явуулах “Аргачилсан заавар”-ыг боловсруулж хороо хариуцсан хэсгийн байцаагч, хороон цагдаа нараар хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Хариуцсан нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, эрх зүйн зөрчил ихээр үйлдэгддэг дүүргийн 16-р хороо 11 дүгээр гудамжийг “Хөршийн хяналт” хөтөлбөрийн хүрээнд гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьчилан сэргийлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх төслийг боловсруулан Засаг даргын тамгын газарт хүргүүлж нийгэм эдийн засгийн хэлтсээс эдийн засгийн судалгаа тооцоог хийж 11 гудамжийг LD гэрэлтэй болгоод байна. Хорооны засаг дарга, хэсгийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэйгээр хөршийн хяналтын бүлэг, цагдаагийн байгууллага, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын уялдаа холбоог сайжруулах зорилгоор 5500 орчим иргэнд яриа таниулга хийж, шинээр хөршийн хяналтын бүлгэмийг зохион байгуулж, цаашид цагдаагийн байгууллага, хөршийн холбоо иргэд хоорондоо мэдээ мэдээлэл солилцох, хамтран ажиллах ажлыг сайжруулах талаар санал солилцон иргэдийг идэвхжүүлэх ажлыг зохион байгуулж дүүргийн 09-20 дугаар хорооны гудамжинд “Анхаар камер ажиллаж байна” гэсэн бичиглэл бүхий гэрлийн ойлттой самбарыг байршуулан ажиллаж байна.</p>				100%
56	НЗДҮАХ-ийн 5.4.3 дахь заалт;	Оюутан цагдаагийн ажиллах нөхцөл бололцоог	Үйл	100	ТЗУХ	ЦХ-1, 2

	<p>3.2.3. "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлнэ.</p>	<p>сайжруулна.</p>	<p>ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>			
		<p>Цагдаагийн 1 дүгээр хэлтэс: Дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсээс 2017 оны эхний 10 сард 455 иргэн, 65 аж ахуйн нэгж, байгууллагын 335 ажилтан, алба хаагчдыг нийтийн эргүүлд, 114 иргэнийг урамшилтай эргүүлд ажиллуулж, үр дүнг тооцсон. Дээрх эргүүлүүд нь ажиллах хугацаандаа 88 зөрчил илрүүлэн цагдаагийн байгууллагад мэдээлэл өгч холбогдох шалгалтыг явуулсан. Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу 5 иргэнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд олон нийтийн цагдаагаар ажиллуулсан. Олон нийтийн цагдаа нар ажиллах хугацаандаа 4 гэмт хэрэг, 336 зөрчил илрүүлсэн. 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 16 Их дээд сургууль, МЗХ-той хамтран "Оюутан эргүүл" арга хэмжээний нээлтийн ажиллагааг 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 11 цагт МЗХ-ны байрны хурлын танхимд зохион байгуулсан. 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн "Оюутны эргүүл" ажлуулах төлөвлөгөө, журам боловсруулан хэлтсийн даргаар батлуулж Сүхбаатар дүүргийн 1, 6, 7, 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй АШУИС, ШУТИС, МУБИС, ҮБТДС, МУИС,"Түшээ", "Шихихутуг","Сити" дээд сургууль, оюутны байрны орчинд тус бүр 10 нийт 70 оюутныг өөрсдийн сургуулийн тод шар өнгийн "Оюутан эргүүл" эмблемтэй хантааз, малгайгаар жигдрүүлж, зааварчлага өгч өдрийн цагаар эргүүлээр ажиллуулж байна.</p> <p>Цагдаагийн 2 дугаар хэлтэс: Олон нийтийн цагдаагийн ажилтанууд хариуцсан нутаг дэвсгэртээ хэсгийн байцаагч, хорооны цагдаа, хэв журмын урамшилтай эргүүлүүдтэй хамтран гудамж талбай олон нийтийн газарт эргүүл хяналтыг тогтмол зохион байгуулж, ажилд гарах бүрдээ дарга, удирдах ажилтнаас үүрэг чиглэл авч, 7 хоног, сараар ажлын биелэлт үр дүнг тооцсон. Хэсгийн байцаагч, хорооны цагдаа, 70 урамшуулалт эргүүл нарын хамт хариуцсан хорооны нутаг дэвсгэрт бүлэг бөөгнөрөл үүсгэдэг айл өрх, гудамжаар өдөр бүр эргүүлийн үүрэг гүйцэтгэж, хууль тогтоомжийг тайлбарлан таниулж ухуулга сурталчилгааг давхардсан тоогоор 2082 байгууллага, 2565 иргэнд хийж, хэлтэс, тасгаас зохион байгуулсан 22 /давхардсан тоогоор/ нэгдсэн болон тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээнд оролцсон. Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулах зорилгоор 7 хоног бүрийн 1 дэх өдөр олон нийтийн цагдаагийн ажилтан нараас мэдээ мэдээлэл авснаар гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй 23 мэдээлэл хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байна. Нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч нараас 7 хоног бүрийн 1 дэх өдөр олон нийтийн цагдаагийн ажилтны төлөвлөгөө тайлантай тогтмол танилцаж, аюулгүй ажиллагааны заавар, ажлын чиглэл өгч, ажлын үр дүнг тооцож ажилласан.</p>			<p>100%</p>	
<p>57</p>	<p>НЗДҮАХ-ийн 5.4.5 дахь заалт; 3.2.4. Дүүрэгт хэрэгжүүлж байгаа хэв журмын урамшуулалт эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.</p>	<p>Хэв журмын урамшуулалт эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>100</p>	<p>ТЗУХ</p>	<p>ЦХ-1, 2</p>
		<p>Цагдаагийн 1 дүгээр хэлтэс: 2017 оны 10 дугаар сарын байдлаар 29 иргэн Засаг даргын тамгын</p>				<p>100%</p>

		<p>газартай хэв журмын урамшилтай эргүүлээр ажиллах гэрээ байгуулан дүүргийн 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт тогтмол ажилласан. Урамшилтай эргүүл үүрэг гүйцэтгэх хугацаанд сургууль, цэцэрлэгийн эхлэх, тарах цагуудад бага насны хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 86 бага насны хүүхдийг зам хөндлөн гаргахад тусламж үзүүлж, сургуулийн нийгмийн ажилтан, эцэг эхэд нь хүлээлгэж өгсөн. Хэсгийн байцаагч, эргүүлийн цагдаа нарт мэдээ, мэдээлэл өгч ажилласны үр дүнд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэн, биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон 30 хүнийг ар гэр асран хамгаалагч, саатуулах байр, яаралтай түргэн тусламж 103-д хүлээлгэн өгч осгож хөлдөх, эрүүл мэндээрээ хохирох, амь насаа алдах эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт, гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн орчинд оршин суудаг идэвхтэй 2500 иргэнийг сонгон авч сар бүр тодорхой мөнгөн урамшил, хөдөлмөр аюулгүй байдлын таних тэмдгээр ханган ажиллуулахаар болсонтой холбогдуулан Сүхбаатар дүүргийн 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2017 оны 01 дүгээр сараас 160 иргэнтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж эхэлсэн. Хэв журмын урамшилтай эргүүлүүд хариуцсан хорооны нутаг дэвсгэртээ 1, 3, 5 дахь өдрүүдэд ажлын цагаар гэмт хэрэг, захиргааны зөрчил гарч болзошгүй, хүн ихээр цуглардаг эмзэг цэгүүдэд эргүүл хяналт тогтоон Сүхбаатар дүүргийн 1-8-р хорооны нутаг дэвсгэрт үүрэг гүйцэтгэж байна. 2017 оны эхний 10 сард “Хэв журмын урамшилтай эргүүл”-үүд хороо хариуцсан цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан нарын хамт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, автомашины эд зүйл хулгайлах, халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 225 ширхэг санамж сэрэмжлүүлгийг тарааж, гудамж талбай болон ар гэртээ архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг 20 иргэнтэй уулзаж, хууль тогтоомжийг сурталчилж зөвлөгөө өгсөн. Хэсгийн байцаагч, эргүүлийн цагдаа нарт мэдээ, мэдээлэл өгч ажилласны үр дүнд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэн, биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон 8 хүнийг ар гэр асран хамгаалагч, саатуулах байр, яаралтай түргэн тусламж 103-д хүлээлгэн өгсөн.</p> <p>Цагдаагийн 2 дугаар хэлтэс: 2017 оны 10 сарын байдлаар тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт 36 хэв журмын урамшилтай эргүүл ажиллаж байна. Тус цагдаагийн хэлтсээс “Эртэч цагдаа” хөтөлбөр, “Хичээлийн шинэ жил” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 9-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 06:30-14:00, 14:00-22:00 цагуудад тасаг албад болон олон нийтийн цагдаа, хэв журмын урамшилт эргүүлүүдийг явган эргүүлд гарган ажиллуулж байна Арга хэмжээний хүрээнд 11 дүгээр хороо, хангай хотхоны уулзвар орчим, 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр, шарга морьтын уулзвар орчимд Бэлх-31 явуулын цагдаагийн постонд 2 алба хаагчийг 24 цагаар үүрэг гүйцэтгүүлж, тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалтыг тогтмол явуулж, хулгайн эд зүйл тээвэрлэсэн, эрэн сурвалжлагдсан этгээдийг олж тогтоох, илрүүлэх чиглэлээр хяналт шалгалт хийн ажилласан.</p>				
58	3.2.5. Гэмт хэрэг, зөрчлийг бууруулж, иргэдийн аюулгүй	Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг цэгүүдийн гэрэлтүүлгийг сайжруулж, телекамерын хяналтад	Үйл ажиллагааны	100	ТЗУХ	ЦХ-1, 2

	байдлыг хангана.	авах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	хэрэгжилт, хувиар			100%
59		Гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ЦХ-1, 2
		<p>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Дүүргийн 2017 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 02 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын А/147, А/342 дугаар захирамжийн дагуу тус тус 9, 15-18, 20 дугаар хороонд 1182 ширхэг, 1-8, 10 дугаар хорооны хог хаягдал цуглуулах цэгт 25 ширхэг гэрэлтүүлэг, хог хаягдал цуглуулах 25 цэгийг шилэн кабельд холбох болон нэг чигийн 20, 360 градусын 25 ширхэг камерын ажлын нийт 60 байршилд 2,326,430.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 37 төсөл, арга хэмжээний худалдан авалтын захиалгыг боловсруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2017.05.08-ны өдрийн 6/1057, 2017.06.27-ны өдрийн 6/1563, 2017.09.07-ны өдрийн 6/2390, 2017.10.20-ны өдрийн 6/2903 дугаар албан тоотуудаар ХААА-нд шилжүүлсэн.</p> <p>Дүүргийн ХАААлба худалдан авах ажиллагааг 2017.04.28-ны өдрөөс 2017.10.13-ны өдрийн хооронд зохион байгуулж, дүүргийн Засаг даргын Тамгын газар 2017.07.21-ний өдрөөс 2017.11.29-ний өдрийн хооронд гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Цагдаагийн 1 дүгээр хэлтэс: Цахим эргүүл"-ийн чиглэлээр 2014 онд 64 цэгт 128 ширхэг нэг чигийн камер, 2015 онд шинээр 22 цэгт эргэдэг 22 камер суурилуулсан. Нийт 88 цэгт 150 ширхэг камерын хяналтаар 2017 оны 07 дугаар сард гудамж талбайд цахим эргүүлийг 24 цагаар тасралтгүй зохион байгуулж үйлдэл дээр нь 4 гэмт хэрэг, бичлэгээр 18 нийт 22 гэмт хэрэг, 52 зөрчлийг илрүүлэн гудамж талбайд ажиллаж буй эргүүлийн алба хаагчдыг мэдээ, мэдээллээр хангаж, гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын явцад нотлох баримтаар ашиглах 34 бичлэгийг хуулбарлан өгч, бичлэг шүүлгэх хүсэлт гаргасан 87 иргэд, оршин суугчдад камерын дүрс бичлэгийг ухраан үзүүлж, цагдаагийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Эргүүл" нэгдсэн арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор 120 чиглэлд 208 алба хаагч өдөр бүр явган эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллалаа. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хороо тус бүрт эрүү болон хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн цэгүүдэд сэлгэн ажиллуулах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Нийт 312 удаагийн эргүүлд давхардсан тоогоор 210 алба хаагч ажилласан байна.</p> <p>Цагдаагийн 2 дугаар хэлтэс: Тус цагдаагийн хэлтсээс Нийслэл хотод үйлдэгдэж байгаа гэмт хэргийг бууруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд орон сууцны орц, гадна орчин, гэр хорооллын гудамж, талбай зэрэг газруудыг камержуулж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлхээр 60.000.000 төгрөгний шагналын сантай "Камержуулалт" болзолт уралдааныг зохион байгуулан ажиллалаа. Болзолт уралдааны хүрээнд тус цагдаагийн хэлтсийн 9-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт иргэдийн амар тайван</p>				100%

		<p>амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй эмзэг цэгт нийт 25 иргэд гэр хорооллын гудамж талбайд 46 ширхэг хяналтын камерыг 7.898.000 төгрөгөөр, Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хорооны Баянбулаг хөршийн холбоо нь 3 ширхэг хяналтын камерыг 630.000 төгрөгөөр, Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны Хангай СӨХ нь 2 блок буюу нийт 8 байрны гадна, дотор орчинд 280 ширхэг камерыг 72.307.200 төгрөг, нийт 80,835,200 төгрөгний 329 ширхэг хяналтын камерыг байршуулж ажилласан байна. Гэмт хэрэг эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Сар, “Илрүүлэлт”, “Илрүүлэлт оргодол”, “Хэрэгжилт”, “Хонх дарж хаалга тогё”, “Камержуулалт 2сарын аян”, “Хүүхэд хамгаалал”, “1000 оюутны эргүүл”, “Эргүүл”, “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлье”, “Төгсөлт”, “Зуслан”, “Хорио цээр хяналт”, “Тарваган тахал”-аас урьдчилан сэргийлье, “Хичээлийн шинэ жил”, “Эрчимжүүлэлт-2”, “Цахим тоглоом”, “Массаж” “Тэнэмэл”, “Тамхины хяналт”, “Цахим тоглоом”, “Бэлэн бус торгууль”, “Илрүүлэлт-оргодол”, “Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг 81 удаа зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан.</p>			
60	<p>Хар тамхи, мансууруулах бодис, тамхины хор хөнөөл, архидан соггуурахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>100</p>	<p>ТЗУХ</p>	<p>ЦХ-1, 2</p>
		<p>Дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 03 –ны өдрийн Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээ, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай А/35 дугаар захирамжийн хүрээнд энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар эрх зүйн боловсролыг нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр эзэмшүүлэх замаар хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийг ойлгуулах, гэмт хэргийн золиос болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагч, оюутнуудын дунд “Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээ, түүнээс урьдчилан сэргийлэх бидний оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж төрийн өмчийн 11 ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, их, дээд 7 сургуульд тус сэдвээр дүүргийн Прокурорын газар, Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Цагдаагийн нэг, хоёрдугаар хэлтэс, сургуулийн захиргаа хамтран сургалт зохион байгуулахаар төлөвлөсөнөөс Ерөнхий боловсролын 9 сургууль, 5 их, дээд сургууль, коллежийн 1500 гаруй сурагч, оюутнууд хамрагдсан байна. Уг сургалтын талаар Монгол HD телевизийн Наашаа цаашаа нэвтрүүлэгт Хууль зүйн тасгийн дарга П.Булганмаа оролцож, мэдээлэл хийсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай үндэсний хөтөлбөр батлагдан хэрэгжиж байна. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Прокурорын газар, Цагдаагийн 1,2 дугаар хэлтэстэй хамтран зорилтот бүлгийн 100 иргэнд “Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2017 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 12 дугаар сарын 06-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын</p>			<p>100%</p>

		газрын хурлын зааланд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.				
		Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн гаралтыг бууруулах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ЦХ-1, 2
61		<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор Хонх дарж, хаалга тогшье өдөрлөгийг Цагдаагийн 1 дүгээр хэлтэстэй хамтран 2017 оны 02 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд 1-8 дугаар хорооны иргэдэд Метромалл их дэлгүүр, Саруул худалдааны төв, Улаанбаатар их дэлгүүрийн заланд тус тус зохион байгуулж сэрэмжлүүлэг, тараах материал тарааж, мэдээлэл хийсэн.</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай, Арбитрын тухай хуулиудыг 18-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрийн хооронд иргэдэд сурталчилах үйл ажиллагааг хороогоор дамжуулан зохион байгуулав. Нийт 20 хорооны 800 гаран иргэд хууль сурталчилах өдөрлөгт хамрагдаж мэдээлэл авлаа.</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудын хэрэгжилт, зохицуулалттай холбоотой журмууд, практик хэрэглээ, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг таньж илрүүлэн, ажиллах арга зүй, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах арга зүй, бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх тусламж, тэдэнтэй ажиллах арга зүй, ур чадварыг сайжруулах зорилгоор “Case conference” сургалтыг Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран 04 дүгээр сарын 21-ны өдөр ЗДТГ-ыг хурлын их танхимд зохион байгуулав. Сургалтад хорооны нийгмийн ажилтан, 13-аас 18 дугаар хорооны сургууль, өрхийн эмнэлгийн нийгмийн ажилтнууд болон Цагдаагийн хэсгийн байцаагч нар хамрагдлаа.</p> <p>Иргэдийн оролцоотой иргэдийн шинэтгэлийн жилийн ажлын хүрээнд НЗДТГ, Өмгөөлөгчдийн холбоотой хамтран Иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх өдөрлөгийг 11 дүгээр сарын 26-ны өдөр 09-16 цагийн хороонд дүүргийн Иргэний танхимд зохион байгуулав.</p> <p>Иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх өдөрлөгт дүүргийн нийт 90 иргэн хүрэлцэн ирж, 40 иргэн хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө авлаа.</p>				90%
		Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ЗЦХ
62		<p><b>Гудамж замын хяналт шалгалт:</b> Үүрэг гүйцэтгэх алба хаагчдын томилгоот хуваарийг хийхдээ Замын цагдаагийн албаны даргын баталсан “Ерөнхий төлөвлөгөө”-нд тусгагдсанаар 7 хоногоор хуваарийг гаргаж, хяналт шалгалтыг тогтмолжуулан зөрчил гаргагч жолооч нарт холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээг тооцон ажиллалаа. Тус хэлтсээс 2017 онд гудамж замын хяналт шалгалтаар нийт <b>130424</b> тээврийн хэрэгсэл шалгаж <b>67750</b> зөрчил илрүүлснээс Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.3.1 дэх хэсгийг зөрчиж согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон явсан <b>1956</b> зөрчил, Зөрчлийн тухай</p>				



	<p>хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.1 дэх хэсгийг зөрчиж журамлагдсан <b>171</b> зөрчил, Цагдаагийн байгууллага болон бусад албадаас зарлагдсан тээврийн хэрэгсэл <b>123</b>, Цагдаагийн нийтлэг үүргийн дагуу гарал үүслийн гэрчилгээгүй мал, малын гаралтай түүхий эд, мод тээвэрлэж явсан <b>25</b>, Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах Асап санд бүртгэлтэй <b>72</b> этгээдийг тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож байх үед зогсоож саатуулан холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч зөрчил гаргасан <b>65212</b> жолоочийг <b>1</b> тэрбум <b>848</b> сая <b>67</b> мянган <b>4</b> зуун төгрөгөөр торгон ажилласан.</p> <p><b>Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ:</b> 2017 онд “Согтуу”, “Бүрэн бус”, “Гэрэл, гэрэлтүүлэг”, Хамгаалах бүс”, “Гэрэл дохио”, “Өнгө үзэмж”, “Ачааны автомашин”, “Эрчимжүүлэлт” зэрэг <b>25</b> удаагийн хэсэгчилсэн арга хэмжээнүүдэд үүрэг гүйцэтгэх алба хаагчдын томилгоот хуваарийг хийхдээ зам тээврийн осол хэрэг ихээр гардаг хар цэгүүдэд хяналт шалгалтыг эрчимжүүлэн зам тээврийн осол хэргийн улмаас хүн нас барсан 8 цэгт алба хаагчдыг үүрэгжүүлэн үүрэг гүйцэтгүүлж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон <b>168</b> зөрчил, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон <b>29</b> зөрчил, хамгаалах бүс хэрэглэлгүй замын хөдөлгөөнд оролцсон <b>1162</b> зөрчил, бүрэн бус <b>84</b> тээврийн хэрэгслийн зөрчлийг илрүүлэн баримтжуулан холбогдох албан тушаалтанд шилжүүлэн өгч ажилласан. Тус хэлтсээс <b>25</b> удаагийн нэгдсэн шалгалтад зөрчил гаргасан нийт <b>1690</b> жолоочид <b>33</b> сая <b>800</b> мянган төгрөгөөр торгон дахин зөрчил дутагдал гаргахгүй байхыг сануулан хийж гүйцэтгэсэн ажлыг илтгэх хуудсаар Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газарт хүргүүлэн үр дүнг тооцуулан ажиллаж хэвшсэн.</p> <p><b>Олон нийттэй харилцах чиглэлээр:</b> Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор 2017 онд дүүргийн ерөнхий болосролын сургууль, цэцэрлэгүүдэд “Замын хөдөлгөөнийн дүрэм”, “Явган зорчигчийн эрх, үүрэг” сэдвүүдээр 1 цагийн сургалтыг 69 удаагийн зохион байгуулж 3200 орчим хүүхэд багачуудыг хамруулан ажилласан. Сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, тэдэнд замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох зорилгоор жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Замын хөдөлгөөний Цагаан толгой-2017”, “Ногоон гэрэл цагаан шугам-2017” тэмцээнүүдийг дүүргийн Засаг даргын тамгын газар, Боловсролын хэлтэс, Улаан загалмайн хороо, Хүүхэлдэйн театр, Улаанбаатар чуулга, Дуурийн театр зэрэг төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгжүүдтэй хамтран амжилттай зохион байгуулав. Энэхүү тэмцээний тус бүрийн зардлыг дүүргийн Засаг даргаар захирамж гаргуулан шийдвэрлүүлж, тэмцээнд амжилттай оролцсон хүүхэд багачуудад Засаг даргын гарын бэлэг, Үндэсний соёл амралтын хүрээлэнд үнэ төлбөргүй тоглох эрхийн бичиг зэргийг гардуулан гутгаар байр, дэд байр, тэргүүн байр, уран зохицуулагчийг шалгаруулан ажилласан. <b>Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр:</b> FM радио 96.3, 102,1-тэй хамтран иргэд жолооч нарт зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлж 9, VTV, Монгол HD, MYOHT, NTV, TV9, MN25 телевизүүдтэй зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замны хөдөлгөөний дүрмийн 12.2, өвлийн бэлтгэл, нийтлэг зөрчилүүдийн талаар 17 удаагийн иргэд жолооч нарт мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг хүргэж ажиллалаа. <b>Тараасан сурталчилгааны материал:</b> 58-р сургуулийн 1000 сурагчдад гэрэл ойлгогч ханцуйвч, тус</p>	100%
--	---	------

		<p>сургуулийн 4<sup>Б</sup> ангийн 38 хүүхдүүдэд Замын хөдөлгөөнд хэрхэн оролцох талаар гарын авлага, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байхыг уриалсан зурагт хуудсыг 20 аж ахуйн байгууллагын үүдэнд байршуулж, 45 дугаар суруулийн 28 сурагчдад зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор гарын авлага тарааж ажиллалаа. Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх “Орон нутгийн хөдөлгөөний соёл”, “Зам тээврийн осол хэрэгт өртөж хохирогсдод хүндэтгэл үзүүлэх өдөрлөг”, “Явган зорчигч, хариуцлага 2017” аян, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Дүүргийн засаг даргын тамгын газруудаас зохион байгуулсан 2 удаагийн өдөрлөгт тус хэлтсийн алба хаагчид бүрэн хамрагдан замын цагдаагийн албаны үйл ажиллагаа, ажил мэргэжлийн онцлог, шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжууд арга хэмжээнд оролцогч иргэд, жолооч нарт сурталчлан 8500 орчим санамж, сэрэмжлүүлэг, гарын авлагыг тарааж ажиллалаа. <b>Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтрассан талаар</b></p> <p>2017 оны 10 дугаар сарын 19-ний өдөр баянгол дүүргийн 94 дүгэр цэцэрлэгийн 131 хүүхэд 65 эцэг эхийг төрийн бус байгууллагатай хамтран “Орхон тайж”- амралтын газарт эцэг эх асран хамгаалагч нарт хүүхдийг аюулгүй тээвэрлэлт, замын хөдөлгөөний дүрмийн талаар 50 минутын сургалтыг зохион байгуулж ажилласан. 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр замын цагдаагийн урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн цагдаагийн хошууч Ж.Энхбатын хамт 160 дугаар цэцэрлэгийн 110 хүүхэд 47 эцэг эхчүүдийн хамт “Болор” амралтын газар очиж зориулалтын суудал хэрхэн ашиглах зөв тээвэрлэлтын талаар сургалт зохион байгуулж ажиллалаа. 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр замын Согионохайрхан дүүргийн зохицуулагч цагдаагийн ахмад Б.Алтанхүгя 68 дугаар цэцэрлэгийн 139 хүүхэд 86 эцэг эхчүүдийн хамт “Орхон тайж” амралтын газар очиж зориулалтын суудал хэрхэн ашиглах зөв тээвэрлэлтын талаар сургалт зохион байгуулж ажиллалаа. Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлж төрийн бус байгуулага “Доктор авто сервис”, “Боловсролын яам” “Хүүхэд залуучуудын холбоотой” хамтран 3 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласан. Мөн Автотээврийн үндэсний төвтэй хамтран автобус баазад үзлэг 3 удаагийн үзлэг шалгалтыг хийж зөрчил заагдсан аж ахуйн байгууллагын 34 жолооч нарт сургалтыг зохион байгуулж ажилласан.</p>				
63		<p>Замын хөдөлгөөний ачаалал ихтэй уулзварт Хөдөлгөөний аюулгүй байдлыг хариуцсан туслах ажилтан ажиллуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>100</p>	<p>ТЗУХ</p>	<p>ЗЦХ</p>
		<p>Нийслэлийн цагдаагийн газраас 2017 оны 04 дүгээр сарын 21-нээс 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд тус хэлтэст хуваарилагдсан 8 олон нийтийн цагдаагийн ажилтанг томилгоот хуваарийн дагуу ирц, үүрэг гүйцэтгэж байгаа байдал, цаг ашиглалтанд 07:30, 10:30, 14:30, 16:30, 19:00 цагуудад хэлтсийн ахлах зохицуулагч, хариуцсан бүсийн байцаагч нар биечлэн хяналт тавьж, зааварчилгаа, зөвлөгөөг өгч үүрэгжүүлэн ажиллалаа. Тус хэлтэст томилгогдсон 8 олон нийтийн цагдааг явган зорчигч зам тээврийн осол хэрэгт ихээр өртөж хохирдог хар цэгүүд буюу Гадаад хэргийн яамны баруун хойд уулзвар /440/, Багшийн дээдийн баруун урд уулзвар /450/ замуудад явганы гарц замуудад үүрэг гүйцэтгүүлж явган зорчигчийн эмх замбараагүй</p>			<p>100%</p>	

		хөдөлгөөнд хяналт тавиулан зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт хөдөлгөөний ачаалал ихтэй уулзварт зохиомол түгжрэл саатлыг бууруулах зорилгоор хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан ажилтанг ажиллуулах хөрөнгийг шийдвэрлүүлэх саналыг Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд хүргүүлсэн боловч одоогоор энэ төрлийн ажил арга хэмжээ зохион байгуулагдаагүй байна. Нийслэлийн цагдаагийн газраас 1 олон нийтийн цагдаагийн цалин хөлсийг шийдвэрлэсэн тул хэлтсийн ахлах зохицуулагч нар өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналтыг тавин хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулан ажиллаж байна.				
64		7-н буудлын автобусны эцсийн буудлыг Зунжин худалдааны төврүү шилжүүлж зохиомол түгжрэл саатлыг бууруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ЗЦХ
		Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо 7 буудлын автобусны эцсийн буудлыг Зунжин худалдааны төдрүү шилжүүлж Чингэлтэйн өргөн чөлөөний замын хөдөлгөөний ачааллыг бууруулж зохимол түгжрэл саатлыг бууруулах Нийслэлийн автозамын газарт 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрын 8-2д/115 тоот албан бичгээр саналыг хүргүүлсэн боловч дүүргийн Дэд бүтэц тохижилтын хэлтсээс саналыг хүргүүлээгүй учир энэ ажил, арга хэмжээ хэрэгжих боломжгүй байна.				70%
<b>3.3 Агаарын бохирдол, хог хаягдлыг бууруулна.</b>						
65	НЗДҮАХ-ийн 3.2.2 дахь заалт; 3.3.1. Агаарын бохирдлыг бууруулах талаар хувийн хэвшлийн байгууллагуудын шинэ санаачилга, дэвшилтэт технологийг дэмжиж ажиллана.	Түүхий нүүрсний хэрэглээг багасгах, дэвшилтэт технологи, сэргээгдэх эрчим хүчээр халаалтаа шийдвэрлэх талаар иргэд аж ахуйн нэгж байгууллагуудад ухуулга сурталчилгаа хийж хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ	
		Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03-03 дугаар Зөвлөмж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тухай тогтоох тухай А/04-А/19 дугаар Тушаал, Захирамжаар батлагдсан 2017 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/18 дугаар захирамжийн биелэлтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/12 дугаар Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай захирамж гарч Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд дэвшилтэт технологийн халаалтын бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулж иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулсан. Тус Захирамжийн биелэлтийг хангах ажлын хүрээнд дүүргийн 1, 2, 3, 7, 9, 13, 14, 15, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 118 аж ахуйн нэгж, иргэний халаалтын зуухны байдалд хяналт шалгалт хийж 100 мэдэгдэл, 5 албан шаардлага, 1 акт гаргаж гадна орчны бохирдолтой, хог хаягдал ил задгай хаясан 6 иргэнд 580.0 мянган төгрөгийн				100%

		<p>шийтгэврийн арга хэмжээ авч бүрэн барагдуулж ажиллалаа.</p> <p>Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын “Агаарын бохирдолд хяналт тавих тухай” 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/11 дүгээр тушаалын дагуу 1, 2, 4, 5, 7, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар хорооны Засаг дарга, олон нийтийн байцаагч, хэсгийн ахлагч, зохион байгуулагч нарыг байлцуулан Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 03-03 дугаар зөвлөмж, Нийслэлийн Засаг даргын А/17 дугаар захирамж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан А/04-А/19 дүгээр тушаал, захирамж, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 02-01/507 тоот албан бичгийг танилцуулан, мэдээлэл хийж ажиллалаа.</p> <p>Хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа агаар бохирдуулагч эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргуулж авсан.</p> <p>Гүйцэтгэлийн хяналтаар өмнө өгсөн 3 албан шаардлагын биелэлт 90 хувьтай, мэдэгдэл өгсөн газраас 49 газар түүхий нүүрсний хэрэглээг зогсоосон байна.</p> <p>Дүүргийн 11-18 дугаар хороодын 100 квт-аас дээш хүчин чадалтай зуух хэрэглэдэг 14 аж ахуйн нэгж, байгууллагын зууханд шалгалт хийж магадлан итгэмжлэл олгож, сорьцын цэгтэй болгож мэдээллийн сан үүсгэсэн. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд дэвшилтэт технологийн халаалтын бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулж иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулсан.</p>			
66		Усан халаалтын болон технологийн зориулалт бүхий зуухнуудад бүртгэл хяналтын тогтолцоо нэвтрүүлж, технологийн шинэчлэл хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ
		Дүүргийн 11-18 дугаар хороодын 100 квт-аас дээш хүчин чадалтай зуух хэрэглэдэг 14 аж ахуйн нэгж, байгууллагын зууханд шалгалт хийж магадлан итгэмжлэл олгож, сорьцын цэгтэй болгож мэдээллийн сан үүсгэсэн.			100%
67		Нийтийн эзэмшлийн бохирдсон хөрстэй гудамж, талбай, гэр хорооллын айл өрхийн бие засах газар, бохирын цооногт ариутгал, халдваргүйтгэл хийлгэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ
		Гэр хорооллын 19803 айл өрхийн жорлон бохирын цооног, нийтийн эзэмшлийн 38000 мкв бохирдсон хөрстэй гудамж талбайд ариутгал халдваргүйтгэлийг Хан судар ХХК, Сүүнболор ХХК, Гангаболд ХХК-нуудтай гэрээ байгуулж хийлгэсэн.			100%
68	НЗДҮАХ-ийн 3.3.7 дахь заалт; 3.3.2. Хог хаягдлын менежментийг одоогийн түвшингээс сайжруулна.	Гаднах орчноо цэвэрлэдэггүй, хууль бусаар хог хаягдлаа хаядаг явдлыг таслан зогсоож, бүх нийтийн болон өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ, хог тээвэрлэлтийн ажлыг сайжруулан тогтмолжуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТНААХ
		Нийтийн эзэмшлийн гудамж талбайд ил задгай хог хаягдал үүсэх, хогны савны өнгө үзэмж муудаж, багтаамж муутай байгаагаас хог хаягдал багтахгүй гадуур асгарах, хог хаягдлын			100%

	<p>үйлчилгээний байгууллагууд хог хаягдлын цаг хугацаанд нь тээвэрлэхгүй байгаагаас зэрэг зөрчлүүд байсаар байна. Эдгээр зөрчлийг арилгах нийслэл, дүүргийн өнгө үзэмжинд муугаар нөлөөлж байгаа ил задгай хогны савыг шинэчилж солих хяналт хариуцлагыг сайжруулах үүднээс хог хаягдлыг шинэ менежментийг хэрэгжүүлж эхлээд байна. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн 25 байршилд эрүүл ахуйн шаардлага хангасан битүү, өнгө үзэмж багтаамж сайтай хогны савыг байрлуулах ажлыг эхлүүлэн ажиллаж байна.</p> <p>Тус хогны савыг байрлуулахад:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хогны савны суурь хэсэг болон эргэн тойрны хэсгийг бетондож хөрсөнд бохир шингэхгүй хөрсний бохирдлоос урьдчилсан сэргийлнэ.</li> <li>• Хогны савны орчныг бүрэн гэрэлтүүлэх гэрэлтүүлэг хийнэ.</li> <li>• Хяналтын камер байршуулж ил задгай хог хаягдал үүсгэх, хогны савын гадуур хаях орчин бохирдуулах, хог хаягдлыг цаг тухайд нь тээвэрлэж байгаа эсэхэд хяналт тавих, мөн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.</li> <li>• Хяналтын камерын хяналт удирдлагын диспетчер 24 цагаар ажиллаж бүрэн хянаана. зэрэг давуу талтай болно.</li> </ul> <p>Ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.</p> <p>Хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудыг тендер зарлан шалгаруулалтын шатанд байна. Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ тендер шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 2465 аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй гаднах орчны тохижилт, цэвэрлэгээний гэрээг хороодын Засаг даргын ажлын албатай шинэчлэн байгуулуулж, гэрээний биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Гаднах орчноо цэвэрлэдэггүй, хууль бусаар хог хаягдлаа хаядаг, шаардлага биелүүлдэггүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын талаарх мэдээлэл, санал гомдлыг дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэст уламжилж 6 аж ахуйн нэгж байгууллага, иргэнд 580000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авахуулсан.</p> <p>Засаг даргын захирамжийн хүрээнд Засаг даргын орлогчийн Албан даалгавар гарган Аж ахуйн нэгж, байгууллага, СӨХ, иргэдэд хороодоор дамжуулан мэдээлэл хүргүүлэн 1370 аж ахуйн нэгж байгууллага, 3369 иргэнийг хамруулан гаднах орчны цэвэрлэгээг хийлгэн хяналт тавин ажилласан.</p> <p>Засаг даргын Тамгын газраас хороо тус бүрт 10-30, нийт 400 иргэнийг урамшуулал олгон шуудай, бээлий, багаж хэрэгслээр ханган эзэнгүй талбай, далан гуу жалга, хогийн цэгийн хог хаягдлыг цэвэрлүүлсэн.</p> <p>Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Улаанбаатар шинэчлэл ХХК-аас ковш гарган ажиллуулж 9, 11-р хорооны дахин төлөвлөлтөд орж газар чөлөөлөгдсөн талбайн эзэнгүй хог хаягдлыг түрүүлж, тээвэрлүүлсэн.</p> <p>Цэвэрлэгээний явцад Нийслэлийн захирагчийн ажлын алба, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтнүүд хяналт тавин ажилласан.</p> <p>Цэвэрлэгээнд 1-20 хороод идэвхтэй оролцож аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг өргөнөөр</p>	
--	--	--

		хамруулан хариуцсан нутаг дэвсгэрийн хог хаягдлыг бүрэн цэвэрлэсэн. Цэвэрлэгээний ажилд Сүхбаатар тохижилт ХХК, Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Улаанбаатар шинэчлэл ХХК, Алтан дорнын хүч ХХК, Цүзүки-Юмэ ХХК- нийт 37 хог тээврийн машин, 2 ковш ажиллаж 90 рейс буюу 405 тонн хог хаягдал, цас, мөсийг тээвэрлэсэн.				
<b>3.4 Иргэдийн нийтийн биеийн тамираар хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлнэ.</b>						
69	3.4.1. Дүүргийн ахмад настнуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх танхимыг байгуулж, үйл ажиллагааг дэмжиж ажиллана.	Хорооны Иргэний танхимыг түшиглэн ахмадын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үйл ажиллагааг өрнүүлэн ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	АХ
		-Дүүргийн 20 хорооны иргэний танхимд ахмадуудын дунд 110 удаагийн уралдаан, тэмцээн, өдөрлөгийн үйл ажиллагаа зохион байгуулж, давхардсан тоогоор 8700 гаруй ахмад хамруулсан. Мөн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хапитат” байрны спорт зааланд ахмадууд 7 хоног бүрийн Лхагва, Бямба гаригт өдөрлөг, уулзалт, спортын тэмцээн уралдаан тогтмол зохион байгуулж байна. - Ахмадын “Хийморь” клуб нь нийт 25 гишүүнтэйгээр иргэдийн хөгжлийн зааланд 7 хоногийн Лхагва гариг бүр волейбол, теннис, шатар тоглож үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.				
70	НЗДҮАХ-ийн 4.5.2 дахь заалт; 3.4.2. Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн талбайг шинээр байгуулах болон шинэчилж, тохижуулна.	Дүүргийн хөрөнгө оруулалтаар тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ.	Ажлын явц, хувиар	100	ТГХШХ	СТСХ ТНААХ, ХААА
		Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Дүүргийн 2017 оны төсөв батлах тухай 12, 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Дүүргийн 2017 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 02 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын А/147, А/342 дугаар захирамжийн дагуу 5 нийтийн орон сууцны барилгын гадна фасад засвар, 8 нийтийн орон сууцны дээвэр засвар, 18 байршилд тохижилт, нийт 31 байршилд 880,806.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээний худалдан авалтын захиалгыг боловсруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2017.03.27-ны өдрийн 6/654, 2017.06.27-ны өдрийн 6/1564 6/1566, дугаар албан тоотуудаар ХААА-нд шилжүүлсэн. Үүнээс дүүргийн ХАААлба 26 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2017.04.27-ны өдрөөс 2017.09.12-ны өдрийн хооронд зохион байгуулж, 1 төсөл, арга хэмжээ тендерийн зохион байгуулалтын түвшинд хэрэгжиж байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газар 2017.06.05-ний өдрөөс 2017.10.15-ны өдрийн хооронд хяналт тавин ажиллаж, гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан. Тохижилтын 294,099.9 мянган төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжихээр төлөвлөгдөж байна.				
71	НЗДҮАХ-ийн 4.4.8 дахь заалт; 3.4.3. Иргэд болон зорилтод бүлгүүдийн дунд /Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ нийтийн биеийн тамирын үйлчилгээг өргөжүүлж, бүх ард	Спортын наадам, өдөрлөг, уралдаан тэмцээнд иргэдийг өргөнөөр хамруулан зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	БТСХ Хороодын ЗДАА
		Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн оюутны спортын IV наадмыг зохион байгуулах тухай 158 дугаар тогтоолын хүрээнд дүүргийн Засаг даргын 2017				

<p>түмний, Хүүхдийн, Үндэсний, Оюутны спортын наадмуудыг зохион байгуулж, Их наадмуудад дүүргийн баг тамирчдыг оролцуулна.</p>	<p>оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/32 дугаар захирамжийн дагуу дүүргийн Оюутны спортын IV наадмыг 2017 оны 2 дугаар сарын 01-нээс 03 дугаар сарын 25-ны өдрүүдэд спортын 5 төрлөөр зохион байгууллаа. Тус наадамд 7 их, дээд сургуулийн 48 багийн 500 гаруй оюутан, тамирчид оролцсоноос байгууллагын нэгдсэн дүнгээр: I байрт Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль, II байрт Үндэсний Биеийн тамирын дээд сургууль, III байрт Монгол Улсын Их сургуулиуд тус тус шалгарч, Өргөмжлөл, медаль болон мөнгөн шагналаар шагнав.</p> <p>-Төрийн албан хаагчдын бие бялдрын эрүүл чийрэг байх нөхцлийг бүрдүүлэн, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, чөлөөт цагаа хамт олноороо зөв боловсон өнгөрүүлэх, дүүргийн Засаг даргын Тамгын газрын шигшээ баг бүрдүүлэх зорилгоор дүүргийн ажилтан албан хаагчдын дунд 2017 оны 04 дүгээр сарын 6,7,8-ны өдрүүдэд спортын 5 төрлийн тэмцээнд 8 багийн тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин оролцож, тэмцээний төрлүүдэд шалгарсан баг, тамирчдыг шагнаж урамшууллаа.</p> <p>-Нийслэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулагддаг Спорт наадам-2017 тэмцээн 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 14-ний өдрүүдэд 9 дүүргийн 10 баг, тамирчдын дунд спортын 5 төрлөөр зохион байгуулагдлаа. Тэмцээнд Сүхбаатар дүүрэг 2 алт, 2 мөнгөн медаль авч, багийн нэгдсэн дүнгээр Тэргүүн байр эзэлж, шилжин явах цом гардан авч, “Спорт наадам 2018” тэмцээнийг зохион байгуулахаар боллоо.</p> <p>-Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг дүүргийн ахмадын “Хаврын спорт өдөрлөг” 2017 оны 5 дугаар сарын 6, 7-ны өдрүүдэд спортын 4 төрлөөр амжилттай явагдлаа. Тэмцээнд 20 хорооны 350 гаруй тамирчид өрсөлдсөн. Шалгарсан баг тамирчдыг диплом, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналаар шагнасан.</p> <p>-Орос, Монгол, Хятад гурван улсын бие чийрэгжүүлэх амьсгалын дасгалын анхдугаар тэмцээн БНХАУ-ын Хөлөнбуйр аймгийн Хайлаар хотод зохион байгуулагдаж, 200 гаруй тамирчин, багш, дасгалжуулагч оролцож, Монгол улсаас 24 тамирчин, 6 дасгалжуулагчийн хамт амжилттай оролцлоо. Тус тэмцээнд оролцоход дүүргийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/122 дугаар захирамжаар 3,002,350 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>-БНХАУ-ын Ханжоу хотод 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 12-ны өдрүүдэд болох Ази, номхон далайн орнуудын суугаа волейболын аварга шалгаруулах тэмцээнд оролцох Хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэний замын зардалд дүүргийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/169 дугаар захирамжаар 1,000,000 төгрөг, Итали Улсын Терме хотод зохион байгуулагдах ахмадын шатрын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох дүүргийн 3 дугаар хорооны ахмад настан Г.Цэгмидэд Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/361 дүгээр захирамжаар 1,000,000 төгрөгийг тус тус шийдвэрлэж өглөө.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/207 дугаар захирамжаар, дүүргийн Иргэдийн спортын YI наадмыг 8 төрлөөр 3 үе шаттайгаар зохион байгуулж, нийт 20 хорооны 6000 иргэн хамрагдсан. Спорт наадмын явган аяллын тэмцээнийг 8 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд, Олс таталтын тэмцээнийг 9 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд, Ширээний шагайн наадгайн тэмцээнийг 9 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд, Волейболын тэмцээнийг 9 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд, Софт волейболын тэмцээнийг 10 дугаар</p>	
--	---	--

		сарын 7,8-ны өдрүүдэд, Сагсан бөмбөгийн тэмцээнийг 10 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан. Иргэдийн спортын VI наадам /бага онооны системээр/-д байгууллагын нэгдсэн дүнгээр: 1-р байр 7-р хороо, 2-р байр 20-р хороо, 3-р байр 12-р хороо, 4-р байр 16-р хороо, 5-р байр 10-р хороо тус тус шалгарч, Өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнуулсан. Иргэдийн спортын VI наадамд хороодын баг тамирчдаа амжилттай зохион байгуулан оролцсон 7-р хорооны Иргэний танхимын зохион байгуулагч Ц.Түмэндэлгэр, 10-р хорооны нийгмийн ажилтан Э.Даваадалай, 20-р хорооны нийгмийн ажилтан Н.Мягмархүү нарыг мөн шагнаж урамшуулсан.				
72	НЗДҮАХ-ийн 4.4.2 дахь заалт; 3.4.4. Иргэдэд амьдралын зөв дадал хэвшил олгох, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, зохистой хооллолт-идэвхтэй хөдөлгөөн аян, Бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорил хөтөлбөрийг жил бүр өрнүүлж, хүн амын бие бялдрын боловсролын түвшинг дээшлүүлнэ.	“Идэвхтэй хөдөлгөөн-Зохистой хооллолт” хөтөлбөрийн хүрээнд сургалт сурталчилгааны ажлыг өрнүүлэх, бие бялдрын түвшин тогтоох сорилд хамруулж, түвшинг дээшлүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	100	НХХ	БТСХ
		-Дүүргийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил” үзлэг зохион байгуулах тухай А/96 дугаар захирамжийн хүрээнд 67 байгууллагын 18603 хүнээс сорил авч, улсын нэгдсэн санд бүртгэв. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит “Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг сурталчлах сарын аяны үйл ажиллагааг идэвхи санаачлагатай зохион байгуулж ажилсан тул тус дүүрэг Монгол улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит Батламжаар шагнуулсан. -Нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/147 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/93 тоот захирамжийн дагуу “Улаанбаатар марафонд нэгдэцгээе” уриан дор төр захиргааны болон хувийн хэвшлийн Аж ахуйн нэгж байууллагуудад 4 цом аялуулж, нийт 80 байгууллага 150 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 9600 иргэн хамрагдсан. Улаанбаатар марафон олон улсын гүйлтэнд дүүргийн 70 гаруй байгууллагын 3192 ажилтан, албан хаагч иргэд оролцсноос нийт 881 иргэн гүйлтийн хураамж 1,762,000 төгрөгийг төлж, гүйлтэнд оролцлоо. Тус цом аялуулах ажлын хүрээнд Түмэн-Аюуш захиралтай Хасу Мегават групп хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд, ахмадуудын гүйлтэнд оролцогчдын хураамжинд 500.000₮, дүүргийн Татварын хэлтэс 150 хүний бүртгэлийн хураамж хандивлалаа.			100%	
<b>3.5 Газар өмчлөх ажлыг үргэлжлүүлнэ.</b>						
73	НЗДҮАХ-ийн 2.2.7 дахь заалт; 3.5.1. "Зуслан" ерөнхий төлөвлөгөөний дагуу дүүргийн 15, 19, 20 хороодын зуслангийн газар өмчлөх ажлыг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан үргэлжлүүлнэ.	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны "Зуслангийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" 25 дугаар тогтоолоор батлагдсан тус дүүргийн 15, 19, 20 дугаар хороодын 26 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газар өмчлөлийн ажлыг үргэлжлүүлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ГА
		Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны "Зуслангийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" 25 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын			70%	



		<ul style="list-style-type: none"> <li>• 2017.01.30-өдрийн А/44 тоот захирамжаар 27 иргэнд 1.5 га,</li> <li>• 2017.03.03-өдрийн А/109 тоот захирамжаар 142 иргэнд 8.7 га,</li> <li>• 2017.04.14-өдрийн А/236 тоот захирамжаар 35 иргэнд 1.8 га,</li> <li>• 2017.05.29-өдрийн А/355 тоот захирамжаар 17 иргэнд 0.9 га,</li> <li>• 2017.07.03-өдрийн А/498 тоот захирамжаар 14 иргэнд 0.8 га,</li> <li>• 2017.08.01-өдрийн А/571 тоот захирамжаар 91 иргэнд 5.5 га</li> <li>• 2017.08.01-өдрийн А/572 тоот захирамжаар 17 иргэнд 0.9 га,</li> <li>• 2017.09.01-өдрийн А/654 тоот захирамжаар 36 иргэнд 2.3 га,</li> <li>• 2017.10.03-өдрийн А/721 тоот захирамжаар 27 иргэн 1.4 га газрыг тус тус өмчлүүлж нийт Нийслэлийн Засаг даргын 10 удаагийн захирамжаар 420 иргэнд 24.7 га газрыг өмчлүүлж газар өмчлөлийн шийдвэр, хянан баталгаа, кадастрын зургийг олгосон.</li> </ul> <p>Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Нийслэлийн иргэдэд эзэмшиж буй газраа өмчлөхөд нь дэмжлэг үзүүлэх, хууль сурталчлах, газрын зөрчил маргааныг багасгах, хотын суурьшлын 1, 2 дугаар бүсэд газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлэх 3 сарын аяныг Нийслэлийн Газрын албаны даргын 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/65 тоот тушаалын дагуу зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Уг аяны хүрээнд тус дүүргийн 9, 11, 12, 13-18 дугаар хороодын 375 өрхийн газар хамрагдсан бөгөөд төлөвлөгөөний дагуу 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 04-ний хооронд газар өмчлөлийн ажил явагдана. Ажил эхлэх хугацаа хүртэл тус хороодоор урьдчилан таниулах сурталчилгааны ажил хийгдэж байна.</p>				
74	НЗДҮАХ-ийн 2.2.6 дахь заалт; 3.5.2. Иргэд зуслангийн газартаа өрхийн аж ахуй эрхлэх санал санаачилгыг идэвхжүүлж ажиллана.	Боломжит байршилд газрын асуудлыг шийдвэрлэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ГА
		Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 09-ны 'Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай' А/17 тоот захирамжийн хүрээнд Дүүргийн Засаг даргын А/185, А/228, А/299 дүгээр захирамжаар тус дүүргийн 11, 14, 16, 17, 18 дугаар хороонд 62 иргэнд 3.2 га газрыг тус тус олгоод байна. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх суурьшлын бүсээс бусад газар нутагт газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулахаар иргэдэд газар шинээр олгохыг хориглосон тул шинээр газар олголт хийгдээгүй байна.				
75	НЗДҮАХ-ийн 2.2.8 дахь заалт; 3.5.3. Газар зохион байгуулалт, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэхэд шаардлагатай материал, судалгаагаар хангаж ажиллана.	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж хамтарч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ГА
		Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайка, Монгол Улсын Барилга хот байгуулалтын яам болон нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хооронд байгуулсан гэрээний дагуу "Монгол улсын хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шатны төсөл"-ийн хүрээнд гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах нэг загвар төсөл нь тус дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэр Бэлх орчимд хэрэгжихээр болсон байна.				

		Энэ ажлын хүрээнд дээрх байршлын жижүүрийн зургийг БХБЯаманд хүргүүлэхээр НГА-ны МТХ-т өгсөн. Мөн дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөлт хэрэгжүүлж буй газруудтай тухай бүр хамтран ажиллаж иргэдэд мэдээлэл хүргэж байна.			
<b>Дөрөв. Иргэндээ үйлчлэх сүхбаатар дүүрэг</b>					
<b>4.1 Төрийн үйлчилгээг иргэдэд цогц, хүртээмжтэй хүргэнэ.</b>					
76		Дүүргийн нэгдсэн удирдлагын программ хангамж "СБД-50" программын хэвийн үйл ажиллагааг хангаж, хэрэгцээ, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэгч компанитай хамтран хөгжүүлэлтийг хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ
		2017 оны 02 дугаар сарын 09-ны өдөр Дүүргийн Засаг даргын Тамгын газар "Эн Эм Эм Эй" ХХК-тай дүүргийн sbd.gov.mn цахим хуудас, СБД-50 НУП хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах 01/17 тоот ажил гүйцэтгэх гэрээ байгуулж захиалга, зааварчилгаа, шинэчлэлтийг тухай бүр хийн ажиллаж байна.			100%
77	НЗДҮАХ-ийн 5.2.1 дахь заалт; 4.1.1. Төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулан нэгдсэн удирдлагын программ хангамжийг хөгжүүлнэ.	Дүүргийн хэмжээнд оюуны өмчийн бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн оюуны өмчийг хууль тогтоомжийн дагуу бүртгэх, өмчлөх эрхийн баталгааг хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ
		"Эрх зүйн шинэчлэл-иргэний эрхийн баталгаа" уриан дор зохион байгуулагдсан аяны хүрээнд 1 дүгээр сарын 27-ны өдөр "Нээлттэй хаалганы өдөр" зохион байгуулж, иргэн, эд хөрөнгийн нийт 164 бүртгэл хийж, утсаар 33 иргэнд, биечлэн 80 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Мөн дүүргийн 1-20 дугаар хороодын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм журам, үйлчилгээний нэр төрлийн талаарх багц гарын авлага бэлтгэн, тараан өгсөн. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас 2017 онд зохион байгуулах сарын аяны төлөвлөгөөнд заасны дагуу "Оюуны өмчийг хамгаалах өдрийг тохиолдуулан оюуны өмчийг дээдлэх, хамгаалах үйл ажиллагааг олон нийтэд түгээн дэлгэрүүлж, сурталчилах ажлыг 4 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан.			100%
78		Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хамгаалалтын талаар зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ
		2017 оны 2 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Оюуны өмч, улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд хэлтсийн дарга, тасгийн дарга, хяналтын улсын байцаагч нар оролцож оюуны өмчийн эрх зүйн зохицуулалт, зохиогчийн эрхийн талаар мэдээлэл авч, улмаар хэлтсийн албан хаагчиддаа мэдээлэл хийсэн. 5 дугаар сарын 17-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан ХЗДХЯамны Нээлттэй хаалганы өдөрт оролцон ажиллаж, зарим бүртгэлийг газар дээр нь бүртгэж, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хамгаалалтын талаар Зохиогчийн эрхийн газартай хамтран иргэдэд зөвлөгөө өгч, хууль сурталчлах үйл ажиллагаанд оролцож ажилласан.			90%

79	Улсын бүртгэлийн үйл ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	БүХ
	Эхний 11 сарын байдлаар иргэний цахим үнэмлэхийн нийт 9906 бүртгэл хийснээс 1707 иргэнд иргэний цахим үнэмлэх шинээр, 4182 иргэний цахим үнэмлэх дахин олгож, 4017 иргэний цахим үнэмлэхийн хугацаа сунгасан байна. Өнөөдрийн байдлаар нийт 15 хорооны улсын бүртгэгч нар онлайнд холбогдсон. Онлайнд холбогдоогүй 12, 16, 18, 19, 20 дугаар хороодын иргэдэд үзүүлэх бүртгэлийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, цаашид онлайнд холбох талаар судалж байна.				100%
80	Хаягжуулалтыг эрэмбэ дараатай цэгцэлж, хаягийн зөрчил давхардлыг арилгана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	БүХ
	Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажил, “Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг цэгцлэе” сарын аяны хүрээнд хаягийн зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулж, 1522 иргэний хаягийн зөрчлийг арилгаад байна. хаяг дээр 10-аас дээш сонгогч бүртгэлтэй хаягийн мэдээллийг сангаас шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хаягийн зөрчил давхардлыг арилгах, хаягжуулалтыг цэгцлэх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.				70%
81	Тусгай захиалгат бүртгэл болон тэмдэглэлт ой, андгай өргөх ёслолын ажиллагааг тогтмолжуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	БүХ
	2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр”-өөр иргэн, эд хөрөнгийн нийт 164 бүртгэл хийж, утсаар 33 иргэнд, биечлэн 80 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Сүхбаатарын талбайд 5 дугаар сарын 2-ны өдөр Нийслэлийн Засаг даргын тамгын газраас, 5 дугаар сарын 17-ны өдөр болон ХЗДХЯ-наас зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдрөөр бүртгэлийн үйл ажиллагаа, хууль сурталчлах үйл ажиллагаанд тус тус оролцож ажилласан. 2017 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан Сүхбаатар дүүргийн Нээлттэй хаалганы өдрийн арга хэмжээнд Улсын бүртгэлийн хэлтэс 10 хүний бүрэлдэхүүнтэй оролцож иргэдэд бүртгэлийн үйлчилгээ, мэдээлэл зөвлөгөөг хүргэж Иргэний бүртгэлийн чиглэлээр иргэний цахим үнэмлэхийн дахин олголт 98, мэдээлэл зөвлөгөө өгсөн-300, 5 иргэний төрөлтийн бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр нийт 100 гаруй иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч, 16 иргэнээс эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдүүлэг, нотлох баримтыг хүлээн авч ажилласан. “Ёслол хүндэтгэлийн танхим”-д Засаг даргын Тамгын газрын дарга Н.Энхболд, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Ариунжаргал нар шинээр төрсөн 2 хүүхдэд төрсний гэрчилгээг, шинээр гэр бүл болж байгаа 3 хосод гэрлэлтийн гэрчилгээг нь тус тус бэлэг дурсгалын зүйлийн хамтаар ёслолтойгоор гардуулан өгсөн.				100%

		<p>11 дүгээр хороонд шинээр ашиглалтад орсон СБД-ийн ЗДТГ-ын ажилчдын орон сууцыг улсын бүртгэлд бүртгэж өмчлөх эрхийг нь баталгаажуулан 37 албан хаагчид орон сууц өмчлөх эрхийн гэрчилгээг нь “Ёслол хүндэтгэлийн танхим”-д гардуулж өгсөн.</p> <p>Хайрын баярын өдрөөр /2 дугаар сарын 14/ гэрлэлтээ бүртгүүлсэн хосод гэрлэлтийн гэрчилгээг гардуулсан.</p> <p>Дэлхийн гэр бүлийн өдөр 5 дугаар сарын 17-ны өдөр Нийслэлийн гэрлэх ёслолын ордонтой хамтран шинээр гэр бүл болсон 6 хосыг бүртгэж гэрлэсний гэрчилгээг гардуулж, гэрлэх ёслолыг зохион байгуулсан.</p> <p>Оргил 6 буудал үйлчилгээний төвд шинээр нээгдсэн Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн нээлтийн үеэр иргэдэд төрсний, гэрлэсний болон газар өмчлөх эрхийн гэрчилгээг ёслолтой гардуулсан. Тус төвд Улсын бүртгэгч томилон ажиллуулж иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, тасралтгүй үзүүлж байна.</p>				
82	НЗДҮАХ-ийн 5.3.7 дахь заалт; 4.1.3. Иргэдийн өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх явцыг цахим бүртгэлд оруулж, цаг алдалгүй судлан үзэж түргэн шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж ажиллана.	Цахим бүртгэлд өргөдөл гомдол бүртгэж оруулах, шийдвэрлэх шатны мэдээлэл зэрэг шаардлагатай өргөтгөлийг оруулах, шийдвэрлэлтийн дундаж хугацааг багасгах арга хэмжээг авч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	БүХ
		Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг бүртгэн авч, шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. Хугацаа хэтэрсэн, шийдвэрлээгүй өргөдөл гомдол байхгүй байна.				100%
83		Мэргэжлийн байгууллагуудтай хамтран иргэдээс ирүүлсэн санал, гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж, иргэнд холбогдох хариуг цаг тухайд нь хүргүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	БүХ
		11 сарын байдлаар иргэдээс улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой нийт 40 гомдол ирүүлсэнийг холбогдох албан хаагчид хугацаанд нь шийдвэрлэж, бичгээр хариу өгсөн байна. Хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.				100%
84		Үйлчилгээ эрхлэх гэрээний сунгалтын хүсэлтийг дүүргийн цахим хуудсаар авч, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ	
		Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйлчилгээ эрхлэгч 2500 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хүлээн авч, мэргэжлийн заавар зөвлөгөө өгч, худалдаа, үйлчилгээ эрхлэх чиглэлээр хүсэлт ирүүлсэн 1600 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох журмын дагуу үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулснаас 250 гаруй нь шинээр гэрээ байгуулж 1350 гаруй аж ахуйн нэгж, иргэний үйлчилгээ эрхлэх гэрээг сунгасан.				100%
85	НЗДҮАХ-ийн 5.3.11 дахь заалт; 4.1.4. Хяналт, шалгалтыг сайжруулж, төрийн үйлчилгээг олон нийтийн мэдээллийн	Засгийн газрын тусгай сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны засгийн газар,	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ДАА

	хэрэгслээр ил тод мэдээлнэ.	байгууллага иргэдээс олгосон зээл, өгсөн хандив тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт зарцуулалтад байгууллагуудыг хамруулна.				
		<p>2017 оны албаны үйл ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаж дотоод аудит, санхүүгийн хяналт хяналт шалгалт хийсэн 41 байгууллагад тухай бүр төлөвлөгөө хөтөлбөртөө Засгийн газрын тусгай сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж дэмжлэг, эргэн төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны засгийн газар, байгууллага иргэдээс олгосон зээл, өгсөн хандив тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт зарцуулалтад хяналт тавьж ажиллаж байна. Зарим байгууллагууд хөрөнгийг орлогод авч данс бүртгэлдээ тусгаагүй өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан зөрчил гарсныг дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дүүргийн Насан туршийн боловсрол төвийн үйл ажиллагаа явуулж буй “Дэлхийн зөн” ОУ-ын байгууллагаас өгсөн 227,013.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод авагдаагүй байна. Сүхбаатар дүүргийн ЗДТГ, Дэлхийн зөн ОУБ-н хооронд байгуулсан гэрээний хугацаа дуусч СБД-ийн ЗДТГ- данс бүртгэлдээ тусган дараагийн асуудлыг шийдвэрлэхээр гэрээнд заасны дагуу албан тоот хүргүүлсэн болно.</li> <li>- 2017 оны 05–р сард Сүхбаатар дүүргийн 109 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийхэд 2015 оны 12 дүгээр сард Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан 884,451.0 мянган төгрөгийн гэрээний үнэ бүхий, 100 ортой цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 66 тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам”-н 3.7-д “Нийслэлийн өмчит хуулийн этгээдэд улсын төвлөрсөн төсвөөс хөрөнгө оруулалт хийж үндсэн хөрөнгө бэлтгэсэн тохиолдолд тухайн хөрөнгийн санхүүжилтийг хийсэн төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр бүртгэх шийдвэрийг энэ журмын 3.2-т заасны дагуу гаргаж, данс бүртгэлд тусгана” гэж заасныг үндэслэн холбогдох баримт материалыг үндэслэн Нийслэлийн өмчийн харилцааны газраас зөвшөөрөл авсны үндсэн дээр 2017 оны эхний хагас жилийн тайланд орлогод авч данс бүртгэлд тусгуулахаар зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулж ажилласан.</li> <li>-2017 оны 09 дүгээр сард СБД-ийн ЖДҮДТ-ийн 2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийхэд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдсан ЖДҮДТ-ийн барилга байгууламж СБД-н ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй байна</li> </ul> <p>Нийслэлийн өмчийн харилцааны газар нь ЖДҮДТ-ийн даргатай Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа боловч уг барилга байгууламж нь СБД-ийн ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй байгаа нь НИТХТ-ын 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 65 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам-1.13-д “Нийслэлийн өмчит хуулийн этгээд нь өөрийн санхүүгийн тайланд бүртгэлтэй эзэмшиж буй барилга байгууламжийн доторх илүүдэлтэй талбайг түрээслэхдээ талбайн түрээсийн орлогын 60 хувийг Өмчийн харилцааны газарт төвлөрүүлнэ”, 2014 онд 2017 онд удирдлага</p>			100%	

		<p>солигдох үед Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулсан гэрээний 3.11-д “Илүүдэлтэй байгаа ажлын байр тоног төхөөрөмжийг бусад аж ахуйн нэгж байгууллагад түрээслүүлэх тохиолдолд Өмчийн харилцааны газрын зөвшөөрлийг үндэслэн шийдвэрлэх бөгөөд талбайн түрээсийн орлогын 60 хувийг Өмчийн харилцааны газарт сарын бүрийн 10-ны дотор төвлөрүүлнэ” гэсэн заалт хэрэгжихгүй байгаад зөвлөмж хүргүүлсэн. .</p> <p>-2017 оны 10 дугаар сард Дэвшил ОНӨААТҮГ-н 2014 оны сүүлчийн хагас 2015. 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийхэд: СБД-ийн 20-р хороо СБД-ийн Тамгын газрын захиалгатай 721,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, 709,609.0 мянган төгрөгийн гэрээний үнэтэй “ 6 машины авто граж, конторын барилга”- г Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссын 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 2015/795 дугаартай актаар хүлээн авч “Сүхбаатар Дэвшил” ОНӨААТҮГ-ын мэдэлд шилжүүлэн хүлээлгэн өгснийг орлогод авч данс бүртгэлд тусгаагүй байгаа нь МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 “Аж, ахуй нэгж, байгууллага, гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахим бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг зөрчиж байгаа тул. 2017 оны жилийн эцсийн тайлангаар орлогод авч данс бүртгэлд тусгуулахаар албан шаардлага, зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.</p>				
<b>4.2 Татварын тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, татвар хураалтыг эрчимжүүлнэ.</b>						
86	<p>НЗДҮАХ-ийн 1.6.7 дахь заалт; 4.2.1 Улс болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган татвар хураалтыг эрчимжүүлэн төлөвлөгөөг биелүүлж ажиллана.</p>	<p>Улс болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, татварын ногдлыг хураан барагдуулах ажлын төлөвлөгөө боловсруулан хагас, бүтэн жилээр хэрэгжилтийг тооцож ажиллана.</p> <p>Оны эхний 11 сарын байдлаар :</p> <ul style="list-style-type: none"> <li>• Улсын төсөвт 132,787,655.7 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээс 133,521,377.5 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 100.6 хувиар;</li> <li>• Нийслэлийн төсөвт 110,050,027.3 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээс 109,554,253.2 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 99.5 хувиар; Үлдсэн хугацаанд улсын төсөвт 9,870,142.0 мянган төгрөг, нийслэлийн төсөвт 9,767,313.6 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.</li> <li>• Орон нутгийн төсөвт 51,739,438.2 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээс 38,859,688.4 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 75.1 хувиар биелүүлэн ажиллаж байна. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө тасарсан гол шалтгааныг тайлбарлавал :</li> </ul> <p>Дүүргийн 2017 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөнд орон нутагт төвлөрүүлэх Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого 4,170,000.00 мянган төгрөгийн төлөвлөгөөг баталж өгсөн. Засгийн газар, Сангийн яамнаас өгсөн хуваарийн дагуу Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 10/13 тоот тогтоолоор 31,137,000.00 мянган төгрөгөөр хадгаламжийн хүүгийн орлогын албан татварын төлөвлөгөөг</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	СТСХ	ТХ
			100%			

	<p>нэмэгдүүлж 2017 онд иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогоор 35,307,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөгөөг шинэчлэн баталж өгсөн. Сүхбаатар дүүргийн 2017 оны орон нутгийн төсвийн орлогын тодотгосон төлөвлөгөөнд иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогын төлөвлөгөөг аймаг нийслэл, орон нутгийн тооцооны төвүүдийн хадгаламжийн хүүгийн орлогын албан татварыг төв банкинд бүрэн төвлөрүүлж харъяа дүүргийн татварын албанд тайлагнана гэсэн үндэслэлээр төлөвлөгөөг нэмэгдүүлсэн. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр хадгаламжийн хүүгийн орлогод албан татвар ногдуулан, суутгахаар Хувь хүний орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулсан бөгөөд төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.1-т зааснаар орлого нь сум, дүүргийн төсвийн татварын орлого байх, мөн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-т зааснаар суутгагч нь иргэнд олгосон орлогод ногдуулан суутгасан албан татварын хэмжээг тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд тайлагнан тухайн сум дүүргийн төсөвт төлөх зохицуулалттай гэж заасан тул тодотголоор батлагдан ирсэн төлөвлөгөөг биелүүлэхэд хүндрэлтэй байна.</p>				
87	<p>Орон тооны бус байцаагч ажиллуулан хувь хүний орлогын албан татварыг иргэдэд сурталчлах тэдгээрийг татварт бүрэн хамруулж, тайланг хүлээн аван татварын хөнгөлөлт чөлөөлтөнд хамруулж ажиллана.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	СТСХ	ТХ
	<p>Татварын ерөнхий газрын 2017 оны 01/04 албан тоотой өгсөн чиглэлийн дагуу Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн даргын 2017 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/04 дугаар тушаалаар татвар төлөгч иргэдийн хувь хүний орлогын албан татварын тайланг цахим системээр хүлээн авч шалган баталгаажуулах иргэдэд татварын хөнгөлөлт, чөлөөлт эдлүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж ажиллалаа. “Албан татварын хөнгөлөлт, чөлөөлт эдлэх хүсэлт”-ийн загвар болон бүрдүүлэх материалын жагсаалтыг өөрийн албаны цахим хуудаст байршуулан, цахим татварын системээр тайланг хэрхэн тайлагнаж илгээх талаар сургалт зохион байгуулж ажилласан. Хувь хүний орлогын албан татварын тайлан, хөнгөлөлт чөлөөлөлтийн “ТАТВАР ТӨЛӨГЧ ИРГЭН ТА” татварын хөнгөлөлт чөлөөлт эдлээрэй гарын авлагын эх бэлгэж 3000 ш хэвлүүлж “татвар төлөгчийн булан”-д байнга байршуулж татвар төлөгчдөд сурталчлах ажлыг зохион байгуулан ажилласан. Хөнгөлөлт чөлөөлтийн ажлыг 2017 оны 01 дүгээр сараас 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулан 3095 иргэдийн материалыг хүлээн авч ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Гадаад, дотоод сургалтаар -1231 иргэн,</li> <li>• анхан байрны хөнгөлөлт эдлэх-751,</li> <li>• давтан байрны хөнгөлөлт эдлэх-1113 иргэний материалыг хүлээн авч ажилласан.</li> </ul> <p>Иргэний хөнгөлөлт чөлөөлөлтийн тайлан өгсөн 3095 иргэний тайлангийн татварын тооцооллын үлдэгдлийн илүү төлөлтийн баталгаажуулж 2,302,498.5 мянган төгрөгийн буцаан олголтыг Нийслэлийн төрийн сангаас иргэдэд олгосон.</p> <p>ХХОАТ-ын тайлан гаргах талаар татвар төлөгч иргэдэд зориулсан сургалтыг удирдамжийн</p>				70%

	<p>дагуу хуваарь гарган дүүргийн нутаг дэвсгэрт байрлах томоохон зах худалдааны төвд очиж ажлын байран дээр зохион байгуулсан. Сургалтад 32 худалдааны төвийн 1175 татвар төлөгч иргэд хамрагдсан. Татвар төлөгчдийн хуулийн мэдлэгийг дээшлүүлэх, хуулийн дагуу орлого, татвараа үнэн зөв хуульд заасан хугацаанд тайлагнах талаар сургалт зохион байгуулсаны үр дүнд иргэний тайланг 95 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авсан.</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай хороо бүрт орон тооны бус байцаагч хувиарлан ажиллуулж, хорооны дэлгэрэнгүй судалгаа гарган үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг татварт хамруулан ажиллаж байна.</p>				
	Орлогын төлөвлөгөөг хангах аян зохион байгуулах ажлыг дэмжинэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	СТСХ	ТХ
88	<p>Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх ажлын хүрээнд дараахь ажлыг зохион байгуулан ажиллалаа.</p> <ul style="list-style-type: none"> <li>2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Тус татварын хэлтэст Улсын тэмдэгтийн хураамжийн татвар телегчээр бүртгэлтэй Зам тээврийн яам, Гадаад харилцааны яам, БСЧДИХАШ шүүхийн Тамгын газар, ХХЗХороо, ХСУХАТАУ-г зохицуулах зөвлөл зэрэг байгууллагуудад Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тайлангийн маягт, тайлан гаргах аргачлал, тайлангийн хугацаа, татварын орлогын бүртгэлийн талаар сургалт зохион байгууллаа.</li> <li>Хувь хүнээс суутгасан орлогын албан татварын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 5 байцаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын баг бүрдүүлэн Сүхбаатар дүүрэгт үндсэн үйл ажиллагаа эрхэлж байгаа томоохон Аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гарган иргэн болон хуулийн этгээдийг татварт бүрэн хамруулан ажиллаж байна. Орон нутагт төвлөрүүлэх Хувь хүнээс суутгасан орлогын албан татварын төлөвлөгөөг 8,523,213,2 мянган төгрөгөөр баталж 12,690,705.5 мян/төг-ийн орлогыг төсөвт төвлөрүүлж 148,8%-аар төлөвлөгөөг давуулан биелүүлэн ажиллаж байна. 2017 онд Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар төлөгчөөр 183 хуулийн этгээдийг бүртгэж, нийт 1675 аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй байдаг бөгөөд үүнээс 912 аж ахуй нэгж тоотой тайлан, 496 аж ахуй нэгж нь “Х”-ээр тайлангаа илгээсэн байна</li> <li>Татвар төлөгчдөд тайлангийн хугацаанд нийт 70 сургалт зохион байгуулсан бөгөөд шинэ бизнес эрхлэгчдэд 28, бүртгэлтэй бизнес эрхлэгчдэд 42 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан. Сургалтанд хамрагдвал зохих 22400 бизнес эрхлэгчээс 15230 бизнес эрхлэгч сургалтанд хамрагдаж 68 хувийн гүйцэтгэлтэй байна.</li> </ul> <p>Татвар төлөгчдөд Харилцаа холбооны хэрэгслэлээр сануулга илгээж, зөвлөгөө өгөн үйлчилгээ үзүүллээ. SMS мессэжийг 5190 татвар төлөгчдөд илгээж гүйцэтгэл 21,6%, Фэйсбүүкээр 24060 татвар төлөгчдөд мэдээлэл илгээж 100%-ийн гүйцэтгэлтэй, утсаар 13120 татвар төлөгчтэй холбогдсон, биечлэн 21320, ажлын байранд очиж 21682 татвар төлөгчдөд зөвлөгөө мэдээлэл өгөн ажилласан.</p>			100%	



89	<p>НЗДҮАХ-ийн 1.6.8 дахь заалт; 4.2.2 Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хууль, Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль болон бусад татварын хууль тогтоомжийг сурталчилж, хэрэгжүүлэн ажиллана.</p>	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай үл хөдлөх эд хөрөнгийн тооллого явуулж, шинэчилсэн судалгаа гарган, үл хөдлөх хөрөнгийн татварт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>100</p>	<p>СТСХ</p>	<p>ТХ</p>
		<p>Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 01, 02 дугаар албан даалгавар болон Татвар төлөгчийн бүртгэлийг сайжруулж, хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны зорилт, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”, “ Нийслэл хотын албан татварын тухай хууль”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, мөн татвар төлөгчөөр бүртгэгдвэл зохих хуулийн этгээд, хувь хүн, татвар ногдох зүйлийн бүртгэлийн мэдээллийг сайжруулах, татвар төлөгчийн бүртгэлийн программ хангамжийг боловсронгуй болгох, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн байршил, татварт хамрагдалт, хуулийн хэрэгжилтийг тодорхойлох, цаашид хуулийн этгээдийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлийн ажлыг нягт уялдуулах, татварын бааз суурийг нэмэгдүүлэх зорилгоор Татварын ерөнхий газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/190 тоот тушаалаар баталсан Татвар төлөгчийн тооллого хийх ажлын нэгдсэн удирдамжыг удирдлага болгон ажилласан.</p> <p>Удирдамжийн хүрээнд Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн даргын 2017 оны 11 сарын 01-ны өдрийн А/76 тоот тушаал гарган ажлын хэсэг байгуулан ажилласан. Ажлын хэсгийг Дэд дарга Ч.Сүрэнхорлоо /ТУАБ/ ахлан, А.Шинэцэцэг /ТУБ/, Б.Батбаяр /ОТББ/ нарын нарийн бичиг, хэлтсийн нийт байцаагчдын бүрэлдэхүүнтэйгээр 2017 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс .2017 оны 11 дүгээр сарын 25-ны өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт байрлах татвар төлөгчдийг тооллоо.</p> <p>Дүүргийн 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй үл хөдлөх хөрөнгө эзэмшигч, ашиглагч, түрээслэгч, хувь хүн, хуулийн этгээд, төсөвт болон төрийн бус байгууллага, салбар, төлөөлөгчийн газар, сан, сууц өмчлөгчдийн холбоо, төлөөний газар, бизнесийн үйл ажиллагаа явуулж буй төлбөрийн баримт олгох үүрэг бүхий цэгийг татвар төлөгчийн тооллогод хамруулж, байршил харуулах зураглалыг, хороонд байрлан буй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа үл хөдлөх хөрөнгө болон ажлын байр бүрээр гарган батлагдсан маягтын дагуу тооллогыг явууллаа.</p> <p>Тооллогыг явуулахдаа аж ахуйн нэгжийн гэрчилгээ, иргэний үнэмлэх, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, түрээсийн гэрээ, нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн гэрчилгээ, үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ зэргийг шалган тооллогын маягтыг давхар бөглөж, гэрэл зургийг авч хавсарган нэгтгэлийг эксел дээр хийж тооллогын нарийн бичигт өдөр бүр хүлээлгэн өгч ажилласан.</p> <p>Тооллогын нарийн бичгүүд нэгтгэл, фото зургийг файлаар хороо тус бүрээр нэгтгэн архивлаж удирдлага болон холбогдох газруудыг тухай бүр мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>Тооллогод 3292 аж ахуйн нэгж, 3150 иргэн, 42 худалдааны төвийн нийт 6484 татвар төлөгчдийг хамрууллаа. Тооллогын явцад татварын албанд бүртгүүлээгүй 4 аж ахуйн нэгж, 63 иргэнд бүртгүүлэх тухай албаны мэдэгдэл, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлээгүй 95 аж ахуйн нэгж, 92 иргэнд албан шаардлага, цахим төлбөрийн баримтын</p>				

	системд холбогдоогүй, нэгдсэн системд холбогдсон хэдий ч төлбөрийн баримт олгохгүй байгаа 104 аж ахуйн нэгж, 215 иргэнд албан шаардлага, Нийслэл хотын албан татвар төлөгчөөр бүртгүүлээгүй болон төлбөрийн баримтанд бодогдохгүй байгаа 12 аж ахуйн нэгж, 1 иргэнд албан шаардлагыг тус тус өгч ажилласан.				
	Томоохон худалдаа үйлчилгээний төв, дэлгүүр, захуудад нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, нийслэл хотын албан татварын тухай хуулийг сурталчлах, гарын авлагаар ханган мэдээлэл өгөх, хуулийг хэрэгжүүлэх аян зохион байгуулж татварын орлого бүрдүүлэлтийг ханган ажиллана.	Хуулийн хэрэгжилт, хувиар	100	СТСХ	ТХ
90	<p>Татварын ерөнхий газрын даргын 2017 оны 03 дүгээр сарын 15-ны өдрийн А/59 тоот тушаал, Нийслэлийн татварын газрын даргын А/75 тоот тушаалыг чиглэл болгон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор дүүргийн татварын хэлтсийн даргын 2017 оны 03 сарын 22-ны өдрийн А/09 тоот Ажлын хэсэг байгуулах тухай тушаал гарган хавсралтаар ажлын төлөвлөгөө, нэгдсэн удирдамжыг батлан ажиллаж байна.</p> <p>Төлөвлөгөөний дагуу дүүргийн Засаг даргатай дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийн хууль хэрэгжилтийн байдалд хамтран хяналт тавих, төсвийн орлогыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор санамж бичиг, Хэрэглэгчдийн систем нийлүүлэгчдийн холбоо, Монгол такс ТМЗ ХХКомпаниудтай нийгмийн сайн сайхны төлөө тэгш эрхэт оролцоог дээдлэн хувь хүн, бүлэг, олон нийтийн санхүү, татварын боловсролыг дээшлүүлж, Татвар төлөгчдийн татвараа өөрөө тодорхойлон төлөх үүрэг, системийг сайжруулах, Татвар төлөгчийн нийгмийн сэтгэлзүйг төлөвшүүлэх замаар төрийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах зорилгоор гурван талт хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна.</p> <p>Удирдамжийн хүрээнд байцаагчдыг баг болгон дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 29 худалдааны төв, 61 зочид буудал, 397 ресторан бар, 41 эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл авсан эмнэлэг, эмийн сан, 139 үсчин, гоо сайхан, 40 нотариат, 19 фитнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэдийн ажлын байранд очиж, татварын хууль тогтоомжийг тайлбарлан таниулж зөвлөгөө өгөх, зөрчил гаргасан татвар төлөгчийн зөрчлийг арилгуулах, хариуцлага тооцож ажиллах талаар сануулга өгч ажилласан.</p> <p>Шалгалтын явцад 45 татвар төлөгчийг нэгдсэн системд, 50 татвар төлөгчийг нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгэж, төлбөрийн баримт олгохгүй байгаа болон зөрчил гаргасан татвар төлөгчид татварын албаны 1593 татвар төлөгчдөд татварын албаны шаардлага хүргүүлж, шаардлага биелүүлээгүй 70 татвар төлөгчид шийтгэврийн хуудсаар 24,747.2 мянган төгрөгийн шийтгэл ногдуулан төлөөгүй татвар төлөгчдийн төлбөрийг барагдуулахаар ажиллаж байна. 2017.07.01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 14 татвар төлөгчид зөрчлийн хэрэг нээн 6,050.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж, 4 татвар төлөгчид холбогдох гомдлыг хуульд</p>				100%

		<p>заасны дагуу хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан.</p> <p>Татварын ерөнхий газрын Татварын үйлчилгээний төвийн 1800-1288 утсанд 401 гомдол, засгийн газрын 11-11 төвд ирсэн 26 гомдол нийт 427 гомдлын дагуу цахим төлбөрийн баримт олгохгүй байгаа бизнес эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийн ажлын байранд очиж, татварын хууль тогтоомжийг тайлбарлан таниулж зөрчлийг тухай бүр арилгуулж, давтан зөрчил гаргаж байгаа татвар төлөгчдөд шаардлага өгч, хариуцлага тооцсон.</p> <p>Татварын байцаагчдыг Татварын ерөний газар болон Нийслэлийн татварын газраас зохион байгуулсан Tax Inspector програмын апплекейшн хэрэглэх, утсанд хэрхэн суулгах сургалт, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн Захиргааны тасаг, Сүхбаатар дүүргийн Прокурорын газартай хамтран Захиргааны арга хэмжээ авах талаар сургалт зохион байгуулж, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хэрэгжүүлээгүй аж ахуйн нэгж, иргэнд захиргааны хариуцлага ногдуулж, шийтгэврийн хуудас хэрхэн бичих талаар гарын авлага гарган байцаагчдад өгч ажилласан.</p> <p>Дүүргийн татварын хэлтсийн facebook хуудсаар 312 удаагийн мэдээ, мэдээлэл байршуулж, нэг цэгийн үйлчилгээний заалаар 2160, утсаар 2615 татвар төлөгчид зөвлөгөө өгч, Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх баримтын жагсаалт, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Ebarimt хэрхэн ашиглах вэ?, Шинэ хэрэглэгчээр хэрхэн бүртгүүлэх вэ? гэсэн гарын авлагуудыг байрлуулж татвар төлөгчдөд тараан ажиллаж байна.</p> <p>Татвар төлөгчдийн өдрүүдийн хүрээнд Одкон, Жоби, Цогтбаян барилгын материалын худалдааны төвд Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилт, и-баримтыг хэрэглээ болгосны үр дүнд иргэдэд ирэх үр өгөөжийг таниулан сурталчилж, зөвлөгөө өгч, асуулт хариултын АХА тэмцээн зохиосон.</p> <p>Дүүргийн татварын хэлтэс, Монгол такс ТМЗ ХХК-тай хамтран Соёмбо, Бүрд худалдааны төв, Видал үсчин, гоо сайхны салон, Соёмбо бичиг хэргийн дэлгүүр, Ком тавилга ХХК-ийн 67 татвар төлөгчид сургалт зохион байгуулж, зөвлөгөө, гарын авлага өгч ажилласан.</p>				
91		<p>Алслагдсан хорооны нутаг дэвсгэрт байршилтай үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж болон иргэдэд Татварын ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгөх зорилгоор байцаагчийг алслагдсан хороодод байрлан ажиллах нөхцлөөр хангана.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>100</p>	<p>СТСХ</p>	<p>ТХ</p>
		<p>Хороо хариуцсан байцаагчид өөрсдийн хариуцсан хороон дээр татварын хураалт хийх болон хууль тогтоомжийг сурталчилах явцдаа иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөн ажиллаж байна.</p> <p>Татвар төлөгчдийн баярын өдрийг тохиолдуулан дүүргийн 1-20 хороон дээр хороо хариуцсан байцаагчид 2017 оны 05 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд 10.00-16.00 цагийн хооронд ажиллаж татвар төлөгчдөд хүрч үйлчлэн иргэдэд татварын талаарх мэдээ мэдээллийг өгч татварын хууль тогтоомжтой холбоотой танилцуулга, зөвлөгөө өгөн ажиллалаа. Дүүргийн хорооны оршин суугчдын цахим групп болон байрны мэдээллийн самбарт “Татвар төлөгчдийн өдрүүдийг тохиолдуулан” хорооны байранд татварын байцаагчид зөвлөгөө өгч ажиллаж</p>			<p>100%</p>	

	байгаа тухай зарыг байршуулж ажилласан. Дүүргийн 1-15 хороон дээр Татвар төлөгчдөд зориулсан татварын албаны мэдээллийн самбарыг шинээр хийлгэн байршуулж иргэдэд цаг үеийн татварын мэдээ мэдээлэлтэй холбоотой асуудлыг байнга байршуулан ажиллаж байна.				
92	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдол, авто зам ашигласны төлбөрийг төлөх цэгүүдийг гарган ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	СТСХ	ТХ
	Нэг цэгийн үйлчилгээний зааланд 5 байцаагч авто тээврийн хэрэгслийн албан татварыг хүлээн авч ажиллаж байна. 2017.03.28-ны өдрөөс эхлэн Саруул, Сансар 32 худалдааны төвүүдэд татвар хураах нэмэлт цэг гарган ажилласан.				70%
93	Авто тээврийн үндэсний төвөөс ирдэг судалгааг үндэслэн татвар төлөөгүй тээврийн хэрэгслийг мэдээллийн хэрэгслээр цацан, олон нийтэд хуулийг сурталчилж татварын өрийг барагдуулан ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	СТСХ	ТХ
	Дүүргийн Татварын хэлтсийн Facebook цахим хаягт АТБӨЯХАТ, АБТ, АЗАТ хураахтай холбоотой мэдээллийг байршуулсан. ТВ9, НТВ, С1 телевизэд АТБӨЯХАТ, АБТ, АЗАТ хураах үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, NTV телевизийн “Зочны цаг” буланд оролцож авто машинтай иргэдэд дугаарын хязгаарлалтын дагуу тухайн сардаа багтан албан татвараа төлөхийг анхааруулсан мэдээлэл хийсэн. Мөн Нийслэлийн татварын газраас гаргасан танилцуулгыг татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлж буй нэг цэгийн үйлчилгээний цэгүүдээр байршуулж танилцуулж ажилласан. Нэмэлт цэгүүд гаргасантай холбогдуулж сурталчилгааны материалыг сүлжээнд байршуулж, үйлчилгээний цэгүүдийн самбарт байршуулах зэргээр олон нийтэд сурталчилгаа хийсэн. 11 сарын байдлаар урьд оны АТБӨЯХАТ-ын 413,2 сая төгрөгийн өрийг барагдуулан ажилласан. 2017 оны АТБӨЯХАТ-т 4.529,125,4 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Үлдсэн хугацаанд 100 сая төгрөг АТБӨЯХАТ-т төвлөрүүлэх зорилттой ажиллаж байна.				100%
94	Хог хаягдлын хураамж төлөгчдийн нарийвчилсан судалгааг гарган, хог хаягдлын гэрээ хийгдээгүй үйл ажиллагаа явуулж буй иргэн болон хуулийн этгээдийг татварт хамруулан ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	СТСХ	ТХ
	2017 оны орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөнд Хог хаягдлын хураамжийн төлөвлөгөөг 1,966,000.0 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээс 1,610,247.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 81,9 хувийн гүйцэтгэлтэй байна. Дүүргийн нутаг дэвсгэрт хог хаягдал тээвэрлэдэг нэр бүхий 5 аж ахуй нэгж байгууллагын үйлчилгээний хураамж төлөлтөнд хяналт шалгалт хийх, хог хаягдлын хураамжийн орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 24–				100%

		<p>ний өдрийн А/351 дүгээр захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулан дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын хог тээврийн гэрээ байгуулсан байдал, гэрээний биелэлтийг сайжруулах, хог хаягдлын хураамжийн орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх, зөрчилтэй аж ахуйн нэгж байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцон Хүнс, Худалдаа Үйлчилгээний Хэлтэс, Тохижилт, Нийтийн аж ахуйн хэлтсийн ажилчидтай хамтран ажиллаж байна. Ажлын үр дүнд Хог хаягдлын тээврийн гэрээг 174 хуулийн этгээдтэй шинээр байгуулж, 144 хуулийн этгээд болон иргэнд мэдэгдэх хуудас гардуулж, 49,895,0 мянган төгрөгний өр барагдуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд Хог хаягдлын хураамж төлөгчийн судалгааг шинэчилсэн байдлаар дахин гаргаж, хог хаягдлын хураамж төлөгчөөр 141 иргэн, хуулийн этгээдийг бүртгэж Хог хаягдлын хураамжийн төлөвлөгөөг биелүүлэх бүрэн боломжтой болсон.</p> <p>Нийслэлийн зургаан дүүргийн татварын албаны орон нутгийн төсөвт төвлөрүүлж байгаа Хог тээвэрлэлтийн үнийн тарифт төрөл бүр дээр нь харьцуулсан судалгаа хийж / дүүргийн нутаг дэвсгэрт байрлах алслагдсан хороод, зарим үйлчилгээний төвүүдийн онцлог байдал, өнөөдөр бодит байдалд төлж байгаа тарифийг харгалзан үзсэн болно/ Хог тээвэрлэлтийн хураамжийн хэмжээнд өөрчлөлт оруулах санал, судалгааг боловсруулан Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт урьдчилсан байдлаар хүргүүлсэн.</p>				
<b>4.3 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.</b>						
95	НЗДҮАХ-ийн 4.2.16 дахь заалт; 4.3.1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.	Эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ЭМТ, ӨЭМТ
		<p>-ЭМТ, ӨЭМТ-ийн хүний нөөцийн чадавхижуулах чиглэлийн сургалтын төлөвлөгөөний дагуу 10 удаагийн давхардсан тоогоор 477, төлөвлөгөөт бус, цаг үеийн асуудлаар 3 удаа 232, Эмнэлзүйн тохиолдолд суурилсан сургалт 10 удаа 185, журнал клуб 3 удаа 58 буюу давхардсан тоогоор 952 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулсан.</p> <p>-“Гамшиг онцгой байдлын үеийн бэлэн байдал, төлөвлөлт”, Эрүүл мэндийн сургалт сурталчилгааг үр дүнтэй зохион байгуулах нь”, “Хавдрын молекул, генетикийн шинжилгээ, ач холбогдол”, “Тарваган тахал өвчний үеийн тохиолдол бэлэн байдал”, Амилуулах суурь тусламж” сэдэвт 5 удаагийн сургалтад ЭМТ, ӨЭМТ-ийн 215 эмч, мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>-ТТӨ-ний дэгдэлтийн үеэр дүүргийн Нэгдсэн эмнэлэгт ӨЭМТ-ийн 26 залуу эмч жижүүрт гарган, дадлагажуулсан.</p> <p>-ДЗОУБ-ын Налайх-2 ОНХХ-ийн 2,500,000 төгрөгийн дэмжлэгээр 2017 оны 03 дугаар сарын 25-ны өдөр дүүргийн "Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал" салбар дундын уулзалт зохион байгуулав. Уулзалтад АШУУИС-ийн зөвлөх багш нар, нийслэлийн харъяа Эрүүл мэндийн төвийн дарга, холбогдох мэргэжилтэн, дүүргийн ЗДТГ, ЭМТ, ӨЭМТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч 105 мэргэжилтэн хамрагдаж, төлөвлөгөө гарган ажилласны дүнд жирэмсний 1278 эх жирэмсний хяналтад орсон. Эрт хяналтын хувь 80%, амьгүй төрөлт 6 буюу өмнө оны мөн үеэс 4,1, гэрийн төрөлт 6 буюу</p>	100%			

		<p>өмнө оны мөн үеэс 0.09, хяналтгүй төрөлт 7 буюу өмнө оны мөн үеэс 0,08, 0-1 насны хүүхдийн эндэгдэл 11 буюу өмнө оны мөн үеэс 6, эрт нярайн эндэгдэл 8 буюу, өмнөх оны мөн үеэс 2,3, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 буюу өмнөх оны мөн үеэс 0,5 промилээр тус тус буурсан.</p> <p>- Бүгд найрамдах Турк улсын Стамбул хотын хөрөнгө оруулалт, “Тика” төслийн буцалтгүй тусламжаар 1800 өрхийн 7000 орчим иргэнд үйлчлэх, олон улсын стандартад нийцсэн жишиг Өрхийн эмнэлэг барих барилгын шав тавих ёслолын үйл ажиллагааг 2017 оны 06 дугаар сарын 21-ний өдөр зохион байгууллаа.</p> <p>-Жайка ОУБ-ын “Өвсний Үндэс” дэд төслийн хүрээнд 2017 оны 08 дугаар сарын 17-25-ны өдрүүдэд "Цусны даралт ихсэх өвчнөөс сэргийлэх сувилагчийн хүний нөөцийг хөгжүүлэх" нь сэдэвт дадлага, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, ЭМТ, ӨЭМТ-ийн 31 сувилагч хамрагдан, цусны даралт өвчнөөс сэргийлэх, цусны даралт ихсэлттэй үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх мэдлэг, ур чадвараа дээшлүүллээ. Мөн Япон улсад 2017 оны 10 дугаар сард ЭМТ-өөс 1 эмч, 1 сувилагч, 7 дугаар хорооны 1 сувилагч туршлага солилцоод ирсэн.</p> <p>-Эрүүл мэндийн төв, ӨЭМТ-ийн эмч, мэргэжилтнийг чадавхижуулах төлөвлөгөөний дагуу 19, төлөвлөгөөт бус, цаг үеийн асуудлаар 3, эмнэлзүйн тохиолдолд суурилсан сургалт 15, журнал клуб 5 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 1428 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамруулж, тэдний ур чадварыг дээшлүүлснээр талархлын тоо 18,3%-иар өссөн.</p> <p>- Дүүргийн Засаг даргын 2017.09.15-ны өдрийн Өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих Эрүүл залуус аян зохион байгуулах тухай А/304, Эрүүл мэндийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах тухай А/303 дугаар захирамжаар ЭМТ, ӨЭМТ-д тэмбүү, ДОХ, сахар, холестрин илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт шаардагдах оношлуур материал авахад 8,915,000 төгрөг шийдвэрлэсэнээр халдварт, халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт иргэдийн хамрагдалт өмнө оны мөн үеэс нэмэгдсэн.</p> <p>-ДЭМБ-ын дэмжлэгтэй “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ болон олон нийтийн түвшинд эрүүл мэндийн мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь 2017” төслийг алслагдсан 20 хорооны “Гэрэлт манал” ӨЭМТ-д хэрэгжүүлж, 26,601,500 төгрөгний багаж тоног төхөөрөмж, оношлуур нийлүүлэгдсэнээр “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчимтай явуулын үйлчилгээг гэрийн эргэлттэй хослуулж, халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх боломж бүрдсэн. Төслийн хүрээнд 2017 оны 5-10 дугаар сар хүртэлх хугацаанд 3543 хүн буюу нийт хүн амын 79%-ийг хамруулсны үр дүнд 8 төрлийн шинжилгээгээр 460 өвчлөлийн тохиолдол ирлүүлж, дараагийн шатлалд илгээсэн.</p> <p>-13-17 дугаар хорооны ӨЭМТ-д 10,250,000 төгрөгний үнэ бүхий 5 ширхэг нярайн шарлалт хэмжих билиметр багаж нийлүүлснээр, нярайн тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж, 2017 оны эхний 10 сарын байдлаар 674 хүүхдийн оношилгоонд хамруулсны шарлалттай 321 хүүхэд илрүүлж, 81,6% /262/-ыг гэрээр эмчилж, 18,4% /59/-ыг дараагийн шатлалын эмнэлэгт илгээж, хүндрэлээс сэргийлэн ажилласан.</p>				
96		Эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарыг хөдөлмөрийн чадвар алдалтын болон	Үйл ажиллагааны	100	НХХ	ЭМНДХ

		хөдөлмөрийн чадвар түр алдалтын, эмнэлгийн хуудасны олголт бичилтийн талаар эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж, сургалт зохион байгуулна.	хэрэгжилт, хувиар			
		-Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт 2017 оны 02 дугаар сарын 09-ны өдөр Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 сарын 26-ны өдрийн “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай” хамтарсан А/39,А/12 тоот тушаалыг танилцуулсан цахим хурал, 2017.02.22-нд ЭМНДЕГ-ын Хөдөлмөрийн чадвар түр алдалтын тухай семинар, 2017.0315-нд ЭМНДЕГ-ын ЭХМТК-оос ЭХМК-ын программ хангамжид өөрчлөлт оруулах тухай хурал тус тус зохион байгуулсан. -Дүүргийн ЭМНДХ-тэй хамтран 2017.04.28-ны өдөр “Монгол улсын нийгмийн даатгалын тогтолцоо, нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол” сэдэвт сургалт зохион байгуулж, сургалтад ЭМТ, ӨЭМТ-ийн 51 эмч хамрагдаж, нийгмийн даатгалын ач холбогдол, хэрэглээний талаарх мэдлэгээ дээшлүүлсэн.				100%
		Өрхийн эрүүл мэндийн төвийн 3 талт гэрээгээр бүрэн хангалттай үнэлэгдсэн өрхийн эрүүл мэндийн төвийг шагнаж урамшуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ЭМТ, ӨЭМТ
97	4.3.3. Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй 3 талт гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцон ажиллана.	-Өрхийн эмнэлгийн үйлчилгээг гүйцэтгүүлэх гурван талт гэрээний шалгуур үзүүлэлтийн дагуу 2016 онд гэрээний үүргээ амжилттай биелүүлж, Бүрэн хангалттай үнэлэгдсэн 2,3,7,9,10,11,13,14,17 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн хамт олныг дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/65 дугаар захирамжаар 1,260,000 төгрөг шийдвэрлэн, шагнаж урамшууллаа. -Нийслэлийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулах тухай А/93 дугаар захирамж, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийг хангуулах тухай А/20 дугаар тушаалын дагуу 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдөр дүүргийн Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарын хооронд 2017 онд хамтран ажиллах 3 талт гэрээ байгууллаа. /Гэрээ № 50-67/ Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор бүхий байртай 14 Өрхийн эрүүл мэндийн төвийн дулааны зардлыг хариуцах ашиглалтын гэрээ байгуулав. /Гэрээ №36-49/ -Дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тухай А/68 дугаар захирамжаар батлагдсан дүүргийн Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2017 оны 06 дугаар сарын 27,28,29,30-ны өдрүүдэд 1-20 дугаар хорооны ӨЭМТ-ийн 3 талт гэрээний гүйцэтгэлийн гэрээ дүгнэлээ. 2017 оны хагас жилийн гэрээний үнэлгээгээр Бүрэн хангалттай буюу А үнэлгээтэй 7, Хангалттай буюу В үнэлгээтэй 10, Хангалтгүй буюу С үнэлгээтэй дүгнэгдсэн ажил сайжруулах 1				90%

		<p>ӨЭМТ байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээний биелэлтийн дундаж 87,7%-тай дүгнэгдсэн.</p> <p>-Дүүргийн Засаг даргын 2017 оны 02 сарын 24-ний өдрийн А/68 дугаар захирамж, ЭМТ-ийн даргын 2017 оны 1 дүгээр сарын 26-ны А/07 тушаалын дагуу ӨЭМТ-ийг мэргэжил арга зүйгээр хангах, мэргэжилтнүүдийн ажиллах хуваарь баталж, Эх, хүүхдийн эрүүл мэнд, сувилахуй, статистик, мэдээлэл технологи, сорьц тээвэрлэлт, дархлаажуулалт, хөтөлбөр-стратегийн хэрэгжилт, удирдлага зохион байгуулалтын дагуу 11 чиглэлээр 82 удаагийн явцын дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгч ажилласнаар анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмж дээшилж, иргэдийн сэтгэл ханамж 5 хувиар өссөн.</p>				
<b>4.4 Иргэн бүрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэнэ.</b>						
		Халдварт бус өвчний эрт илрүүлгийг эрчимжүүлэх, дүүргийн дэд хөтөлбөр хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг хийж өмнөх оны хүрсэн түвшнээс ахиулах, өрхийн эрүүл мэндийн төвийг хурдавчилсан оношлуураар хангах, нарийн мэргэжлийн эмч нар өрхийн эрүүл мэндийн төвд дэмжлэгт хяналт хийж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	100	НХХ	ЭМТ, ӨЭМТ
98	НЗДҮАХ-ийн 4.2.1 дахь заалт; 4.4.1. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлж иргэдийг чихрийн шижин, цусны даралт ихсэх, хорт хавдар зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт жилд нэг удаа хамруулж эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллана.	<p>-Халдварт бус өвчнийг бууруулах, эрт илрүүлэгт хамрагдалтыг эрчимжүүлэн ажилласнаар артерийн гипертензи өвчний эрт илрүүлэг үзлэгт дүүргийн зорилтот бүлгийн 23054 иргэнээс 16734 хүн /72,6%/-ийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 49,95%-иар, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 16402 хүн /71,1%/ буюу өмнөх оны мөн үеэс 50,53%-иар ахиулсан.</p> <p>-Умайн хүзүүний хавдар илрүүлэх үзлэгт зорилтот бүлгийн 5372 хүн, үүнээс 2525 /47%/-ийг, хөхний үзлэгт 4110 хүн хамруулсан.</p> <p>-Эрт илрүүлэг үзлэгийн дүнд артерийн гипертензи өвчний тохиолдол 149, чихрийн шижин хэв шинж II 89, умайн хүзүүний хавдар 4, хөхний хавдар 4 тохиолдол шинээр илрүүлж, эмчийн хяналтанд авсан.</p> <p>-НЭМГ, дүүргийн ЗДТГ, ЭМТ хамтран 2017-2019 онд Японы Жайка байгууллагын Өвчний үндэс техникийн хамтын ажиллагааны Орон нутгийг хөгжүүлэх тусгай хөтөлбөрийн хүрээнд “Амьдралын буруу хэв маягаас урьдчилан сэргийлэх” төсөл хэрэгжүүлж, ЭМТ, ӨЭМТ-ийн эмч мэргэжилтнийг чадавхижуулах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж, 80 хүнээс артерийн даралт ихсэлтийн талаарх мэдлэг хандлагыг үнэлэх судалгаа авч дүгнэлт хийн, дотоодод 32 эмч, сувилагч, Япон улсад 1 эмч, 2 сувилагчийг сургалтад хамруулж, ур чадварыг нэмэгдүүлсэн.</p> <p>-Дүүргийн Засаг даргын Өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих Эрүүл залуус аян, Эрүүл мэндийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах тухай А/303, А/304 дугаар захирамж, Төрийн байгууллагуудаас иргэдэд ажлаа сурталчлах Нээлттэй хаалганы өдөрлөг, Автомашингүй өдөрлөгийн хүрээнд ЭМТ, ӨЭМТ 1541 хүнд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, 1176 хүнд 5 төрлийн шинжилгээ хийж, 72 төрлийн 2100 ширхэг сургалт сурталчилгааны материал тараасан.</p>				100%



	<p>-ЭМТ, ӨЭМТ, хорооны ЗДАА хамтран “Хүүхдийн түлэгдэлт, түүнээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх нь” сэдэвт 157 удаагийн сургалтад 36 цэцэрлэгийн 441 багш, 1116 эцэг, эх, цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийн 491 эцэг, эх хамрагдан, сургалтын өмнөх дараах тестийн үнэлгээний дүнгээр эцэг, эхчүүдийн мэдлэг 35 хувиар дээшилсэн /сургалтын өмнө-49%, сургалтын дараа-84%/. Хүүхдийн осол гэмтэл, түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж, 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зарласан “Хүүхдийн түлэгдэлт-эцэг эхийн хариуцлагаас” сэдэвт сарын аяны төлөвлөгөө хэрэгжилтийг 100% биелүүлж, бага насны хүүхдийн эрүүл мэнд, амь нас, амьдралын чанарын асуудалд эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлага, аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор дүүргийн Засаг дарга уриалга гаргав. Уриалгын хүрээнд дүүргийн Засаг даргын 2017.02.21-ний өдрийн А/63 дугаар захирамжаар Төрөлжсөн сургалттай Биеийн тамирын дунд сургуулийн түлэгдэлтийн III зэргийн оноштой М.Номин-Эрдэнийн эмчилгээний зардалд Орон нутгийн нөөц хөрөнгөөс 1000000 /нэг сая/ төгрөг шийдвэрлэв. Дээрх үйл ажиллагааны үр дүнд 2017 оны 10 сарын байдлаар осол гэмтлийн шалтгаант хүүхдийн нас баралт 1 тохиолдлоор, өвчлөл 54 тохиолдлоор буурсан.</p> <p>-АШУҮИС-ийн НЭМС, АУС-ын ДЭМБ, Японы Улсын их сургууль болон холбогдох байгууллагатай хамтран Монгол улсын хэмжээнд 10-64 насны хүн амын дунд гепатитын В,С вирусийн халдварын эпидемиологийн онцлогийг тодорхойлж, элэгний хатуурал, хавдрыг эрт илрүүлэн, хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн хамаарлыг урт хугацаанд судлах “Хавдарын үндэсний когорт судалгаанд” Гэрэлт манал ӨЭМТ 20 дугаар хорооны зорилтот бүлгийн 290 хүнийг үзлэг, шинжилгээнд хамруулав.</p> <p>-2017 оны эхний хагас жилд Олон нийтийн эрүүл мэндийн боловсорлыг дээшлүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, Амьсгалын замаар дамжих халдварт өвчний чиглэлээр ЭМС-ын 01, 03 албан даалгавар, Осол гэмтлээс сэргийлэх, хавдараас сэргийлэх, Архидан согтуурахтай тэмцэх 10 хоног, Чих сонсгол хамгаалах, Бөөр хамгаалах өдөр, Глаукүматай тэмцэх 7 хоног, Давсны хэрэглээг бууруулах дэлхийн 7 хоног, Харшилтай тэмцэх өдөр, дэлхийн эрүүл мэндийн өдөр, Амны эрүүл мэнд, Сүрьеэтэй тэмцэх өдөр, Дэлхийн тамхигүй өдрүүдийн хүрээнд ӨЭМТ-үүдтэй хамтран байгууллагын цахим хуудсаар иргэдэд тогтмол мэдээлэл хүргэж, 454 сургалт, 75 өдөрлөг, сурталчилгаа зохион байгуулж, 118 төрлийн 30239 төрлийн сургалт сурталчилгааны материал тарааж, 38474 хүнийг хамруулсан.</p> <p>-Сүхбаатар ЭМТ, 1-6 дугаар хорооны ӨЭМТ-тэй хамтран 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр “Эрүүл зөв дадал-эрүүл мэнд” сэдэвт өдөрлөг зохион байгуулж, 100-аад иргэн хамрагдав. Өдөрлөгийн үеэр дүүргийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн талаар мэдээлэл өгч, БЖИ тогтоох, цусан дахь өлөн үеийн глюкоз тодорхойлж, нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.</p> <p>-Дүүргийн ЗДТГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/50 дугаар тушаалаар дагуу 2017 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр ХСҮТ-д нарийн мэргэжлийн мэс засал, дотор-уушги-зүрх судас, толгой хүзүүний мэс засал, рентген, хэт авиа, эмэгтэйчүүд зэрэг 6 төрлийн үзлэг шинжилгээнд ЗДТГ, хороодын нийт 142 ажилтан албан хаагч хамрагдахаас 86 албан хаагч хамрагдан, тэдэнд нарийн мэргэжлийн эмч нар зөвлөгөө өгч, хэвтүүлж эмчлүүлэх боломж</p>	
--	--	--

		<p>бүрдүүлэн, эмчилгээнд хамрууллаа.</p> <p>-Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийн хүрээнд ЭМТ, хорооны ЗДАА, ӨЭМТ хамтран эрүүл мэндийн сайн дурын туслагч, хорооны хэсгийн ахлагч, иргэдэд үйлчлүүлэгчдэд сургалт, өдөрлөг зохион байгуулж, 4522 хүн хамруулсан. Хепатитын В, С вирусийн эрт илрүүлэг шинжилгээнд 40-65 насны зорилтот бүлгийн 16023 иргэнд утсаар, 6112 иргэнд шинжилгээнд хамрагдах урилга тараан, орц, гудамжны мэдээллийн самбар, 135 дэлгүүр, 35 цайны газар, 11 буудал, 32 үсчин, 18 авто засвар, 7 худалдааны төв зэрэг 238 аж ахуй нэгжүүдэд 2082 Хепатитийн В, С вирусийн эрт илрүүлэг, шинжилгээний мэдээлэл бүхий зарлал байршуулж, “Хепатитын эсрэг дэлхийн өдөр” өдөрлөгөөр давхардсан тоогоор 43889 хүнийг мэдээлэл, сурталчилгаанд хамруулсан. Дүүргийн хэмжээнд зорилтот бүлгийн 17948 хүнийг илрүүлэг шинжилгээнд хамруулахаас 2017 оны 09 сарын 08-ны байдлаар 12602 хүн хамруулсан. Үүнээс С вирүстэй - 2312, В вирүстэй – 779 хүн илэрсэн. Хамралтын хувь – 70,21%. В вирүсийн эсрэг сэргийлэх тарилгын 2 дах тунд хамрагдвал зохих 2589 хүнээс 2116 хүн хамрагдсан. Хамрагдалт 81,7% байна.</p>							
99	<p>НЗДҮАХ-ийн 4.2.2 дахь заалт; 4.4.2. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.</p>	<p>Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаа явуулах, амны хөндийн өвчлөлийг эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулахад нэг удаагийн багажаар хангах, үзлэгийн хүрсэн түвшинг өмнөх оноос ахиулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	НХХ	БХ, ЭМТ, ӨЭМТ			
		<p>-Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах 50 цэцэрлэгийн 11240, цэцэрлэгт хамрагдаагүй 2483, 29 ерөнхий боловсролын сургуулийн 24455 хүүхдийн 50%-ийг буюу 12227 хүүхдийг хамруулах зорилт тавьж ажилласан. 2017 оны эхний 4 сард 7037 хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийснээс 66,7% нь шүд цоорлын өвчтэй илэрснийг, эрүүлжилтийн төлөвлөгөө гарган, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох зөвлөгөө мэдээлэл өгсөн.</p> <p>-Амны хөндийн эрүүл мэнд сэдвээр 52 сургалт, 11 удаагийн сурталчилгааны ажил зохион байгуулж 592 эцэг эх, багш ажилтан, ЕБС-ийн 2387 хүүхэд нийт 2979 хүнийг хамруулсан.</p> <p>-Амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах зорилгын хүрээнд дүүргийн хамтын ажиллагаатай Японы Саку хотын удирдлагад Шүд эрүүл бол бие эрүүл төслийн саналаа танилцуулаад байна.</p> <p>-Хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 20 дугаар хорооны ИТХ-ын дарга Б.Энхболд Салбар амбулатори 2-ийн шүдний кабинетад эм, эмнэлгийн хэрэгслийн зориулалтын 2 ширхэг шүүгээ хандивласнаар ариутгалын багажны хадгалалтын чанар сайжирсан.</p>			100%				
100	<p>НЗДҮАХ-ийн 4.2.3 дахь заалт; 4.4.3. Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг сайжруулж, эмчилгээний хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлнэ.</p>	<p>Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлэг сайжруулах, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	НХХ	ЭМТ, ӨЭМТ, Хорооны ЗДАА			
		<p>-Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгт Этүгэн их сургуулийн Анагаахын 4-р курсийн 210 оюутан, орон</p>			100%				

	<p>гэргүй тэнэмэл 124, ШУТИС, ХУИС, Этүгэн их сургуулийн дотуур байрны 519 оюутан, НЭМГ-ын 2017 оны “Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах тухай” 01 албан даалгаврын дагуу Эрүүл мэндийн төвийн 216 ажилтан, дүүргийн Засаг даргын 2017 оны “Өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих Эрүүл залуус аян зохион байгуулах тухай” А/304 дүгээр захирамжийн дагуу ЕБС-ийн 11,12-р ангийн 533 сурагч, нийт 1602 хүн хамруулсанаар сүрьеэгийн 6 шинэ тохиолдол илрүүлж, хяналтанд авсан. Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт өмнө оны мөн үеэс 15,9%-иар өссөн.</p> <p>-Амбулаториор сүрьеэгийн 153 шинэ тохиолдол илэрсэн нь өмнөх оны мөн үеэс 17 тохиолдлоор буурсан.</p> <p>-Бүх хэлбэрийн сүрьеэгийн шинэ тохиолдлын илрүүлэлтийн хувь 62,7%, уушигны судлалын шинжилгээгээр батлагдсан сүрьеэгийн шинэ тохиолдлын эдгэрэлтийн хувь 71,6%.</p> <p>-Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ болон эмэнд мэдрэг сүрьеэтэй өвчтнүүдийг ХДХВ-ийн шинжилгээнд 96,3% тай хамруулсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7%-иар өссөн.</p> <p>-Маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэ илрээгүй, олон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй 13, цөөн эмэнд тэсвэртэй 10 тохиолдол илрүүлж, 100% эмчилгээнд хамруулсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдлоор буурсан. ХӨСҮТ-ийн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмч нарын зөвлөгөөнөөр 39 өвчтний асуудал хэлэлцүүлсэн. Өдрийн эмчилгээний цэгээр эмэнд тэсвэртэй 18 өвчтөн эмчилгээ хийлгэж байна.</p> <p>-ЭМТ-ийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 29-ны Цөөн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн “Зөвлөгөөний баг томилох тухай” А/64 дугаар тушаалыг 10 дугаар сарын 1-нээс мөрдөн хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>-“Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн үндэсний тандалт судалгаа-III “-г 2016 оны 2-р сараас эхлэн 2017 оны 2-р сарын 1 хүртэл лабораториор түрхэц эерэг оношлогдсон нийт 83 хүний 31 удаагийн сорьц зөөвөрлөлтөөр ОЭТС-1 /1,2%/ , ЦЭТС-10 / 12%/ илэрсэн. Эмэнд тэсвэржилттэй илэрсэн 11 үйлчлүүлэгчийг ХӨСҮТ-ийн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмч нарын зөвлөгөөнөөр оруулж, 100% эмчилгээнд нь хамруулсан.</p> <p>-“Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах тухай” НЭМГ-ын 2017 оны 3 сарын 24-ний өдрийн 01 албан даалгаврын дагуу Эрүүл мэндийн төвийн 111 ажилтанг сүрьеэгийн урдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.</p> <p>-Сүрьеэгийн оношийн баталгаажилт 83,3% буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна. Шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдол 84 буюу өмнөх оны мөн үеэс 23 тохиолдлоор буурсан.</p> <p>-Маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэ илрээгүй, олон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөн 3, цөөн эмэнд тэсвэртэй 5 илэрснээс 100% эмчилгээнд хамруулж, эмчийн яналтанд хянагдаж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдлоор буурсан.</p> <p>-МУИС-ийн 1,2-р дотуур байранд “Сүрьеэгийн өвчнөөс урьдчилан сэргийлэлт” сургалт зохион байгуулан, сурталчилгааны материал тараалаа. Сургалтын өмнөх сорил 41,1%, сургалтын дараах сорил 63,3% болж нэмэгдсэн.</p> <p>-Хятад найрамдал сургуулийн бага ангийн 150 сурагчдад “Сүрьеэ өвчний тухай, сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт” сэдвээр сургалт зохион байгуулж, зөвлөмж тараав.</p>	
--	---	--

		<p>-Монголын Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн албан хүсэлтийн дагуу 12,13,14,16,17,18,20 дугаар хорооны сүрьеэгээр өвчилж болзошгүй, эрсдэл бүлгийн, 2343 нэн ядуу өрхийн судалгааг хүргүүлсэн.</p> <p>-Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан БХ, ЭМТ-тэй хамтран цэцэрлэгт хамрагдсан 121787 хүүхдээс 5146 хүүхэд, ЕБС-ийн 1-5-р ангийн болон цэцэрлэгийн багш, цайны газрын ажилчин нийт 785 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, нийт 189 хүүхэд, 14 багш, ажилтан өвчтэй илэрсэн байна. Өвчлөлийн тохиолдлуудыг бүртгэн хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлж байна.</p> <p>-Дүүргийн Улаан загалмайн хороо, Сүхбаатар Эрүүл мэндийн төвтэй хамтран 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр орон сууцны орцны жижүүр, дүүргийн ТҮК-ны ажилчдыг сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгууллаа. Үзлэгээр сүрьеэгийн эрт илрүүлгийн асуумж, цэрний шинжилгээ, явуулын рентген төхөөрөмж ашиглан нийт 100 хүнийг үзлэг шинжилгээнд хамруулж, сүрьеэгийн 1 тохиолдол илрүүлж, эмчийн хяналтанд авч, эмчилгээнд хамруулсан. Мөн дүүргийн УЗХ-оос шинжилгээнд хамрагдсан иргэдэд өдрийн халуун хоол цай, дулаан хувцас олгов.</p>						
101	<p>НЗДҮАХ-ийн 4.2.4 дахь заалт; 4.4.4. ХДХВ, БЗДХ-ыг бууруулах, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж, ажиллана. /Хорооны Засаг даргын үр дүнгийн гэрээнд Сүрьеэ, ХДХВ/БЗДХ-ыг бууруулах, Халдварт бус өвчний эрт илрүүлгийг эрчимжүүлэх, Жирэмсний хяналтыг сайжруулах, Хүүхдийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, Дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх, өрхийн эрүүл мэндийн төвийг дэмжиж ажиллах арга хэмжээг тусгайлан тусгаж, үр дүнг тооцох/</p>	<p>ХДХВ, БЗДХ-ыг бууруулах дүүргийн дэд хөтөлбөр хэрэгжүүлэх, ХДХВ, БЗДХ-ыг бууруулах, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах, оношилгуурын нөөц бололцоог нэмэгдүүлэх, гарын авлага сургалт сурталчилгааны материалыг хэвлүүлэх, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулийн оюутнуудад сургалт зохион байгуулна.</p>	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	100	НХХ	ӨЭМТ, Хорооны ЗДАА		
		<p>ХДХВ, бэлгийн замаар дамжих -Урьдчилан сэргийлэх үзлэгт 2017 оны 10 сараар 15291, өвчний улмаас амбулаторит 1580, диспансерт 413, нийт 17647 үйлчлүүлэгчээс 230 тэмбүү, 71 заг хүйтэн, 62 трихомониаз илрүүлж, өвчтөнг 100% эмчилгээнд хамруулж, хяналтанд авсан. Тэмбүү 16.77, заг хүйтэн 5.17, трихомониаз 4.52 промилль байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэмбүү 5.7, заг хүйтэн 1.67 промилиэр өссөн, трихомониаз өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.</p> <p>-Сайн дурын зөвлөгөө шинжилгээнд ХДХВ/ДОХ 806, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 665 хүн хамруулснаар тэмбүүгийн 54 эерэг тохиолдол илрүүлж, 10 шинэ тохиолдлыг эмчилгээнд хамруулсан.Сайн дурын зөвлөгөө шинжилгээнд хамрагдсан хүний тоо өмнө оны мөн үеэс 4 дахин нэмэгдсэн.</p> <p>-Цагдаагийн хэлтэстэй хамтран архины хамааралтай, гэр оронгүй 193 иргэнийг БЗДХ-ын шинжилгээнд хамруулж, тэмбүүгийн 34 тохиолдол, НХХ, МУЗН хамтран Гэртээ харих зам хөтөлбөрийн хүрээнд 93 тэнэмэл иргэдийг үзлэгт хамруулж, тэмбүүгийн 10 тохиолдол шинээр илрүүлж, албадан эмчилгээнд хамруулсан.</p> <p>-Зорилтот бүлгийн олон нийтэд чиглэсэн бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, хянах үйл ажиллагааны хүрээнд 10 удаагийн явуулын сайн дурын зөвлөгөө шинжилгээ, хуваарьт</p>				100%		



		<p>төвд 4 удаагийн дэмжлэгт хяналт хийж, 50 үзүүлэлтээр үнэлэн хангалтгүй үнэлэгдсэн үзүүлэлтийг сайжруулах арга хэмжээ авч, ЭМТ, Салбар амбулатори 1, 2, 11-18 дугаар хорооны ӨЭМТ-ийн 16 эмч, сувилагч нарт хэлэлцүүлэг 1, мэргэжил арга зүйн чиглэл өгөх сургалт 4 удаа зохион байгуулснаар үнэлгээ 26%-иар сайжирсан.</p> <p>-2017 оны 10 сарын байдлаар товллын дархлаажуулалтад 37575 хүүхэд буюу 96,1% хамруулж, нөхөн дархлаажуулалтаар 1437 хүүхэд хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад 620 хүүхдээр буурсан нь товллын дархлаажуулалт хугацаандаа хийгдэж байгааг илтгэнэ. УГУ вакцинд хамрагдвал зохих хүүхэд 5353, хамрагдсан 5222 буюу 97,6%.</p> <p>-2017 оны 11 сарын 10-ны байдлаар дүүргийн сонгогдсон цэцэрлэгүүдээс хамрагдвал зохих 3383 хүүхдээс 2466 хамрагдсан. Сонгогдсон 3 ӨЭМТ-ийн хамрагдвал зохих 200 жирэмсэн эх 100 хувь, ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй 530, архаг хууч өвчтэй 124 хүн томуугийн эсрэг дархлаажуулалтанд хамрагдсан байна.</p> <p>-ЭМС-ын 2017 оны Дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулах тухай тушаалын хүрээнд Нэмэлт дархлаажуулалтын 10 хоногийн үйл ажиллагааг 5,10 дугаар сард зохион байгуулж, заавал хийх дархлаажуулалтаас хоцорсон 15 хүртэлх насны 225, ЕБС-ийн 16-17 настай сурагчдыг улаанбурхан, улаанууд өвчний эсрэг хавсарсан вакцинаар 3616 буюу 95%, 7 настай хүүхдийг сахуу татрангийн вакцины 1-р тунд 3798 хүүхэд буюу 98 хувь, 15 настай сурагч сахуу, татрангийн эсрэг вакцины 2-р тунд 2524 хүүхэд буюу 99,8%, Улаанууд өвчний эсрэг вакцинд 2345 хүүхэд буюу 95%-ийг хамруулсны үр дүнд амьсгалын замын халдварт өвчин өмнө оны мөн үеэс 12774 тохиолдлоор буурсан үр дүнтэй.</p> <p>-0-5 насны хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор 6 удаа ТТТӨ-ний хяналт үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажилласнаар ХӨЦМ-ийн хэрэгжилт өмнө оны мөн үеэс 1,7%-иар сайжирсан.</p> <p>-Дүүргийн Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн төвтэй хамтран 2017.09.25,26-ны өдрүүдэд томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЕБС-ийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, эмч нийт 100 хүнд сургалт зохион байгуулж, хүүхдийн дархлааг дэмжих, витаминжуулах, дасгал хөдөлгөөнөөр чийрэгжүүлэх, аминдэмтэй тэжээллэг хоол өгөх, анги, танхимын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, ариутгал, халдваргүйтгэл хийх талаар зөвлөлөө.</p>				
103	НЗДҮАХ-ийн 4.2.6 дахь заалт; 4.4.6. Дүүргийн залуучуудын дунд “Эрүүл залуус” аян өрнүүлнэ.	Залуучуудын дунд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх аян зохион байгуулан ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ЦШ, ӨЭМТ
		<p>-“Эрүүл залуус аян”-ы хүрээнд “Сүхбаатар дүүргийн өсвөр үеийн эрүүл мэнд, тулгамдсан асуудал” сэдвээр зөвлөгөөн зохион байгуулж, өсвөр насны хүүхдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр ГБХЗХХ, Цагдаагийн 1 дүгээр хэлтэстэй хамтран ЕБС, их, дээд сургуулиудад 122 удаагийн сургалт зохион байгуулж, 2451 оюутан, сурагчийг хамруулсны үр дүнд 19-өөс доош насны охидын төрөлт 79 тохиолдол буюу 2016 оны мөн үеэс 28 тохиолдол буюу 0.69%-иар буурсан.</p> <p>-Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдлыг сайжруулах, эрүүл мэндийн боловсрол</p>				90%

		<p>олгох чиглэлээр дүүргийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/171 дүгээр захирамжаар 2017 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрүүдийн хооронд болзолт уралдаан зарлалаа. Болзолт уралдааны удирдамжийн хүрээнд Хорооны ЗДАА, ӨЭМТ хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p> <p>-Өсвөр үе, хүүхэд залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилгоор дүүргийн Засаг даргын 2017.09.15-ны өдрийн А/304 дүгээр захирамжаар Өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих Эрүүл залуус 2 сарын аян зарлаж, 11 сарын байдлаар нийт 862 хүүхэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаар шүд цоорол 18,8%, дотрын өвчлөл 3%, ЧХХ-н өвчлөл 6,3%-д тус тус илэрсэн. БЗДХ илрээгүй. Сүрьеэгийн сэжигтэй 3 тохиолдол илэрснийг онош баталгаажуулах шинжилгээнд илгээсэн. Мөн аяны хүрээнд өсвөр үеийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар эмч, мэргэжилтнүүдийн дунд Онол практикийн бага хурал зарлан, материалыг хүлээн авч байна.</p> <p>-2017 оны 2 удаагийн цэрэг татлагын үзлэгээр 3018 залуучууд орсноос 891 буюу 29,5% нь өвчний учир чөлөөлөгдсөн. Дүүргийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/171 дугаар захирамжаар Хорооны ЗДАА, ӨЭМТ, ЭМТ-ийн нарийн мэргэжлийн эмч нарын дунд цэргийн жинхэнэ албаны татлагаар эрүүл мэндээр тэнцээгүй залуучуудын эрүүл мэндийн байдлыг сайжруулах болзолт уралдааныг 2017 оны 5 дугаар сараас 2017 оны 12 дугаар сарын 1 хүртэл зарлан ажиллаж байна.</p>				
<b>4.5 Зорилтод бүлгийн иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжин ажиллана.</b>						
104	НЗДҮАХ-ийн 4.7.5 дахь заалт; 4.5.1. Ахмад настан, эмзэг бүлгийн иргэдийн суурь судалгааг нарийвчлан гаргаж, өрхийн хөгжлийг дэмжин, хөтөлбөр, арга хэмжээнд хамруулна.	Зорилтот бүлгийн иргэдийн төрөлжсөн судалгааг гаргана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ХөХҮХ
		<p>Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/15 тоот Босго шугам тогтоох тухай тушаалын дагуу Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнийг тодорхойлох босго шугамыг амьжиргааны төвшний үнэлгээний 360,3186 болон түүнээс доош оноогоор тогтоосон. 2013 оны үндсэн судалгааны мэдээллийн санг ашиглан дүүргийн зорилтот 5652 өрхийн 25298 иргэний мэдээллийг мэдээллийн сангаас тодорхойлон ажиллаж байна. 2017-2018 оны зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд 448 өрхийн 2300 иргэний нэгдсэн мэдээлэл бүрдүүлэн зорилтот 16 бүлгийн хэрэгцээний судалгааг гарган ажиллаж байна.</p> <p>Мөн өрхийн ерөнхий судалгаа үүнд нийгмийн үйлчилгээ, оролцоо, хүний хөгжлийн гол гол үзүүлэлтийг тусган мэдээлэл цуглуулсан.</p>			70%	
105	НЗДҮАХ-ийн 4.7.1 дахь заалт; 4.5.2. Ажил эрхэлдэггүй, нийгмийн халамжид хамрагддаггүй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж	Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг илрүүлэх, бүртгэх, нийгэмшүүлэх ажлыг дэс дараатайгаар зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ХөХҮХ, ХГБХХ, ЦХ-1, 2
		-Гэртээ харих зам хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уг хөтөлбөрийг танилцуулах, арга				

<p>болзошгүй иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг санаачлан ажиллана.</p>	<p>зүйн зөвлөгөө өгөх хэлэлцүүлэг уулзалтыг 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр дүүргийн удирдах ажилтнууд, хороодын Засаг дарга, нийгмийн ажилтнууд, халамжийн мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан.</p> <p>-4 дүгээр хороо нь 2017 оны 1 дүгээр сард тус хорооны нутаг дэвсгэрээр тэнэмэл амьдралаар амьдарч байсан, өөрийн орон гэргүй, нэр хаяг тодорхойгүй иргэн Оюунчимэгийг “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”, дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн “Нэг цэгийн үйлчилгээний төв”, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллагад тус тус байршуулан, 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Нийслэлийн Засаг даргын дэргэдэх “Нийгмийн халамжийн тусгай төв”-д хүлээлгэн өгч, нийгэмшүүлэн ажиллаж байна.</p> <p>-2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр 10 дугаар хорооны нийгмийн ажилтан, ХГБХ-ийн мэргэжилтэн, ӨЭМТ-ийн нийгмийн ажилтаниар Зөв амьдрах ухаан” төвд очиж 10 дугаар хорооны иргэн Ариунзаяа, хүү Батбаяр нарын талаар ТББ-ын удирдлагуудтай уулзаж нөхцөл байдалтай танилцсан.</p> <p>-Төрийн болон ТББ-уудын ажлын уялдаа холбоо сайжирч, харилцан мэдээллээ солилцдог болсноор 9 хүүхэд, 2 иргэнийг гэр бүлд нь эргэн нэгтгэж, тэнэмэл болон тэнэх эрсдэл бүхий иргэн, хүүхдийн тоог бууруулсан.</p> <p>-Дүүргийн Улаан загалмайн нийгэмлэг, Цагдаагийн 1,2 дугаар хэлтэс хамтран тэнэмэл иргэдийн дунд сүрьеэ өвчний тандалт, судалгаа хийх ажлыг 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж, нийт 180 тэнэмэл иргэдийг бүртгэлжүүлж, эмнэлгийн үзлэгт хамруулан, Улаан загалмайн нийгэмлэгээс хооллож, үнэгүй хувцас олгох талон тарааж, ажилласан.</p> <p>-Дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт тэнүүчлэн амьдарч байсан иргэн Дүгэрсүрэн, охин Итгэл нарыг бүртгэл судалгаанд авч, “Зөв амьдрал төв”-д байрлуулсан.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай А/357 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах, “Гэртээ харих зам” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус дүүргийн нутаг дэвсгэрт тэнүүчлэн амьдарч буй гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг бүртгэлжүүлэн, нөхцөл байдлын үнэлгээ хийх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, ажлыг 11 дүгээр сарын 16,17-ны өдрүүдэд зохион байгууллаа.</p> <p>Уг ажлыг зохион байгуулахад дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Бүртгэлийн хэлтэс, Эрүүл мэндийн төв, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, ХӨСҮТ, Улаан загалмайн нийгэмлэг зэрэг байгууллагын нийт 151 ажилтан, албан хаагч ажилласан.</p> <p>Энэ арга хэмжээний хүрээнд нийт 111 гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг илрүүлэн бүртгэлжүүлж, асуулга авч судалгааны анкет бөглөн, фото зураг авч, бүртгэгдсэн иргэдэд бүртгэлийн хуудас олгон баталгаажууллаа.</p> <p>Дээрх иргэдийг дотор, сүрьеэ, ДБЗХӨ-ний үзлэгт хамруулан, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэн ба дотрын үзлэгт нийт 86 иргэн хамрагдсан ба түлэгдсэн болон бэртэж гэмтсэн ил шарх, зөөлөн эдийн гэмтэл байснаас хяналтанд авах зөвлөгөө өгч ажиллалсан.</p> <p>БЗДХ/ХДХВ/ДОХ илрүүлэх үзлэг, шинжилгээнд 92 иргэнийг хамруулснаас ХДХВ илрүүлэх шинжилгээгээр эргэлзээтэй 1 тохиолдол илэрснийг онош баталгаажуулах шинжилгээнд</p>	<p>100%</p>
--	---	-------------



		явуулсан. Тэмбүү илрүүлэх шинжилгээгээр тэмбүүгийн 10 тохиолдол илрүүлж, албадан эмчилгээг тухай бүрт хийж, хяналтанд авсан. Ил шархтай 13 иргэнд шархны цэгцлэлт, цэвэрлэгээ, цэвэр боолт хийж анхан шатны тусламж үзүүлсэн. Дүүргийн ЗДТГ, Улаан загалмайн нийгэмлэгээс өвлийн дулаан хувцас олгож, халуун хоолоор үйлчиллээ. Бүртгэлжүүлэх ажлын хүрээнд дүүргийн харьяалалтай 30 иргэнийг бичиг баримжуулах ажлыг зохион байгуулах юм. Мөн арга хэмжээний үеэр бүртгэгдсэн 10 хүүхдийг бүртгэн эцэг эхэд нь хүлээлгэн өгч, дулаан хувцас олгосон. Арга хэмжээний явцыг зургаар баталгаажуулан материалжуулж, Стар телевизэд мэдээлэл өгөн, үйл ажиллагаагаа сурталчилсан.				
106	4.5.4. Ахмад настныг эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах, тэдний насны онцлогт тохирсон нийгмийн идэвхтэй амьдралд татан оролцуулах Ахмад настны зөвлөх үйлчилгээг өргөжүүлэн ажиллана.	Дадлага туршлагатай ахмад мэргэжилтний судалгааг хороо бүрээр нь гарган зөвлөн туслах,мэдээлэл өгөх,туршлага дэлгэрүүлэх үйлчилгээг мэргэжлийн өндөр чадвартай ахмад мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ХөХҮХ
		Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд төсөл хүлээн авах, сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг ХХҮХ-ийн даргын 2017 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн А/14 тоот тушаалаар байгуулсан. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт, нийт 14 ахмад мэргэжилтэн хамрагдаж, 22,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Эрүүл мэнд, боловсролын чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлсэн 5 ахмад мэргэжилтэн гүйцэтгэлийн тайлангаа ирүүлж, 4,2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Одоогоор 9 ахмад мэргэжилтэн гүйцэтгэлийн тайлангаа ирүүлээгүй тул гүйцэтгэлийн санхүүжилтийг олгоогүй байна.				90%
107		Олон улсын ахмадын өдрийг угтсан ажлуудыг тусгай төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ХөХҮХ
		Дүүргийн Засаг даргын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн Олон улсын ахмадын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай А/295 дугаар захирамжийн хүрээнд Олон улсын ахмадын өдрийг 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулахаар хороодод зөвлөмж, чиглэл хүргүүллээ. Ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд зориулж хороо бүрд тус бүр 300,000 төгрөг шийдвэрлэв.				100%
108		Сар шинийн баяраар албан байгууллагуудад харьяалалгүй дүүргийн ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ХөХҮХ
		Сар шинийн баярыг тохиолдуулан дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 09-ны				

		өдрийн А/44 дүгээр Цагаан сарын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах тухай захирамжийн дагуу дүүргийн 14132 ахмадуудад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг 2017 оны 02 дугаар сарын 23, 24-ны өдрүүдэд хороо тус бүр дээр зохион байгуулав. Хүндэтгэл үзүүлэх үйл ажиллааны хүрээнд хороо бүр өөрийн онцлогт тохируулан ахмадуудаа хүлээн авч нийт ахмадууддаа гарын бэлэг гардууллаа. Дээрхи үйл ажиллагаанд 2017 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн Цагаан сарын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх хүндэтгэлийн үйл ажиллагаа зохион байгуулах тухай А/18 дугаар тушаалаар хороо тус бүр 300000 төгрөг, нийт 6 сая төгрөг зарцууллаа.				100%
109	НЗДҮАХ-ийн 4.8.6 дахь заалт; 4.5.5. Ахмад настанд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх иргэд, залуучуудын сайн дурын үүсгэл санаачилга, хөдөлгөөнийг дэмжин “Хариу нэхээгүй тус” аян зохион байгуулна.	Ахмад настанд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх, тэдэнд туслах төрийн бус байгууллагуудын үүсгэл санаачилга, хөдөлгөөнийг дэмжин "Хариу нэхээгүй тус" аян зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ХөХҮХ
		“Хариу нэхээгүй тус” аяны хүрээнд дараах ажлуудыг иргэд, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулсан. Үүнд: Гацуурт ХХК–иас амьжиргааны түвшин доогуур 32 ахмад настанд 25 кг гурил, 10кг мах тус бүрд нь олгосон. Ерөнхий боловсролын 31 дүгээр дунд сургуулийн 9г ангийн хүүхдүүд сар шинийн баяртай холбогдуулан 14 дүгээр хорооны ахмад настан Норовд тавгийн боов, тавгийн чихэр бусад хүнсний зүйлийн туслалцаа үзүүллээ. “ХАДАН СУУРЬ” ТББ-тай хамтран олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 5 ээжид гарын бэлэг гардуулан сэтгэлийн дэм үзүүлсэн. Оюутны христийн цуглааны залуучууд өөрсдийн нөөц боломжиндоо тулгуурлан 12 дугаар хорооны зорилтод бүлгийн 5 ахмад настанд 5 литр ургамлын тос, 10 кг гурил тус тус олгосон. 14-р хороо Төв гандантэгчилэн хийд болон өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран байнгын асаргаанд байдаг хүнд өвчтэй байнгын хэвтэрт байдаг 24 өрхөд хэрэгцээ шаардлагатай эм, тарианы тусламж үзүүлж, сэтгэл санааны дэмжлэг үзүүлсэн. Оюутны христийн цуглааны залуучууд өөрсдийн нөөц боломжиндоо тулгуурлан 12 дугаар хорооны зорилтод бүлгийн 5 ахмад настанд 5л ургамлын тос, 10 кг гурил тус тус олгосон. Дүүргийн 1-20 дугаар хороодын амьжиргааны баталгаажих түвшин доогуур, нэн ядуу өрх гэр бүлд амьдарч буй сургуулийн насны хүүхдүүдэд зориулж “Сүүн Сэтгэлийн Дэм” төрийн бус байгууллагатай хамтран “Дүрэмт хувцасаа хандивлацгаая” аян зохион байгуулж, сурагчдын дүрэмт хувцас, цүнх, сурах бичиг, зохиолын номын тусламж үзүүлж, хамтран ажилласан. 16 дугаар хорооны иргэн өөрийн гэр оронгүй, тэнэмэл Н-ыг Тереза, Энэрэл эмнэлэгээр түр байрлуулан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр тогтоолгон Батсүмбэр дэх Ахмад настны асрамж хөгжлийн үндэсний төврүү хүргэж өгсөн. Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан нийт 8 иргэний хүсэлт материалын бүрдэлийг ханган Батсүмбэр дэх асрамж хөгжлийн үндэсний төвд 7 иргэнийг, Тереза-Эх ахмад настны асрамжийн төвд 1 иргэнийг хүргэж өгсөн.				100%
110		Хөгжлийн бэрхшээлтэй ахмад настанд гэрээр үйлчилгээ үзүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ЭМНДХ

		Хэлтсийн даргын 2017 оны 03 дугаар сарын 20-ны А/10 тоот тушаалаар дүүргийн 20 хороонд ажиллах ажлын хэсгийг 5 байцаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 4 хэсэг болгон хуваарилж ажлын хэсгүүд улиралд 1-ээс доошгүй удаа хариуцсан хороодод хороодын хэсгийн ахлагч нартай хамтран ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй иргэн ахмад настны тэтгэврийг итгэмжлэлээр олгож байна.	70%			
<b>Тав. Дэвжин дээшлэх сүхбаатар дүүрэг</b>						
<b>5.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллана.</b>						
		Ажил олгогчдын өдөрлөгийг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ХөХҮХ
111	5.1.1. Орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэгч татвар төлөгч, ажил олгогчдын чуулга уулзалтыг жил бүр явуулна.	<p>Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2016-2017 оны Улсын хэлэлцээрийн хүрээнд:</p> <p>-Дүүргийн төр захиргааны байгууллагууд, ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлэн үр дүнд хүргэх, холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах</p> <p>-Орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэгч татвар төлөгч, ажил олгогчдод холбогдох хууль тогтоомжуудын талаар мэдээлэл өгөх зорилгоор Ажил олгогчдын чуулганыг 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, дүүргийн Ажил Олгогч Эздийн холбоо, Дүүргийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо зэрэг байгууллагууд хамтран зохион байгууллаа.</p> <p>Чуулганд дүүргийн Засаг дарга Х.Болормаа, Засаг даргын орлогч П.Давхарбаяр болон дүүргийн дэргэдэх хэлтэс, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөлөл, аж ахуй нэгж байгууллага, ажил олгогчид, хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд, МАОЭХ, нийслэлийн Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөл нийт 600 гаруй төлөөлөгчид оролцлоо. Чуулганы төлөөлөгчдөд Хадгаламж, өрхийн төсөв сэдвээр МУИС-н ЭЗСургуулийн багш, эдийн засгийн ухааны Доктор, профессор Л.Оюун, хөдөлмөрийн зах зээлийн бодлого, гадаад орны туршлага сэдвээр Хөдөлмөрийн эдийн засагч, Доктор, профессор Д.Лхагвасүрэн, Шилийн гол аймаг дах сургалтын талаарх танилцуулгыг Санхүү эдийн засгийн их сургуулийн ректор Д.Батжаргал /Ph.D/, Мэргэжлийн хяналтын хэлтсийн байгууллагын бодлого, цаашид анхаарах асуудал сэдвээр Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга М.Баасандорж, Татварын хуулиудын өөрчлөлт, цаашдын чиг хандлага сэдвээр Татварын хэлтсийн дарга Ц.Сайнбуян, Ажил олгогчийг дэмжих хөтөлбөрийн талаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Н.Мөнхбат, Голомт банкны бизнес хөгжлийн менежер Амарсанаа нар жижиг зээлийн талаар тус тус танилцуулан мэдээлэл өглөө.</p> <p>Залуучууд, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин байнгын болон түр ажлын байраар хангах, сургах, дадлагажуулах, мэргэжил эзэмшүүлэх зорилгоор чуулганы төлөөлөгчдөөс Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд, хөгжлийг дэмжих асуудлаар нийт ажил олгогчдод хандан уриалга гаргалаа. Дүүргийн ХХҮХ-ээс хамтран ажилладаг Одкон</p>				100%

		холдинг, Юнивишн ХХК, Шангрилла ХХК-г өргөмжлөлөөр, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооноос Тэргүүний ажил олгогч цол тэмдгээр Улаанбаатар зочид буудал ХХК, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, “Өгөөж чихэр боов” ХХК шагнагдсан ба 13-р хорооны иргэн Баярмагнай Оюунсүрэн Бүтээлч иргэнээр тус тус шагнагдсан. Мөн Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээлээр үзэсгэлэн худалдаа гаргасан.				
112	НЗДҮАХ-ийн 4.7.9 дахь заалт: 5.1.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, судалгаанд тулгуурлан дүүргийн залуучуудыг мэргэжил эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулан ажиллана.	Мэргэжилгүй, ажил олоход хүндрэлтэй зорилтот бүлгийн иргэдийг ажил олгогчдын захиалгад тулгуурлан Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтран мэргэжлийн болон давтан сургалтад хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ХөХҮХ
		2017 оны эхний 9 сарын байдлаар нийт 155 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгч, үүнээс 146 иргэн ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэн байна. Ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэдэд ажил олгогчоос ирүүлсэн нийт 887 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг сурталчилж, 519 иргэнийг ажлын байранд зуучилсны 455 иргэн байнгын ажлын байртай боллоо. Дүүргийнхээ ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажилгүй мэргэжилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэдийн хүсэл сонирхол болон ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн мэргэжил олгох, давтан сургалтад хамруулах зар мэдээллийг хороодоор дамжуулан хүргэсний үр дүнд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газраас мэргэжил олгох болон давтан 39 төрлийн мэргэжлийн сургалт зарлагдаж, дүүргийн хэмжээнд 125 ажил олоход хүндрэлтэй иргэн хамрагдсан.				90%
113	5.1.3. Хороодод байрлах Е биржийн /Киоск машин/ үйл ажиллагааг сайжруулж, иргэдэд ажлын байрны мэдээ, мэдээллийг шуурхай хүргэж ажиллана.	Хороодод байрлах Е биржийн хэвийн ажиллагааг ханган иргэдэд ажлын байрны мэдээлэл, хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, сургалтын талаарх мэдээ, мэдээллийг шуурхай хүргэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ХөХҮХ
		Дүүргийн хэмжээнд байгаа нийт 21 Е бирж байдаг. Е биржийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор 8 дугаар сард 20 хороодод байрлах Е биржид засвар, үйлчилгээ хийснээр 17 Е биржийг хэвийн ажиллагаатай болгосон, 3 Е биржид техникийн засвар үйлчилгээ хийх шаардлагатай тул ХХҮЕГ-т мэдэгдсэн. Нийт 10 Е бирж, үүнээс 7 Е бирж нь 8 дугаар сараас эхлэн ассан ба 8714 цаг ажиллаж, 1276 мэдээ мэдээллийг иргэдэд хүргэж, ажлын байрны зар мэдээллийг 150 иргэн хэвлэж авсан.				90%
114	НЗДҮАХ-ийн 4.7.5 дахь заалт; 5.1.4. Ажил олоход хүндрэлтэй, зорилтот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн зөвлөгөө өгч, хөдөлмөрийн зах зээлд бэлдэн, хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.	Ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэдийг хөдөлмөрийн зах зээлд бэлдэх зөвлөгөө мэдээллийн үйлчилгээнд хамруулж, ажил олгогчийн захиалгад тулгуурлан ажилд зуучилна. Жич: Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудаас орон тооны судалгаа авч, ажилгүй иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах,	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	НХХ	ХөХҮХ
		Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сангийн Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох				90%

		үйлчилгээ модульд 234 иргэнд ганцаарчилсан мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. Мэргэжлийн сургалтын талаар 35, гадаад улсад ажиллах хүсэлтэй 43, ажилгүй 156 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сангийн зуучлалын модульд шинээр ажил олгогч 136 байгууллага, сул чөлөөтэй ажлын байрны захиалга 1449, ажил хайгч 1570 иргэнийг бүртгэлжүүлж, ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтэй 1281 иргэнд тодорхойлолт гарган өгч, мэргэжлийн болон давтан сургалт санал болгон танилцуулж, 1203 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучлан, мэдээллийг оруулсан. Цэргээс халагдаад ажилгүй байгаа 7 иргэн, шинээр сургууль төгсөгч 137, хөгжлийн бэрхшээлтэй 38 иргэн ажилд зуучлагдсан.						
		Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад мэргэжлээ хэрхэн сонгох, ажил олоход хүндрэлтэй иргэдэд бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээлэл, хөдөлмөрийн харилцааны талаарх зөвлөгөө өгч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	HXX	ХөХҮХ		
115		Монгол Солонгосын Политехникийн коллежийн ээлжит төгсөлтөөр төгсөгчдийг ажлын байранд зуучлах, ажлын байртай болгох зорилгоор төгсөгч, ажил олгогчдыг уулзуулсан “Хөдөлмөрт бэлтгэх зөвлөгөө, ажлын байр” сэдэвт өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгт Монгол Солонгосын политехникийн коллежийн засварчин, хэвлэлийн график дизайнер, ээрмэлийн өргөгч мэргэжил, цахим хэрэгслийн засварчин, цахилгаан техникч, оёдол, эсгүүрчин зэрэг мэргэжлээр нийт 450 суралцагч төгссөнөөс, 100 гаруй төгсөгч болоод ажил олгогч 15 байгууллагын төлөөлөл оролцлоо. Өдөрлөгөөр ажил хайгч 11 иргэнийг бүртгэж, мэдээлэл зөвлөгөө өгч, 75 иргэнд 84 сул чөлөөтэй ажлын байр танилцуулж, 50 ширхэг танилцуулга тараан ажилласан. Ганцаарчилсан мэдээлэл, зөвлөгөөг 234 иргэнд өгч Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сангийн Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний модульд бүртгэсэн. Мэргэжлийн сургалтын талаар 35, гадаад улсад ажиллах хүсэлтэй 43, ажилгүй 156 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн. Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг эрх бүхий сургалтыг гүйцэтгүүлэхээр 4 сургалтын төвийг сонгон шалгаруулж, 900 иргэнд бүлгээр Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.						70%
116	НЗДҮАХ-ийн 4.7.8 дахь заалт; 5.1.5. Дүүргийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	HXX	ХөХҮХ		
		Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн аж ахуй эрхлэлтийн арга хэмжээний хүрээнд сургалт зохион байгуулж 77 иргэн, бичил бизнес эрхлэгчийг хамруулж сургалтын зардалд 2310000 төгрөг зарцууллаа. Сургалтад хувиараа хөдөлмөр эрхлэгч 43 эмэгтэй хамрагдсан.				70%		

117		Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, нөхөрлөл, хоршоодыг аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100		Хороодын ЗДАА
		“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгийн хүрээнд дүүргийн хэмжээнд 2 удаа /хавар, намар/ төсөл зарласнаас нийт 152 төсөл ирүүлж 69 иргэний төслийг ажлын хэсгээр дэмжин 198 сая төгрөгийг 2 жилийн хугацаатай 100%-ийн эргэн төлөлттэй олгосон. 69 төслийн хүрээнд нийт 87 ажлын байр бий болсон.				90%
118	НЗДҮАХ-ийн 1.3.6 дахь заалт; 5.1.6. Аж ахуйч өрх хөтөлбөр хэрэгжүүлэн, тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.	Өрхийн тариалан эрхлэгчдэд зориулж онолын танхимын болон практик сургалт зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ	Хороодын ЗДАА
		Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилтын хүрээнд өрхийн тариалан эрхлэлтийг дэмжиж, АДРА-Монгол Олон улсын байгууллагатай хамтран “Өрхийн тогтвортой тариалан” төсөл, Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгээр Монголын фермер эмэгтэйчүүдийн холбоо ТББ-аас хэрэгжүүлж буй Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл, маркетингийн “Монгол ногоо” төсөл, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран Хүлэмж төслүүдийг амжилттай үргэлжлүүлэн хэрэгжүүлж, эдгээр төслүүдэд дүүргийн 360 гаруй өрхийг хамруулан, төслийн багуудтай хамтран өрхийн тариалан эрхлэгчдэд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалтыг хэрхэн хийх аргачалалд сургах, хүлэмжийн аж ахуй эрхлэх чиглэлд мэргэжлийн зөвлөгөө өгөх танхимын онол арга зүйн сургалтыг 8 удаа, талбайн практик сургалтыг 8 удаа тус тус зохион байгуулж, 2017 онд 0,5 га талбайгаас 6 тн төмс, 1,5 га талбайгаас 20,8 тн хүнсний ногоо хураан авч, хүнсний хангамжаа нэмэгдүүллээ.Тухайлбал: Хүнсний ногооны салбарын тогтвортой хөгжлийг дэмжих, хүйсийн тэгш байдлыг хангах замаар ногоочдын, ялангуяа хөдөө, орон нутгийн жижиг тариаланчид, хот суурин газрын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхүүдийн амьжиргааг сайжруулах зорилгоор хэрэгжиж буй “Монгол ногоо” төсөлд хамрагдсан 43 өрхийн тариалан эрхлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор төмс хүнсний ногооны үр ашиг, төлөвлөлт, эрүүл мэндийн ач холбогдол, хөрс боловсруулалт, хамгаалагдсан хөрс, "Ургамал хамгаалал, хүнсний ногооны ургалтын үеийн арчилгаа" сэдвээр танхимын онол арга зүйн сургалтыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд, практик дадлагыг дүүргийн тэргүүний тариаланч Н.Далхаасүрэн, Б.Энхчимэгийн хүнсний ногооны талбайд зохион байгуулж, харилцан туршлага судлуулан, өрхийн тариалан эрхлэхэд газраа хэрхэн хагалах, бордох, төмс, хүнсний ногооны үрийг яаж суулгах, ил талбайн төмс, хүнсний ногоо болон хүлэмжний ногооны арчилгааг хэрхэн хийх, хүлэмжийн өвчин хортонтой тэмцэх арга, хүнсний ногоогоор хэрхэн шимтэй хоол хийх, хэрхэн даршлах зэрэг төмс хүнсний ногоо тариалах, үр шимийг хүртэх талаар цогц мэдлэг олгож, төсөлд хамрагдсан зорилтот бүлгийн 15 өрхөд 3 төрлийн үр, 10 кг үрийн төмс үнэ төлбөргүй				100%

	<p>өгч, иргэдээ дэмжиж ажиллалаа. Монгол ногоо төслийн 1 жилийн үйл ажиллагааны танилцуулга, Налайх дүүргийн тариаланч өрхүүдийн туршлага судлах үзүүлэх сургалт 2017 оны 08 дугаар сарын 09-ний өдөр Налайх дүүрэгт зохион байгуулагдаж, төслийн үр шим хүртэгчдийн багаар ажиллах тэргүүн туршлага, төслийн хүрээнд хийгдсэн жишиг гудамж, загвар өрх, үрслэг бойжуулах төв, зорилтот сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, төмс хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй, мод үржүүлгийн ажлыг хэрхэн багаар хийх арга, багийн ажиллагааны үр дүнг үзэж сонирхон, хүнсний ногоо, даршилсан ногоогоор хийх хоолны нэр төрлийг хэрхэн нэмэгдүүлэх, ногооны хайлмаг, торт зэрэг шинэ бүтээгдэхүүн хийх аргад суралцсан. Гэр хорооллын өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, чадавхжуулах, тэдгээрийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Дэлхийн зөн ОУБ-тай хамтран хэрэгжүүлж буй Хүлэмж төсөлд дүүргийн 14 дүгээр хорооны 5 өрх, 15 дугаар хорооны 3 өрх, 16 дугаар хорооны 4 өрх, , 17 дугаар хорооны 4 өрх 18 дугаар хорооны 5 өрх, нийт 21 өрхийг хамруулж, мэргэжлийн чиг баримжаа олгох анхан шатны “Хүлэмжин дэх тариалалт” сэдэвт 2 өдрийн сургалтыг дүүргийн Агро Парк Хоршоотой хамтран зохион байгуулж, хүлэмжинд тариалалт хийхэд хөрс шороогоо хэрхэн яаж бэлтгэх, газрын байрлалыг сонгон хүлэмжийг байрлуулах, бордоогоо бэлтгэх арга, үр үрсэлгээгээ хэдэн сард үндэслүүлэх болон хүлэмжиндээ суулгах ургацын тандалтыг хэд хэдэн сард яаж хийх талаар сургалтын хүлэмжинд онол-практикийг хослуулсан мэдлэг олгож, CD бичлэг бүхий сургалтын гарын авлага тараасан. Дүүргийн Засаг дарга болон АДРА-Монгол ОУБ-тай байгуулсан хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд Монгол дахь Олон улсын Адвентист хөгжил туслалцааны ашгийн бус, нийгмийн сайн сайхны төлөөх төрийн бус байгууллагатай хамтран “Хүнсний аюулгүй байдал хөтөлбөр”-ийн хүрээнд Канадын Хүнс, үр тарианы банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа “Өрхийн тогтвортой тариалан” төсөлд хамрагдсан дүүргийн 16, 17, 18, 20 дугаар хорооны 220 өрхөд “Үрсэлгээний дадлага сургалт”-ыг 12 дэд сэдвээр тусгай хөтөлбөрийн дагуу хороо тус бүрт хоёр бүлэг дээр хичээл зааж, ногооны талбайд дадлага хийлгэж, мэргэжлийн ур чадварыг сайжруулах чиглэлээр холбогдох зөвлөмжүүдийг өгч ажиллалаа. Зөгийн аж ахуй эрхлэх сонирхол бүхий аж ахуйн нэгж, иргэдэд зориулж, “Зөгийчний анхан шатны сургалт” зохион байгууллаа. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй ажлын байр шинээр бий болгох, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд энэхүү сургалтыг Монголын Зөгийчдийн холбоотой хамтран 25 иргэнийг хамруулан зохион байгуулсан.</p>				
119	<p>Эрүүл баталгаатай төмс, хүнсний ногооны борлуулалтын сүлжээ цэгүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, нэгдсэн асар барьж, хөдөө орон нутгийн ногоог хямд үнээр дүүргийн иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	ХХҮХ	ААТ
	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2017 оны 02-02/1089 тоот албан бичгээр ирүүлсэн Зөвлөмжийн дагуу АДРА-Монгол ОУБ-ын “Өрхийн тогтвортой тариалан” төсөл, Дэлхийн зөн ОУБ-ын “Хүлэмж” төсөл, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгээр Монголын фермер эмэгтэйчүүдийн холбоо ТББ-аас хэрэгжүүлж буй Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл,</p>				100%

	<p>маркетингийн “Монгол ногоо” төслүүдийг амжилттай хэрэгжүүлж, төсөлд хамрагдсан иргэдийн тарьж ургуулсан хүнсний ногооны борлуулалтыг дэмжиж, Хүүхдийн урлан бүтээх төв, Эвт үйлчилгээний төв, Хан-Эрдэнэ худалдааны төв, Дарь эхийн 33-ын автобусны буудлын талбай дахь 4 борлуулалтын цэгээр эрт ургацын ногооны борлуулалт хийх зорилгоор ажлын байрын эрүүл ахуйн нөхцөл болон гаднах өнгө үзэмж, хаягжилтыг шинэчлэх ажлыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасагтай хамтран хийж, уг ажлын байранд хүнсний ногоо худалдаалах дүүргийн иргэдийн хүсэлтийг авч, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/105 дугаар тушаалаар батлагдсан Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үл мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмын дагуу гарал үүслийн гэрчилгээ олгох, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн мэдээллийн санд бүртгүүлэх, тариалан эрхлэгчдийг тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулж, эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ худалдаалах чиглэлээр Хамтран ажиллах гэрээг 13 иргэн, 1 ААН-тай байгуулж, худалдаа үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран 2 удаа хяналт, шалгалт явуулж, мэргэжлийн заавар зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хөдөө орон нутгийн ногоочдын болон дүүргийн өрхийн тариаланчдын тарьж ургуулсан ногоог шууд хүргэж, иргэдийнхээ хүнсний хэрэгцээнд эдгээр төвлөрсөн худалдааны цэгүүдээр 59.7 тн төмс, 29.8 тн лууван, 9.6 тн манжин, 21.4 тн сонгино, 52.4 тн байцаа, 13.6 тн нарийн ногоо, 48.8 тн тарвас, нийт 235.3 тн ногоо борлуулсан нь өмнөх оныхтой харьцуулахад 4 дахин нэмэгдсэн байна. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолоор баталсан “Хүн амын хоол тэжээл Үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, экологийн цэвэр бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор Цэрэндоржийн гудамжинд 2017 оны 04 дүгээр сарын 08-09-ний өдрүүдэд Ногоон сор ХХК-ийн үйл ажиллагааг дэмжиж, “Гүзээлзгэний баяр” өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулж, 2 өдрийн хугацаанд нийт 2630 пакет буюу 789 кг гүзээлзгэнэ борлуулж, хүүхэд багачуудын дунд урамшуулалттай худалдаа, уралдаант тэмцээнүүдийг зохион байгуулан, 62,4 кг жимсийг амталгаат болон урамшуулалд олгож, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор гэрийн нөхцөлд гүзээлзгэнийг хэрхэн тарих аргачлалыг зааж сургах, мэргэжил арга зүйн тусламж үзүүлэх ажлыг нийт 400 гаруй иргэдэд үзүүлсэн.</p> <p>Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэвэр агаар, ногоон орчин, тав тухтай байдлыг бий болгоход иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, бага насны хүүхэд, залуучуудын экологийн боловсролыг сайжруулах зорилгоор мод бут сөөг, цэцгийн мандал, жимс, жимсгэний модыг хэрхэн тарьж ургуулах, арчлах, ногоон орчныг яаж зөв зохистой бий болгох чиглэлээр 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд 32-ын тойруугийн нийтийн эзэмшлийн талбайд “Танин мэдэхүйн цэцэрлэг” байгуулах зорилготой Монголын ногоон эмэгтэйчүүдийн холбоо ТББ, Хурын үнэр ХХК, Буянт үйлстэн ТББ-ын санал санаачилгыг дэмжин, жимс жимсгэний мод, бут сөөгний үзэсгэлэн худалдаа гаргаж, нийт 250 ш интоор, бөөрөлзгөнө, монос, долоогоно зэрэг жимс жимсгэний үрсэлгээ суулгацыг худалдан борлуулж, мэргэжлийн заавар зөвлөмж өгөх ажлыг зохион байгууллаа.</p>	
--	---	--



		<p>Дүүргийн Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Газар эзэмшүүлэх тухай захирамжаар дүүргийн Засаг даргын Тамгын газарт мод үржүүлгийн зориулалтаар олгосон 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Сэлбэ голын баруун далангаас зүүн тийш байрлах нийт 8 хэсгийн 149630 м2 талбайд мод, бут сөөг, жимс жимсгэний тарьц суулгацыг бойжуулах зориулалтаар түр хугацаагаар ашиглуулан, хамтран ажиллах гэрээ байгуулсан 8 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлж, хаврын мод тарилтаар нийт 1000 гаруй жимс жимсгэний суулгацыг тарьж ургуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Чацаргана” хөтөлбөрт дүүргийн 18 дугаар хорооны иргэн Д.Сүхбаатар, 19 дүгээр хорооны Сэлбэ төгөл хоршоо, 15 дугаар хорооны иргэн Д.Баяндалай, СБ Хот тохижилт ХХК-иуд хамрагдаж, нийт 2950 ш чацарганы суулгац авч, тариалсан байна. Хөтөлбөрийн гэрээний үүргийн биелэлтэнд хяналт тавьж, тайланг нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.</p>			
120	<p>Дүүргийн "Алтан намар-Ургацын баяр" арга хэмжээ зохион байгуулж, Өрхийн тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, урамшуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	ХХҮХ	Хороодын ЗДАА
		<p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, үндэсний үйлдвэрлэгчид, тариаланчдын шилдэг бараа бүтээгдэхүүн, шинэ ургацын дээжийг хэрэглэгч түмэнд хүргэх зорилгоор Мишээл экспо төвд “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” уриан дор зохион байгуулж буй “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээний хүнсний бүтээгдэхүүний “Эрүүл Монгол хүнс-2017” үзэсгэлэн худалдаа, шинэ ургацын “Алтан намар” өргөтгөсөн худалдаанд дүүргийн өрхийн тариаланчдын төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний борлуулалтыг дэмжих зорилгоор дундын зуучлалгүйгээр шууд худалдан борлуулах нөхцөл бололцоог олгож, нийслэл, дүүргийн тэргүүний тариалан эрхлэгч Ж.Наранцэцэгийг дэмжин оролцуулж, 300 гаруй шил даршилсан ногоо, 0,5 орчим тонн төмс, хүнсний ногооны борлуулалт хийж, хамгийн олон төрлийн ногоо борлуулсан оролцогчоор шалгарч, ХХААХҮЯамны Өргөмжлөлийн эзэн болж, хүнсний салбарт ажилласан түүний 25 жилийн хөдөлмөрийг Төр засгаас өндрөөр үнэлж, Алтан гадас одонгоор шагнасан.</p> <p>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн өгсөн үүрэг чиглэлийн дагуу дүүргийн 1 дүгээр хороо, Драммын театрын арын талбайд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний өргөтгөсөн худалдаа “Алтан намар-2017” арга хэмжээг 2017 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл зохион байгуулж, дүүргийн өрхийн тариалан эрхлэгчид болон орон нутгийн тариаланчдыг ажлын байраар ханган, хүнсний ногооны борлуулалтыг дэмжин, нийслэлчүүдийг экологийн цэвэр хүнсний ногоогоор ханган ажилласан.</p> <p>Мөн 5 дахь жилдээ хэрэгжиж байгаа АДРА-Монгол ОУБ-ын Тогтвортой тариалан төслийн хаалтын арга хэмжээ болох “Ургацын баяр-2017” өргөтгөсөн худалдаанд төсөлд хамрагдсан 16, 17, 18, 20 дугаар хорооны 220 өрхийн төслийн хугацаанд хүнсний ногоо тариалах, боловсруулах, өрхийн аж ахуй эрхлэх чиглэлээр сурч эзэмшсэн арга туршлагаа бусадтай хуваалцах, төслийн үр шимээр бий болсон олон төрлийн экологийн цэвэр хүнсний ногоо, жимс</p>	100%		

		<p>жимсгэний үзэсгэлэн худалдааг төслийн баг, хороодын Ажлын албатай хамтран зохион байгуулж, АДРА-Монгол ОУБ-д 5 жилийн хугацаанд амжилттай хамтран ажиллаж, дүүргийн иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, тогтвортой тариалан эрхлэх боломжийг олгосонд талархаж, дүүргийн Засаг даргын Талархал гардууллаа.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Төрийн ордонд зохион байгуулагдсан Хүнсний аюулгүй байдлын Үндэсний чуулганд дүүргийн өрхийн тариалан эрхлэгчид болон хүнсний салбарт идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж буй 12 аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулж, Монгол улсын хүнсний салбарын өнөөгийн байдлын талаар мэргэжлийн байгууллагуудын үнэлэлт дүгнэлт, санал Зөвлөмжийг сонсож, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцсэн.</p>			
121	Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийг сурталчлах, хүн амд зохистой хооллох дадал заншлыг эзэмшүүлэх "Эрүүл хүнс-зөв зохистой хооллолт" сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран иргэдийн дунд зохион байгуулж, зөвлөмж, аргачлалыг боловсруулан хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ	МХХ
		<p>Хоол үйлдвэрлэлийн салбарын ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, зохистой хооллолтын зөвлөмжид нийцсэн тэжээллэг, аюулгүй хоолны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор "Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нь" сэдэвт үзүүлэх сургалтыг дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран Централ таур үйлчилгээний төв дэх Монголиан гүрмэ энд катеринг ХХК-ийн Монет ресторанд хоол үйлдвэрлэлийн технологи, бэйкери үйлдвэрлэлийн цехийн үйл ажиллагааг танилцуулах чиглэлээр зохион байгуулж, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулсан. Сургалтанд хамрагдсан байгууллагуудын удирдах ажилтан, салбарын менежер, дотоод хяналтын ажилтан, тогооч, зөөгч нарыг чадавхжуулах, харилцан туршлага судлуулах, дотоод хяналт шалгалтын үр дүнг сайжруулах зорилгоор хүнсний чанар аюулгүй байдлыг хэрхэн хангах, технологи арга ажиллагааг хэрхэн зөв удирдах, эрүүл ахуйн горимыг хэрхэн ханган ажиллах, эрүүл зөв зохистой хоолны хэрэглээг хэрхэн нэмэгдүүлэх чиглэлээр МХХ-ээс сургалт явуулж, хууль эрх зүйн актуудыг танилцуулан, Монгол улсын мастер тогооч зөвлөмж өгч, Монет рестораны тогооч нар өөрсдийн туршлагаасаа хуваалцлаа. Сургалтын үеэр хүнсний манлай үйлдвэр "Өгөөж чихэр боов", Черри берри бэйкери, "Артизан" компаниуд үйл ажиллагаагаа танилцуулж, үйлдвэрийн бүтээгдэхүүний амталгаа явууллаа. Сургалтанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд НМХГ-ын Батламж олгож, сургалтын талаарх мэдээллийг "Өлзий" телевиз, "Засгийн газрын мэдээ", "Монголын үнэн", "Өнөөдөр" сонин, " Itoim.mn", "<a href="http://Zaluu.com">Zaluu.com</a>", "Ардчилал" сайтуудад байршуулсан.</p> <p>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан удирдамжийн дагуу Хоолны газрын ангилал зэрэглэл, үндсэн шаардлага MNS4946:2005, Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал MNS 39:2011 стандартуудын шаардлагыг хангуулах чиглэлээр хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад аттестатчилал явуулж, нийт 239 газрыг</p>			100%

		<p>хамруулсан. Аттестатчилалд хамрагдсан ААН-д стандартын хэрэгжилтийг хангах, гадна орчны тохижилтыг сайжруулах чиглэлээр дүүргийн Засаг даргын Албан даалгавар өгч, биелэлтийг хангуулан ажилласнаар үйлчилгээний газрууд тухайлбал Баянгол зочид буудал, Корпорайт хотел ХХК-иуд хоол үйлдвэрлэлийн байрны технологи урсгалыг зөв зохион байгуулж, ажилчдын амрах өрөөг тохижуулан, дотоод хяналтын журмыг Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлж, шинэчлэн батлуулан, бүртгэл хөтөлж хэвшсэн зэрэг дэвшил гарсан.</p> <p>Хоол үйлдвэрлэлийн салбарт үйлчилгээний зохистой дадлыг нэвтрүүлэх, хөдөлмөрийн харилцаа, дотоод журам, салбарын хууль тогтоомж, хяналтын хуудсыг хэрэгжүүлэх арга зам зэрэг сэдвүүдээр салбарын ажиллагсдын дунд нийт 6 удаагийн сургалт зохион байгуулж, хоол үйлдвэрлэлийн 600 гаруй аж ахуйн нэгж, иргэдийг хамруулсан. Тухайлбал:</p> <p>Салбарын Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран цайны газрын үйлчилгээ эрхлэгчдэд “Хөдөлмөрийн аюулгүй байдал”, “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний өнөөгийн байдал” “Хүнсний аюулгүй байдал” сэдвүүдээр сургалт зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний талаар хэлэлцүүлэг яриа өрнүүлж, хоол үйлдвэрлэлийн салбарт гарч буй зөрчил дутагдал, түүнийг арилгах арга зүй, технологи ажиллагааны талаар видео хичээл үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.</p> <p>Дүүргийн МХХ-тэй хамтран “Сургууль, цэцэрлэгийн байгууллагуудын хоол хүнсний аюулгүй байдлыг хангах нь”, “Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж”, “Нийтээр үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал нэвтрүүлэх арга зүй”, “Сургууль цэцэрлэгийн эрүүл ахуй, дотоод хяналтын асуудлууд”, “Транс тосны хэрэглээ”, “Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, ул мөрийг мөрдөн тогтоох нь”, “Органик хүнсний үйлдвэрлэлд тавигдах шаардлага” зэрэг сургалтуудыг зохион байгуулж, хоол, хүнсээр дамжих өвчин болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 300 ш зөвлөмж, санамжуудыг тараасан.</p>			
		Олон үндэстний болон цагаан хоолны үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ
122		<p>Монгол улсын Нийслэл Улаанбаатар хотыг “Хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв” болгох зорилтын хүрээнд жуулчдад зориулсан таатай, аюулгүй орчин бий болгох зорилгоор “Шөнийн гэрэлт гудамж” төслийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран 2017 оны 06-10 дугаар сарын хооронд амжилттай зохион байгуулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор гэрэлт гудамжны задгай талбайн үйлчилгээнд олон үндэстний хоолны фестиваль зохион байгуулж, “Модерн номадс”, “Намасте”, “Блүфин”, “Гранд хаан айриш”, “Броадвэй”, “Зочин Монгол зоог” зэрэг Монгол, Энэтхэг, Солонгос, Узбекистан зэрэг улс орнуудын онцлогийг илэрхийлсэн хоолны газрууд 24 цагаар ажиллах нэмэлт цагийн хуваарийн дагуу хоолны үйлчилгээ гаргаж, арга хэмжээнд хүрэлцэн ирсэн иргэд, олон нийт, гадаадын жуулчдад чанар, стандартын шаардлага хангасан</p>			100%

		<p>олон үндэсний хоолны үйлчилгээ үзүүллээ.</p> <p>“Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” уриан дор монгол үндэсний хоол, уламжлалт өв соёлыг сурталчлан таниулах, тогооч нарын ур чадварыг дээшлүүлэх, бүх төрлийн ил гал дээр хийх хоолны үйлчилгээг олон нийтэд сурталчлах зорилгоор 2017 оны 06 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд Үндэсний Соёл амралтын хүрээлэнд “Nomadic BBQ festival”-ыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, нийт 15 аж ахуйн нэгжийг амжилттай оролцуулж, хоолны урлагийг сурталчилсан.</p> <p>Мөн нийслэлийн Аялал, жуулчлалын газар, Монголын зочид буудлуудын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг олон үндэстний хоолны урлагийг сурталчлах “HORECA-ULAANBAATAR-EXPO-2017” үзэсгэлэнд салбарын тэргүүний “Номадс хоспиталити” ХХК, “Шангила Улаанбаатар хотел” ХХК зэрэг томоохон аж ахуйн нэгжүүдийг амжилттай оролцуулсан.</p> <p>Үндэсний их баяр наадам болон Даншиг наадмын худалдаа, үйлчилгээнд дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 100 ААН, иргэнийг дэмжин гаргаж, наадмын хуушуур, хорхог, шорлог, ус, ундаа, амтат хүнс, зайрмаг, бэлэг дурсгалын үзэсгэлэн худалдаа, гэрэл зургийн үйлчилгээ, монгол ахуйг харуулсан үзэсгэлэн зохион байгуулж, наадамчин олон, гадаад дотоодын зочид төлөөлөгч, жуулчдад монгол наадмын онцлогийг харуулсан наадмын амтат хуушуур, цагаан идээний онцлогийг харуулж, Өвөрхангай аймгийн Уянга хийцийн бүрэн тавилга бүхий гэр барин, монгол үндэсний хөхүүрийн айрагны худалдаа гаргаж, наадамчин олонд уламжлал, монгол ахуйг сурталчилсан.</p>				
123	НЗДҮАХ-ийн 5.1.9 дахь заалт; 5.1.7. “Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	100%
		Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сертификаттай сургалтад 8 албан хаагч, Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагчийг хамруулж, сургалтын төлбөрт 830,000 төгрөг зарцуулсан. Богино болон дунд хугацааны гадаад хэлний сургалтад 1, Удирдлагын академийн төрийн захиргааны удирдлагын мэргэшүүлэх сургатад 3 албан хаагч, урт хугацааны магистрын сургалтад 2, докторын сургалтад 1, хос мэргэжил эзэмших бакалаврын сургалтад 4 албан хаагч тус тус суралцаж байна.				
124		Мэдээллийн цагаар ажлын байранд сургах сургалтуудыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	100%
		“Төрийн албан хаагчийн сургалт” хөтөлбөрийн хүрээнд: Албан хаагчдын мэдлэг, мэдээллийг				

		дээшүүлэх, бататгах, шинэ мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор Мэдээллийн цагийг сар бүр зохион байгуулж хэвшсэн ба 2017 онд 11 удаа сургалт зохион байгуулж, албан хаагчдыг хамруулсан байна. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран Засаг даргын Тамгын газар болон хороодын албан хаагчдад “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт, захиргааны байгууллагаас шийдвэр гаргах ажиллагаа, түүний эрх зүйн үр дагавар”, “Цагийн менежмент”, “Орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлага”, “Харилцааны ур чадвар”, “Удирдах ажилтны ур чадвар олгох”, “Эрх зүйн мэдлэг олгох” зэрэг вакумжуулсан сургалтуудыг тус тус зохион байгуулсан.			
		Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ
125		“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа” хөтөлбөрийн хүрээнд: ЗДТГ-ын болон хорооны 16 албан хаагчид орон сууцны нөхцөлөө, сайжруулах, өөрийн орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлж 109 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. Төрийн албан хаагчдыг ажиллах нөхцөлөөр хангах, ажлын байрны ая тухтай нөхцөлийг бүрдүүлэхэд зориулан компьютер, техник хэрэгсэлд 16,022,800 төгрөг, ширээ, сандал, шүүгээ гэх мэт тавилга, эд хогшилд 8,061,500 төгрөг, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын чийрэгжүүлэлтийн танхимыг засварлан тохижуулж, тоног, төхөөрөмжийг нэмэгдүүлэхэд 14,332,000 төгрөг тус тус зарцуулсан байна.			100%
		Батлан хамгаалах бодлого, Батлан хамгаалах багц хууль, тогтоомж, төрийн цэргийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчилна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ЦШ
126	НЗДҮАХ-ийн 5.4.2 дахь заалт; 5.1.8. Дүүргийн иргэдэд батлан хамгаалах төрийн үйлчилгээг хүргэнэ.	2017 оны 01 дүгээр сарын 04-өөс 24-ны өдрүүдэд явагдсан цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын цэргийн бүртгэлийн явцад шинэчлэн батлагдсан Батлан хамгаалах хууль тогтоомж, иргэний цэргийн үүргийн биелэлтийн талаар МҮОНТ, UBS, Эх орон, TV-8, Малчин, 25-р суваг телевиз, МҮОНР болон 102,5 FM –радиоогоор сурталчилгааг зохион байгуулж явуулсан. Цэргийн бүртгэлийн явцад 7, 9, 12, 13, 16, 18, 19, 20 дугаар хороодод батлан хамгаалах хуулийг хэрэгжүүлэхэд иргэний оролцоо сэдвээр ярилцлага өдөрлөгийг зохион байгуулж 700 гаруй иргэнд хууль эрх зүйн мэдлэг олгосон. Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын бүртгэл явагдаж байгаатай холбогдуулан 13 дугаар хороонд 01 дүгээр сарын 12-ны өдөр, 16 дугаар хороонд хороонд 01 дүгээр сарын 19-ны өдөр “Батлан хамгаалах хууль сурталчлах” өдөрлөгийн зохион байгуулж 18 нас хүрсэн 26 иргэнд цэргийн үүрэгтэний үнэмлэх гардуулах, цэргийн жинхэнэ алба болон мөнгөн хэлбэрээр орлуулан хаасан 18 иргэнд батлан хамгаалахын төв архивын лавлагааг үндэслэн цэргийн үүрэгтэний үнэмлэхийг нөхөн олгох тус хорооноос цэргийн жинхэнэ албанд татагдан алба хааж байгаа 14 иргэний ар гэрт хороо болон Олон улсын хүмүүнлэгийн байгууллагаас олгодог			100%

	<p>хүнсний, 3 цэргийн алба хаагчийн ар гэрт тус бүр 100000 төгрөгийн буцалтгүй тусламжийг үзүүлсэн.</p> <p>Шинэчлэгдэн батлагдсан Батлан хамгаалах багц хуулийг сурталчлах ажлын хүрээнд цэргийн бүртгэлийн ажилтай уялдуулан нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсгийн хамт Хөгжим бүжгийн коллежийн ажилчин албан хаагч нарт хуулийн шинэчлэлээр яриа танилцуулга хийлээ.</p> <p>Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 96 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай нийслэлийн Засаг даргын 2017 оны А/73 дугаар захирамжийг үндэслэн дүүргийн хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг Цэргийн штабын бүрэлдэхүүнээр хэлэлцүүлэн 10 ажил үйлчилгээг явуулахаар төлөвлөгөөг боловсруулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.</p> <p>Д.Сүхбаатарын мэндэлсний 124 жилийн ойг тохиолдуулан түүний нэрэмжит ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн талбайд байрлах хөшөөнд цэцэг өргөх хүндэтгэлийн арга хэмжээг Зэвсэгт хүчний 189 дүгээр анги, Зэвсэгт хүчний Жанжин штабын үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүнтэй хамтран зохион байгуулсан. Уг ажиллагаанд дүүргийн Засаг дарга Х.Болормаа, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газрын удирдлага, хэлтсийн дарга нар, 2 дугаар сургуулийн удирдлага, багш сурагчид оролцлоо.</p> <p>Монгол цэргийн музейн “Түүх өгүүлсэн он жилүүд” сэдэвт, Цэргийн дүрэмт хувцасны “Бөртэ” ТӨҮГ-ийн цэргийн дүрэмт хувцасны үзэсгэлэн зэргийг гарган бэлтгэл хурандаа болон Засаг даргын Тамгын газрын ажилтан алба хаагч нарт танилцуулав.</p> <p>Өсвөр үеийн хүүхэд багачуудад цэрэг эх оронч хүмүүжил олгон төлөвшүүлэх үүднээс дүүргийн ерөнхий боловсролын 35 дугаар сургуулийн бага ангийн 70 сурагчдад 03 дугаар сарын 11-ний өдөр, 58 дугаар сургуулийн 3-5 дугаар ангийн 80 сурагчдад 03 дугаар сарын 19-ны өдрүүдэд Монгол цэргийн музейг үзүүлэн эх орон цэрэг эрсээрээ бахархах түүх дурсгалтай танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Сургуулийн удирдлага, сурагчид музей хамт олонд талархал илэрхийлэн дурсгалын зүйл гардуулсан.</p> <p>Музейн удирлагатай Цэргийн штаб энэ үйл ажиллагааг цаашид байнга хамтран зохион байгуулж байхаар болсон.</p> <p>“Эх орон-Эр цэрэг” сэдэвт зохион бичлэгийн уралдааны нэгдүгээр шатыг дүүргийн хэмжээнд зохион байгуулж 75 сурагч бүтээлээ ирүүлснийг дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран шалгаруулан 1-3 дугаар байранд орсон сурагчдад дүүргийн Засаг даргын өргөмжлөл мөнгөн шагналаар, 4-5 дугаар байрт орсон сурагчдад дүүргийн Засаг даргын талархалаар шагнасныг нийслэл, дүүргийн Цэргийн штабуудын ажлаа сурталчлах өдөрлөгийн арга хэмжээний үеэр гардуулан өгсөн.</p> <p>Дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг, спортын “Дөл” тоглолтыг дүүргийн ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд 2017 оны 03 дугаар сарын 11-ний өдөр ҮБХИС-ийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулж, нээлтэнд нийслэлийн Цэргийн штабын орлогч хурандаа Ц.Анхбаяр, дүүргийн Засаг даргын орлогч Ц.Шижир болон тэмцээнд оролцож байгаа сургуулиудын удирдлага цэргийн штабын офицерууд оролцсон.</p>	
--	--	--

	<p>Батлан хамгаалах хууль тогтоомжийг нийслэлийн төр захиргааны авто бааз, Сүхбаатар дэвшил ОНӨҮГ, Хөгжим бүжгийн коллеж, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдийн 180 гаруй иргэдэд шинэчлэгдэн батлагдсан Батлан хамгаалах багц хуулиар танилцуулга хийсэн.</p> <p>БХЯ, ЗХЖШ, ҮБХИС, нийслэлийн болон дүүргүүдийн Цэргийн штаб, яамны харьяа, аж ахуй нэгж байгууллага хамтран Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэдэд сурталчлах зорилготой “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулах ажлын хүрээнд нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2017 оны 11 дүгээр тушаалын дагуу бэлтгэл ажлыг ханган оролцлоо.</p> <p>Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 96 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний 232, 327, 338, Хилийн 0132, 0146, 0184, 0198, 0306 дугаар ангиудад алба хааж байгаа хугацаат болон цэргийн гэрээт алба хааж байгаа дайчидтай уулзан ар гэрийнхий мэндчилгээ захидал, дүүргийн Засаг даргын гарын бэлэг дурсгалын зүйлийг гардуулан, дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээний талаар танилцуулга хийж Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн мэргэжилтнүүд ажил мэргэжлийн судалгааг авч ажлын байранд зуучлах, ар гэрийнхнийг нийгмийн халамж хөтөлбөрт хамруулах судалгааг гарган санал сэтгэгдэлийг нь сонслоо.</p>			
127	Нийслэлийн Засаг даргаас өгөгдсөн дайчилгааны даалгаврыг хэрэгжүүлж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ЦШ
	нийслэлийн Засаг даргаас өгөгдсөн дайчилгааны даалгаврын дагуу бэлтгэл офицер, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн, техникийг анги, командад оногдуулан данслан 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 13-ны өдрийг дуустал Улаанбаатар цэргийн хүрээний Зэвсэгт хүчний анги, байгууллагуудад Цэргийн штабын дайчилгааны офицер өөрийн биеэр очиж тодотгосон, хөдөө орон нутгийн ангиудад оногдуулан данслагдсан дайчилгааны бэлтгэл нөөцийн нэр, татан нийлүүлэх техникийн жагсаалт, тодотгол хийсэн тухай нотломжийг ЗХЖШ-ын шуудангаар тодотгохоор явуулсан.			100%
128	Батлан хамгаалах хууль, тогтоомжийн хяналт, шалгалтыг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, хороодод зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ЦШ
	Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Дайчилгааны тухай хууль, Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, аймаг, нийслэлийн Цэргийн штабын дүрэм, нийслэлийн Цэргийн штабын даргын баталсан хуваарийн дагуу Батлан хамгаалах хууль тогтоомжийн хяналт шалгалтыг дүүргийн Засаг даргын захирамж, удирдамжийг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын			100%

		<p>алба, Засаг даргын Тамгын газар, хороодын ажлын алба, Улсын төв номын сан, “Жуулчин” ХХК зэрэг байгууллагуудын 128 иргэнийг хяналт шалгалтад хамруулан, цэргийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний журам зөрчсөн 26 иргэнийг сануулж, цэргийн үүрэгтний үнэмлэхгүй 12 иргэнд үнэмлэхийг шинээр олгон, цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 11 иргэнд цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр болох 4.8 сая төгрөгийн төлбөрийн мэдэгдэх хуудас бичиж олгон барагдуулахад хяналт тавин ажиллаж 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар нийслэлийн төрийн сангийн 200000984 тоот дансанд 2.9 сая төгрөгийг төвлөрүүлээ.</p>			
129	Цэргийн албаны хуулийн дагуу Цэргийн сургалт, бэлтгэлүүдийг цаг хугацаанд нь зохион байгуулж явуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ЦШ	
		<p>Нийслэл дүүргийн Засаг даргын захирамжийн дагуу 2017 оны бэлтгэл офицер, ахлагч, бэлтгэл үүрэгтний цэргийн бүртгэл явагдахтай холбогдуулан хороодын ажлын хэсгийн дарга, зохион байгуулагч нарт програм нууцын хадгалалтын чиглэлээр 2016 оны 12 дугаар сарын 26-нд, цэргийн бүртгэлийг зохион байгуулах бүрэлдэхүүнтэй 01 дүгээр сарын 04-ний өдрүүдэд нэгдсэн сургалтыг зохион байгуулж ажиллаж заавар зөвлөмжөөр хангасан;</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын сургалт бэлтгэлийн ерөнхий арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хорооны Засаг дарга нарын Цэргийн бэлтгэл сургалтыг 03 дугаар сарын 29-нөөс 31-ний өдрүүдэд онолын хичээлийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд, хээрийн сургалт, дадлагыг Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан;</p> <p>Цэргийн штабын 2017 оны сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн цэргийн мэргэжил олгох сургалтыг 04 дүгээр сарын 17-ноос 04 дүгээр сарын 28-ны өдрийг дуустал Зэвсэгт хүчний 189 дүгээр ангид цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэнг, ҮБХИС-д зохион байгуулагдсан бэлтгэл офицерын сургалтад 2 иргэнийг хамруулсан;</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу нийслэл, дүүргийн цэргийн штабын офицер, ахлагч нарын даргын бэлтгэл сургалтуудад штабын бүрэлдэхүүн бүрэн хамрагдсан;</p> <p>Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй алба хаагч нартай 2017 оны 09 дүгээр сарын 27-ноос 10 дугаар сарын 04-ны өдрүүдэд цэргийн анхан шатны бэлтгэлийг Зэвсэгт хүчний 350 дугаар ангид, үүрэг гүйцэтгэх үеийн мэдлэг олгох гүнзгийрүүлсэн шатны сургалтыг 11 дүгээр сарын 20-ноос 28-ны өдрүүдэд дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Аврах, гал унтараах 45 дугаар ангид сургалтад хамруулсан;</p> <p>ЗХЖШ, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран нийслэл дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дайчилгааны офицер, тоо бүртгэлийн офицеруудтай явуулсан мэргэжил арга зүйн сургалтыг зохион байгуулсан;</p> <p>Цэргийн штабын офицеруудаас улирал бүр батлан хамгаалах багц хууль тогтоомж, цэргийн дүрэм, Зөрчлийн тухай хуулиар шалгалт авч асуудлыг танилцуулан харилцан ярилцаж хууль</p>			100%



		эрх зүйн мэдлэг боловсролоо дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллалаа 100%				
		Цэргийн тоо бүртгэл, цэрэг халалт, татлага, цэргийн гэрээт албыг сурталчлах, элсүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ЦШ	
130		Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/186, дүүргийн Засаг даргын А/117 дугаар захирамжуудыг удирдлага болгон тус дүүргийн нутаг дэвсгэрт цэргийн жинхэнэ албаны 2017 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 2017 оны 05 дугаар сарын 05-наас 07-ны өдрүүдэд зохион байгуулан явууллаа. Тус дүүргийн цэрэг татлагын байрны эрүүл мэндийн үзлэгээр 2670 нь биеэр орж асуудлаа шийдвэрлүүлсэн бөгөөд тэдний 497 нь буюу 18.6 хувь нь эрүүл мэндээр, 1593 нь буюу 58.3 хувь нь суралцахаар, 497 нь буюу 18.6 хувь нь ар гэрийн гачигдлаар, 3 иргэн хэргийн холбогдолтой гэсэн шалтгаанаар түр чөлөөлөгдөж, 144 иргэнийг цэргийн албанд тэнцүүлж, нийслэлийн цэрэг татлагын товчооноос ирүүлсэн хяналтын тоог 100 хувь биелүүлсэн 2017 оны цэргийн бүртгэл, хороодод батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах ажил үйлчилгээ, Батлан хамгаалах хууль тогтоомжийн хяналт шалгалт, батлан хамгаалах яам, нийслэл дүүргийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын үйл ажиллагаагаа сурталчлах өдөрлөг, бусад баярын арга хэмжээ нээлттэй хаалганы өдөрлөгүүдээр цэргийн гэрээт алба-ажлыг байрыг сурталчлснаар 2017 оны нэгдүгээр ээлжээр сайн дурын үндсэн дээр гэрээгээр цэргийн алба хаалгуулах хяналтын тоон даалгаврыг бүрэн биелүүлсэн анги байгууллагуудад хүргүүлэн 6 иргэнийг ажлын байраар хангасан. 100%				100%
<b>5.2 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.</b>						
131	НЗДҮАХ-ийн 4.7.7 дахь заалт; 5.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгж, үүний дотор Старт ап бизнес компаниуд, инновацийн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудыг хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хамруулна.	Хөгжлийн бэрхшээлтэй хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн өөрөө өөртөө ажлын байр бий болгох санал, санаачлагыг дэмжих төсөл зарлан, шаардлагатай санхүүжилтийг зориулалтын дагуу олгоно.	Олгох санхүүжилт, хувиар	100	ХХҮХ	ЖДҮДТ
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 106 иргэний төслийг хүлээн авч 50 төслийг ажлын хэсгээр дэмжин нийт 180 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. 50 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажлын байртай болсон.				100%
132		Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн бизнесээ өргөжүүлэх, ажлын байр бий болгоход чиглэсэн төслийг хүлээн авч санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ	ЖДҮДТ
		“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгийн хүрээнд Сүхбаатар дүүргийн хэмжээнд 2 удаа /хавар, намар/ төсөл зарласнаас нийт 152 төсөл ирүүлж 69 иргэний төслийг ажлын хэсгээр дэмжин 198 сая төгрөгийг 2 жилийн хугацаатай 100%-ийн эргэн төлөлттэй олгосон. 69 төслийн хүрээнд нийт 87 ажлын байр бий болсон.				100%
133		Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, нөхөрлөл,	Үйл	100	ХХҮХ	ЖДҮДТ

		хоршоодод ажлын байр нэмэгдүүлэх жижиг зээлийг арилжааны банкаар дамжуулан олгоно.	ажиллагааны хэрэгжилт, хувиар			
		Ажлын байр нэмэгдүүлэх жижиг зээлийг Голомт банкаар дамжуулан олгож байгаа бөгөөд 2017 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар 18 иргэн, аж ахуйн нэгжид 255 сая төгрөгийн зээл олгож 95 ажлын байр бий болсон.				90%
134	НЗДҮАХ-ийн 4.7.3 дахь заалт; 5.2.2. Дүүргийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчид болон өрхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн борлуулах борлуулалтыг дэмжиж ажиллана.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсан иргэдийн борлуулалтыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор томоохон худалдааны төвүүдэд борлуулалтын цэг ажиллуулах арга хэмжээ зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ	ЖДҮДТ
		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан болон хөтөлбөрт хамрагдах шийдвэр гарсан иргэдээс борлуулалтын цэгт ажиллах иргэдийн судалгааг гаргасан. Борлуулалтын цэг ажиллуулах худалдааны төвүүдийг судлан СБД-ийн 8-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Саруул зах” худалдааны төвд ажиллуулж байна. Дээрх борлуулалтын цэгт өмнө нь төсөл, хөтөлбөрт хамрагдаж байсан нийт 10 иргэн бараа бүтээгдэхүүнээ худалдан борлуулахаар гэрээ байгуулан ажиллаж байна.				
135	5.2.3. Зорилтот бүлгийн иргэн, нөхөрлөл, хоршоодыг бизнес инкубацийн арга хэмжээнд хамруулна.	Зорилтот бүлгийн шаардлага хангасан иргэдийг үйлдвэрлэл, үйлчилгээний түрээсийн хөнгөлөлтийн арга хэмжээнд хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ	ЖДҮДТ
		“Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт”-д төсөл, хөтөлбөр, жижиг зээлд хамрагдсан иргэдээс хөтөлбөрт заасан шаардлага хангасан, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байгаа 18 иргэнийг хамруулж 8.501.396 төгрөгийн хөнгөлөлтийг буцаан олгосон.				
136	5.2.4. Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийн төвийг түшиглэн Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт, судалгаа, мэдээллийн төвийг байгуулна.	Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт, судалгаа, мэдээллийн төвийг байгуулах судалгааг гаргана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ	ЖДҮДТ
		Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийн судалгаа, мэдээллийн төвийг байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Улсын бүртгэл, оюуны өмчийг газар, НЖДҮДТөвийн мэдээллийн санд бүртгэгдсэн 153 аж ахуйн нэгж, дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэгдсэн 2514 үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, иргэн, дүүргийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн мэдээллийн санд бүртгэгдсэн 113 ХХК, 926 өрхийн үйлдвэрлэгчдийн мэдээлэлд тулгуурлан судалгаа, бүртгэл мэдээллийн санг баяжуулах ажил хийгдэж байна. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газар, “Нийгмийн судалгаа, мэдээллийн төв” ТББ-тай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн тооллогыг				90%

		2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлүүлж, мэдээллийн санд бүртгэж байна. Одоогийн байдлаар дүүргийн 20 хороодоос 1132 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдээллийг авч, судалгааг шинэчилж байна.				
137	5.2.5. Дүүргийн жижиг, дунд үйлдвэр, бичил бизнес, өрхийн үйлвэрлэлийг хөгжүүлэхэд Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллана.	Монгол улсын Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин олгож буй зээлийн талаарх мэдээллийг олон нийтэд гарын авлага хэвлүүлэн, сурталчлан түгээж, бизнес эрхлэгчдийг хамруулан ажиллана.	Сургалтанд хамрагдах үйлдвэр эрхлэгчид, тоо	100	ХХҮХ	ЖДҮДТ
		Монгол улсын Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин олгож буй зээлийн талаарх мэдээллийг үйлдвэрлэгчдэд төвийн цахим хуудас болон мэдээллийн самбараар мэдээлэн ажиллаж байна. Үүнд: 1. НЖДҮДТөвийн зээлийн мэдээлэл 2. Банкнуудаас олгогдож буй жижиг дунд үйлдвэрлэгчдэд зориулсан зээлийн бүтэгдэхүүний мэдээлэл 2017 оны 11 дүгээр сард “Зээлд хамрагдахад анхаарах асуудал” сэдвээр 1-20 дугаар хороодын жижиг, дунд үйлдвэр, эрхлэгчдийн дунд зохион байгууллаа. Сургалтын хүрээнд “Төсөл боловсруулах арга зүйн гарын авлага, Санхүүгийн бүртгэл хэрхэн хөтлөх, бизнесийн зээл авахдаа юунд анхаарах хэрэгтэй вэ” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулагдаж одоогийн байдлаар 125 үйлдвэр эрхлэгчдэд хамрагдаж гарын авлага, тараах материалаар хангалаа.				
138	НЗДҮАХ-ийн 5.7.3 дахь заалт; 5.2.6. Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, хамтран ажиллах, гадаад болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх боломжийг бүрдүүлнэ.	Дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, чадавхжуулах сургалтад хамруулна.	Зөвлөх үйлчилгээ авах үйлдвэр эрхлэгчид, тоо	100	ХХҮХ	ЖДҮДТ
		Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвөөс 2017 оны 03, 06 дугаар саруудад зохион байгуулсан "Бизнес санааг төлөвлөх нь", "Асуудал ба бизнесийн санаа" сэдэвт 2 удаагийн сургалтанд салбарын 100 ажиллагсдыг хамруулж, 3 өдрийн шаталсан сургалтаар хэрхэн бизнесээ өргөжүүлэх, шинэ санаа олох, бизнес төлөвлөгөө хэрхэн боловсруулах зэрэг мэдлэг чадварыг олгосон. Мөн дүүргийн ахуйн үйлчилгээний салбарт ажиллаж буй иргэдэд зориулсан Бүтээгдэхүүн үйлчилгээний маркетингийг хэрхэн борлуулалтын өсөлттэй холбон хэрэглэгчийн сонголтыг хөнгөвчлөх ухаалаг байдлаар хийх аргачлалд сургах ур чадварыг дээшлүүлэх, сургалтаар олж авсан мэдлэгээ шууд ашиглах боломжийг олгох Бизнесийн маркетинг сургалтыг БЭЭТ-тэй хамтран зохион байгуулж, маркетингийн ойлголтыг 5W1H аргачлалаар боловсруулсан тусгай tool-дээр тулгуурлан явуулж, худалдан авалтын туршлага дээр үндэслэн маркетингийн ажлын чиг баримжааг ойлгох, өмнөх туршлагаасаа үндэслэн бүтээгдэхүүний маркетинг хийж сурах дадлыг үйлчилгээний салбарын 40 ажилтанд эзэмшүүлсэн.  Мөн ахуйн үйлчилгээ болон хөнгөн үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байгаа бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээ, хууль эрх				

		<p>зүйн актуудыг танилцуулах, төсөл хөтөлбөрт хэрхэн хамрагдах, төсөл хэрхэн бичих талаархи сургалтыг дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрийн төв, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвтэй хамтран салбарын ажиллагсдын ур чадварыг сайжруулах “Үйлчилгээний чанар стандарт-Ур чадвар-2017” сургалтанд үйлдвэрлэл, үйлчилгээний 40 гаруй иргэдийг хамруулсан.</p> <p>Жижиг, дунд үйлдвэрлэгчдэд олгох зээлийн талаархи мэдээлэл олгох, төсөл бичих аргачлалд сургах чиглэлээр НЖДҮДТ-тэй хамтран 2 удаа сургалт явуулж, 22 үйлдвэрлэгчдэд сертификат гардуулсан.</p> <p>Дүүргийн Татварын хэлтэс, ХөХҮХ, ЖДҮДТ-тэй хамтран жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй татварын хөнгөлөлт, зохицуулалт, ХөХҮХ-ээс олгогдож байгаа төсөл хөтөлбөрийн талаар сургалт мэдээлэл, бизнесийн зөвлөгөөг зохион байгуулж, нийт 67 иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг оролцуулсан.</p> <p>Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газар болон нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас боловсруулсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих 2017-2020 хөтөлбөрийн төслийн хэлэлцүүлэгт оролцож, санал солилцож, 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдөрт Төрийн ордонд зохион байгуулагдах хуулийн хэлэлцүүлэгт аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог хангаж, нийт 45 төлөөллийг оролцуулсан.</p> <p>Үндэсний аж үйлдвэрийн зөвлөлөөс Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл доор 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр “Оёдлын салбарын өнөөгийн байдал, гарц” сэдэвт уулзалт хэлэлцүүлэгийг салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүд, үйлдвэрлэгчдийн дунд МУ-ын Засгийн газар, УИХ дахь “Үйлдвэржилтийг дэмжих”, болон “Эмэгтэйчүүдийн ажлын байрыг дэмжих” лобби бүлэг, ХХААХҮЯ, Үндэсний хөгжлийн газар зэрэг төр хувийн хэвшлийн байгууллагуудыг хамруулан төрийн ордны Их танхимд зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт оролцлоо.</p> <p>Зөвлөгөөний үеэр салбарын мэргэжлийн холбоодоос боловсруулсан хууль, эрх зүйн баримт бичгийн төслийг Монгол улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад өргөн барилаа. Оёдлын салбарын хөгжил дэвшил, цаашдын гарцын талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл санал бодлоо хуваалцлаа. Сүхбаатар дүүргийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвөөс 25, хороо тус бүрээс 4 иргэн, нийт 105 үйлдвэрлэгч зөвлөгөөнд хамрагдлаа.</p>				
139		<p>Дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж дотоод гадаадын үзэсгэлэн, яармаг худалдаанд хамруулж, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Зохион байгуулах үзэсгэлэн худалдаа, тоо</p>	4 удаа	ХХҮХ	ЖДҮДТ
		<p>Дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин зах зээлд бараа бүтээгдэхүүнийг нь сурталчлах, харилцан туршлага судлах, дэвшилтэт тэргүүний техник технологитой танилцах, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлж, санхүүгийн чадавхийг сайжруулах зорилгоор ОХУ-</p>				100%

	<p>ын Эрхүү, БНХАУ-ын Эрээн хот, Хөх хот зэрэг гадаад улс орнуудад болон дотоодын “Цагаан сар-2017”, “Сүхбаатарт үйлдвэрлэв”, “Хүрээ цам-даншиг наадам-2017”, “Улаанбаатар түншлэл-2017” зэрэг 10 гаруй удаагийн үзэсгэлэн яармаг худалдаанд давхардсан тоогоор 200 гаруй үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулж, зах зээлд гарах гарцыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээг нийтэд таниулах, сурталчлах ажлыг зохион байгууллаа. Тухайлбал:</p> <p>Сар шинийн баярыг угтаж, дүүргийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, өргөтгөсөн худалдааны талбайн түрээсийн хөнгөлөлт олгож дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн дэргэдэх “Сүхбаатарт үйлдвэрлэв” нэрийн барааны дэлгүүр болон Мишээл экспо төв зохион байгуулагдсан “Цагаан сар-2017” үзэсгэлэнд 30 гаруй үйлдвэрлэгчдийг дэмжин оролцуулж, 40 гаруй нэр төрлийн 1000 ш, 10,399,000 төгрөгийн бараа бүтээгдэхүүний борлуулалт хийсэн.</p> <p>Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулагдсан дүүргийн “Ажил олгогчдын чуулган”-д дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг өргөнөөр оролцуулж, 40 үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн хүүхдийн гутал, монгол дээл, хөөрөг чулууны урлал, савхин эдлэл, арьсан урлалын бүтээгдэхүүнийг нийтэд сурталчлан, борлуулалтыг дэмжин ажиллалаа.</p> <p>МҮХАҮТ-аас 2017 оны 06 дугаар сарын 2-4-ний өдрүүдэд БНХАУ-ын Эрээн хотноо зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд ЖДҮТөвийн бойжигч Р.Батнаран, Б.Зоёо, Ш.Мөнхбаатар нар оролцож, үндэсний хувцас, сүлжмэл бүтээгдэхүүн зэрэг үндэсний бүтээгдэхүүнээ худалдан борлуулж, гадаадад монгол ёс заншлаа сурталчиллаа.</p> <p>Монголын Үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордонд зохион байгуулагдсан “Улаанбаатарт үйлдвэрлэв-2017” үзэсгэлэнд дүүргийн 33 үйлдвэрлэл эрхлэгч идэвхтэй оролцож, үзэсгэлэнгийн шилдгийн шилдэг үйлдвэрлэгчээр Сүхбаатар дүүргийн “Мон ланс” ХХК, “Монгол шаглаа” ХХК-ийн хамт олон шалгарч, ӨМӨЗО-ны Хөх хотод зохион байгуулагдах “Монгол-Хятадын 2-дугаар экспо” үзэсгэлэн худалдаанд үнэгүй оролцох эрхийн бичиг, өргөмжлөлөөр, Үндэсний дээл хувцас үйлдвэрлэгч 13 дугаар хорооны өрхийн үйлдвэрлэгч Б.Даваажав шилдэг оролцогчоор шалгарч, Өргөмжлөл, 500 мянган төгрөгөөр шагнагдсан. Уг үзэсгэлэнгийн арга хэмжээнд оролцсон үйлдвэрлэгчид нийт 2.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.</p> <p>Нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулагдсан Хүүхдийн баяр, Улаанбаатар марафон-2017, Баяр наадмын үйлчилгээ, Даншиг наадам, Сөүлийн гудамжны Шөнийн гэрэлт гудамж зэрэг нэгдсэн арга хэмжээнүүдэд торгоны салон, хүүхдийн гутал, хувцасны үйлдвэрлэл, үндэсний зураг бүхий футболканы үйлдвэрлэл, жааз бэлэг дурсгалын үйлдвэрлэл, монгол үндэсний ахуй соёлын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, “Дуут урлан” алт мөнгөн сийлбэртэй бурхан шашны бүтээлүүд, монголын эртний хэв шинжийг агуулсан үнэт эдлэл, ховор хийцийн гар урлалын бүтээл, “Нүүдэлчин сэрэхүй” арьсан урлал зэрэг үйлдвэрлэгчдийг үзэсгэлэн худалдаанд гаргаж, бүтээгдэхүүнийг сурталчлан, борлуулалтын сувгийг нээж өгсөн. Эдгээр арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 100 гаруй жижиг, дунд бизнес эрхлэгчид оролцож, нийт 7,5 сая гаруй төгрөгийн борлуулалт хийсэн байна.</p> <p>Нийслэлийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоотой хамтран 2017 оны 11 дүгээр сарын 30, 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд Соёлын төв өргөөнд зохион байгуулах “Бүтээлч бизнес</p>	
--	---	--

	эрхлэгч эмэгтэй” үзэсгэлэнд дүүргийн ноос, ноолууран бүтээгдэхүүн, монгол дээл болон хувцас үйлдвэрлэл, бүжгийн гутал, ээтэн гутлын үйлдвэрлэл эрхлэгч 5 аж ахуйн нэгж, иргэнийг оролцуулах бэлтгэл ажлыг хангаад байна.				
	Тэргүүний үйл ажиллагаатай үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын үйл ажиллагаатай жижиг, дунд үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгчдийг танилцуулж, харилцан туршлага судлуулах аялал зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ	ЖДҮДТ
140	Монголын үндэсний брэнд “Urban jeans” ХХК-тай хамтран дүүргийн 48 үйлдвэрлэл эрхлэгчдийг үйлдвэртэй танилцуулах аялалыг 2 удаа зохион байгуулж үйлдвэрийн бүтэц, бүтээгдэхүүний дамжлага хэрхэн явагдаж байгаатай танилцууллаа. Үйлдвэр эрхлэгчдийн хувьд массын үйлдвэрлэлийн зарчим, шинэлэг техник тоног төхөөрөмжүүд, орчин үеийн чиг хандлага зах зээлээ тодорхойлж буй хүчирхэг маркетингийн албатай танилцсан нь үйлдвэрлэгчидэд урам зориг өгөх шинийг эрэлхийлэх сэдлийг өгсөн гэдгийг үйлдвэрлэгч нар ярьж байлаа. Шинээр үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрлэгч нарын бас сонирхолыг татаж байсан зүйл нь шошго, сав баглаа боодол байсан. Үүнийг жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нар хялбар байдлаар овор багатай тоног төхөөрөмжөөр шийдсэн байсан нь бас нэг давуу тал байсан юм. Оёдолын чиглэлээр 100 гаруй оёдолчинтой ажилладаг тус үйлдвэрийн ажилчид нь тогтвор суурьшилгүй байдаг нь нэг бэрхшээл байдаг тиймээс бид Жижиг дунд үйлдвэрлэлийн оёдолчинтой хамтарч ажиллах саналтай байгаагаа илэрхийллээ.				70%
	Ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах сонирхол бүхий иргэдэд төлөвлөлт, төсөл боловсруулах, аж ахуй эрхлэх ур чадвар эзэмших, зах зээлийн өрсөлдөөний тухай ойлголт, соёлыг төлөвшүүлэх сургалт зохион байгуулна.	Сургалтанд хамрагдах үйлдвэр эрхлэгчид, тоо	100	ХХҮХ	
141	Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвөөс 2017 оны 03, 06 дугаар саруудад зохион байгуулсан "Бизнес санааг төлөвлөх нь", "Асуудал ба бизнесийн санаа" сэдэвт 2 удаагийн сургалтанд салбарын 14 ажиллагсдыг хамруулж, 3 өдрийн шаталсан сургалтаар хэрхэн бизнесээ өргөжүүлэх, шинэ санаа олох, бизнес төлөвлөгөө хэрхэн боловсруулах зэрэг мэдлэг чадварыг олгосон. Мөн дүүргийн ахуйн үйлчилгээний салбарт ажиллаж буй иргэдэд зориулсан Бүтээгдэхүүн / үйлчилгээний маркетингийг хэрхэн борлуулалтын өсөлттэй холбон хэрэглэгчийн сонголтыг хөнгөвчлөх ухаалаг байдлаар хийх аргачлалд сургах ур чадварыг дээшлүүлэх, сургалтаар олж авсан мэдлэгээ шууд ашиглах боломжийг олгох Бизнесийн маркетинг сургалтыг БЭЭТ-тэй хамтран зохион байгуулж, маркетингийн ойлголтыг 5W1H аргачлалаар боловсруулсан тусгай tool-дээр тулгуурлан явуулж, худалдан авалтын туршлага дээр үндэслэн маркетингийн ажлын чиг баримжааг ойлгох, өмнөх туршлагаасаа үндэслэн бүтээгдэхүүний маркетинг хийж сурах дадлыг үйлчилгээний салбарын 60 ажилтанд эзэмшүүлсэн. Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст				100%

		<p>дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй инноваци нэвтрүүлсэн ахуйн үйлчилгээний салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын судалгааг <a href="mailto:ubtour@yahoo.com">ubtour@yahoo.com</a> цахим хаягаар хүргүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрийн газрууд болон шинэ техник, технологи, нэвтрүүлсэн ААНБ-ийн судалгааг шинэчлэн, бусад ААНБ-ууд болон иргэдэд сурталчлан таниулах, харилцан туршлага судлуулах аялал зохион байгуулахаар бэлтгэл ажил хангасан.</p> <p>Халдварт өвчин судлалын Үндэсний төвтэй хамтран БЗДХ, ХДХВ/ДОХ-ын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт зочид буудал, дэн буудал, саун, массажны үйлчилгээ эрхлэгч 30 гаруй иргэн, аж ахуйн нэгжүүдэд нөлөөллийн уулзалт зохион байгуулж, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд аж ахуйн нэгж, байгууллагуудын үүрэг оролцоог идэвхжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллах талаар санал солилцсон. Сургалтанд оролцсон үйлчилгээ эрхлэгчдэд Төгс бүсгүйчүүд ТББ, Сүхбаатар дүүргийн Сэтгэл амар төв, Нийслэлийн аялал жуулчлалын газар, нийслэлийн Эрүүл мэндийн газар, ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албаны холбогдох мэргэжилтнүүд мэдээлэл хийж, Зочлох үйлчилгээний стандарт, Жуулчны бааз, Зочид буудлын үйлчилгээний стандарт, Дэн буудлын үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага зэрэг стандартууд, Аз жаргалтай Улаанбаатар хөтөлбөрүүдийг танилцуулж, мэргэжлийн заавар зөвлөгөө өгч, байгууллага бүрт Сэтгэл амар төвөөс үнэ төлбөргүй 1 хайрцаг бэлгэвч тарааж, цаашид бүх үйлчилгээний газрууд бэлгэвчний үнийг үйлчилгээний үнэндээ шингээж, байнга бэлэн байлгах чиглэл өгсөн.</p> <p>Мөн ахуйн үйлчилгээний салбарын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээ, хууль эрх зүйн актуудыг танилцуулах, төсөл хөтөлбөрт хэрхэн хамрагдах, төсөл хэрхэн бичих талаархи сургалтыг дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, нийслэлийн Жижиг, джнд үйлдвэрийн төв, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвтэй хамтран салбарын ажиллагсдын ур чадварыг сайжруулах “Үйлчилгээний чанар стандарт-Ур чадвар-2017” сургалтанд үйлдвэрлэл, үйлчилгээний 40 гаруй иргэдийг хамруулсан.</p> <p>Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газар болон нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас боловсруулсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих 2017-2020 хөтөлбөрийн төслийн хэлэлцүүлэгт оролцож, санал солилцсон.</p>			
142		<p>Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд аттестатчилал явуулна. /Халуун ус, үсчин гоо сайхан, гуталчин, ломбард гэх мэт/</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	ХХҮХ
		<p>Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны даргын баталсан 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн удирдамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй саун, массажны газруудын үйл ажиллагаанд Монгол улсын Эрүүл мэндийн тухай, Эрүүл ахуйн тухай хууль, Садар самууны тухай, Стандартчилал, тохирлын</p>			100%

		<p>үнэлгээний тухай хуулиуд болон Монгол улсын Засгийн газрын 2005 оны Стандартчилал, тохирлын үнэлгээний ажлыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай 127 дугаар тогтоол, 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Саун. Ерөнхий шаардлага MNS 5164:2010 стандарт, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлын 2014 оны 07 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг шалгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах, үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний саналыг холбогдох байгууллагуудад тавьж, шийдвэрлүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Стандарт, Хэмжил зүйн газар, Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг 2017 оны 04 дүгээр сарын 21-26-ны өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 19 аж ахуйн нэгж, иргэний 9 саун, 2 бариа засал, 14 массаж /хөл, бүтэн бие, алжаал тайлах/, 1 гоо сайхны спа, 1 вакс үйлчилгээнд үзлэг, шалгалтыг явуулж, стандартын шаардлага хангаагүй 3 ААН, иргэнд нийт 600,0 мянган төгрөгний торгууль оногдуулж, 2 газрын үйл ажиллагааг түр зогсоож, холбогдох саналыг УБ хотын ЗАА-д хүргүүлсэн.</p> <p>Дүүргийн өмчид бүртгэлтэй 6 халуун усны газруудын үйл ажиллагаанд дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгтэй хамтран хамтран үзлэг, тооллого хийж, үйлчилгээний чанар аюулгүй байдалд хяналт шалгалт явуулсан. Дүүргийн өмчид бүртгэлтэй халуун усны газруудад үйлчилгээний стандарт шаардлага хангах чиглэлээр үүрэг чиглэл өгч, 2018 онд дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтрач эрсдлийн үнэлгээ тогтооно. Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй халуун усны газруудын судалгааг шинэчлэн гаргаж, 2017 оны эрүүл аюулгүй индексийг тодорхойлсон. Дүүргийн нутаг дэвсгэрт 126 шүршүүр бүхий 21 халуун усны газар ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.5.4 дэх “Улаанбаатар хотод тулгамдаж буй асуудал/ агаар, ус, хөрсний бохирдол, нийтийн тээвэр/-ыг шийдвэрлэхэд гадаад улс, хотуудын туршлагаас судалу нэвтрүүлнэ” гэж заасны дагуу нийслэлийн гэр хорооллын оршин суугчдын амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор “Нийтийн ахуйн үйлчилгээ, автомат угаалгын газар”-ыг гэр хороололд байгуулах ажлын хүрээнд дүүргийн 12, 13, 14, 15, 16 дугаар хороодын иргэдээс судалгаа авч нэгтгэн, Улаанбаатар хотын Хөгжлийн корпораци ХК-д 2017 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 2/1739 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p>				
143	"Үсчин, гоо засалчдын Сүхбаатар-2017" уралдаант тэмцээн зохион байгуулна.	- Франц улсад зохион байгуулагдсан 2017 оны	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ	90%



		<p>засалчдын тэмцээнд Ази тивийн 3 удаагийн аварга, Европ тивийн аварга, Дэлхийн аваргын хүрэл медальт, Монгол улсын мастер үсчин, дүүргийн Хос шагай салоны захирал Н.Алтаншагайг дүүргийн Сарнайх гоёлын студи, Туяарах салон, Монголын үсчин гоо засалчдын холбоо зэрэг мэргэжлийн байгууллагууд болон төр, засгаас дэмжиж, санхүүгийн дэмжлэг үзүүлэн, дэмжиж ажилласнаар Дэлхийн аваргын тэмцээнд Тусгай байр эзэлж, Холбооны Хүндэт өргөмжлөлөөр шагнагдаж, Монгол Улсын нэр хүндийг дэлхийн тавцанд дахин цуурайтууллаа.</p> <p>- Нийслэлийн хэмжээнд 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Бөхийн өргөөнд зохион байгуулагдах "Улаанбаатар-2017" мэргэжлийн аварга шалгаруулах үсчин, гоо засалч, хумс дизайн урлалын 10 дахь тэмцээн уралдаант тэмцээнд дүүргийн үсчин гоо засалчдыг идэвхтэй оролцуулах зорилгоор дүүргийн цахим хуудас болон нүүр номонд тэмцээний удирдамж, танилцуулга, тэмцээний онцлог болох "Хүрээ хотын гангачууд" ахмад, залуу мастер үсчдийн 1970-2015 оны үс засалтын шоу үзүүлбэр мөн Монгол улсад анх үсчин, гоо засалчдын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж байсан түүхэн замнал фото зургийн үзэсгэлэнгийн талаархи мэдээллийг байрлуулан нийтэд сурталчилж, Хороодын Ажлын алба болон дүүргийн Үсчин гоо засалчдын салбар хороотой хамтран удирдамжийг тарааж, тэмцээний бэлтгэлийг хангаж, дүүргийн салбарын ажилчдыг идэвхжүүлж байна.</p>			
144		<p>Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажлыг дүгнэж, салбарын тэргүүний ААН, иргэдийн шагнаж урамшуулна.</p> <p>Дүүргийн 16 дугаар хорооны иргэн, өрхийн тариалан эрхлэгч Нийслэл, дүүргийн тэргүүний тариаланч Ж.Наранцэцэгийн хүнсний салбарт ажилласан 25 жилийн хөдөлмөрийг Төр засгаас өндрөөр үнэлж, Алтан гадас одонгоор шагнасан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Өвлийн наадам зохион байгуулах тухай А/36 дугаар захирамжийн хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулагдсан "Улаанбаатарын өвлийн наадам-2017" гэр бүлийн баярын арга хэмжээнд дүүргийн 150 гаруй аж ахуйн нэгж, иргэдийг амжилттай оролцуулж, наадамд оролцогсдын дунд зохион байгуулсан "Үндэсний хувцас"-ны шалгаруулалтын төрөлд 18 дугаар хорооны иргэн Н.Отгонжаргал, Х.Эрдэнэцэцэг нар шалгарч, нийслэлийн Засаг даргын Хүндэт Өргөмжлөл, дурсгалын зүйлсээр шагнагдсан.</p> <p>Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжаар баталсан "Гэр бүлд ээлтэй байгууллага" шалгаруулах удирдамжийн дагуу гэр бүлд чиглэсэн бүтээлч, ажил үйлчилгээг үзүүлж, иргэдийн талархлыг хүлээсэн худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, урамшуулах зорилгоор "Хүүхэд, гэр бүлд ээлтэй үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага", "Хүүхэд, гэр бүлд ээлтэй худалдаа, үйлчилгээний байгууллага"-ын төрөлд үйлдвэрлэлийн салбараас "Тод оймс" ХХК, "Өгөөж чихэр боов" ХХК, "АСУВ" ХХК, "Жэй эн кэй" ХХК, "Аз хур" ХХК-уудыг дэмжин, нэр дэвшүүлж, холбогдох материалуудыг дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст хүргүүлсэн. Шалгаруулалт 2017 оны 12 дугаар сарын 22-</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ
					70%

		ны өдөр болно.			
145		Салбарын ажилчдын дунд ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ
		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын тогооч нарын холбооноос зохион байгуулсан Монгол туургатнуудын аварга тогооч шалгаруулах “Улаанбаатар-2017” уралдаант тэмцээнд хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 12 аж ахуйн нэгж, 3 тогоочийг амжилттай оролцуулж, тэмцээний шагналт байранд орсон.			100%
146		Хэрэглэгчийн өдөрлөг, Нийслэлийн өдөр, Хичээлийн шинэ жил, Иргэдийн өдөрлөг, Наадам зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ХХҮХ
		<p>Олон Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан дүүргийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хэрэглээний талаарх тэдний мэдлэг боловсрол, соёл, хандлага, хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах зорилгоор “ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ДЭЭДЛЭЭ” өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр иргэдэд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль болон Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг танилцуулж, хууль эрх зүйн мэдээллээр хангаж, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсээс хэрэглэгчдэд зориулж хүнсний чанар аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн, эмийг хэрхэн зөв сонгох талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хадгалалтын хугацаа дууссан, шошгын шаардлага хангаагүй, Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэлгүй эм, хүнсний бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гарган иргэдэд зөвлөмж, сэрэмжлүүлэг, гарын авлага тарааж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээ. Өдөрлөгт 150 гаруй иргэн, аж ахуйн нэгж оролцов.</p> <p>Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад “Хэрэглэгчийн үндсэн эрх” сэдвээр мэдээлэл хийж цагийн сургалт зохион байгуулж, хэрэглэгчийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд төрийн захиргааны албан хаагчдын үүрэг, оролцоо ямар байх талаар ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах газрын дарга Ц.Лхагвасүрэн, нийслэлийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн гүйцэтгэх захирал С.Тойвгоо нар сонсгол мэдээлэл хийлээ. Сургалтад 60 төрийн хаагч хамрагдсан. Өдөрлөгийн арга хэмжээний үеэр Хэрэглэгчийн эрхийн чиглэлээр Асуумж явуулж, 20 иргэний санал хүсэлт, гомдол саналыг түргэн шуурхай шийдвэрлэсэн.</p> <p>Үндэсний их баяр наадам болон Даншиг наадмын худалдаа, үйлчилгээг Төв цэнгэлдэх хүрээлэнгийн 1-3 дугаар секцийн гадна талбайд зохион байгуулж, дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэдээс сонгон шалгаруулан, холбогдох зөвшөөрөл олгож, баяр наадмын үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавин ажиллалаа. Баяр наадмын 2 удаагийн арга хэмжээнд нийт 100 ААН,</p>			100%

	<p>иргэн наадмын хуушуур, хорхог, шорлог, ус, ундаа, амтат хүнс, зайрмаг, бэлэг дурсгалын үзэсгэлэн худалдаа, гэрэл зургийн үйлчилгээ, монгол ахуйг харуулсан үзэсгэлэн гаргаж, наадамчин олон, гадаад дотоодын зочид төлөөлөгч, жуулчдад монгол наадмын онцлогийг харуулсан үйлчилгээг үзүүллээ. Аж ахуйн нэгж, байгууллагуудад мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч, баяр наадмын болон Сүхбаатар дүүргийн лого бүхий хаяг, ижил өнгийн жигд ажлын хувцсаар хангаж, худалдаа, үйлчилгээний чанар аюулгүй байдалд Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, нийслэлийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэстэй хамтран хяналт тавин ажиллалаа. Хөдөө орон нутгаас ирсэн зөвшөөрөлгүй айрагны худалдаа эрхэлж байсан 10 гаруй иргэн, малгай, нүдний шил, хүүхдийн тоглоом зэрэг зөвшөөрөлгүй худалдаа эрхэлж байсан 12 иргэнд холбогдох журмыг танилцуулж, худалдаалалтыг зогсоож, хяналт тавин ажилласан.</p> <p>Улаанбаатар хотод өвлийн спортыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Хүй долоон худаг дахь “Монгол наадам цогцолбор”-т өвлийн спорт, аялал жуулчлалыг хөгжүүлж, иргэд, хүүхэд залуус эрүүл агаарт бие бялдраа хөгжүүлэх, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх зорилгоор “UB Resort” цанын баазад зохион байгуулсан “Мөнгөн Улаанбаатар” өвлийн спорт наадамд дүүргийн Засаг даргын Тамгын газар болон харьяа газар, агентлагуудтай хамтран зохион байгуулж, арга хэмжээнд оролцогсдод зориулан гаргах үйлчилгээний байгууллагуудын хүнсний хангамж, эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавин ажилласан. Хүй долоон худагт дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж буй Жаат хээр ХХК-ийн Монгол хуушуур бейкэрийн хамт олон өвлийн спортын наадамд оролцогсдод 6 нэр төрлийн халуун хоол, аарц, цай, кофегоор үйлчилж, дүүргүүдийн дунд зарласан мөсөн хотхон байгуулах уралдаан, цасны бүжгийн тэмцээн, ерөнхий зохион байгуулалт, иргэдийн оролцоо зэрэг уралдаан, тэмцээнүүдэд амжилттай оролцож, нийлбэр дүнгээр нийслэлийн хэмжээнд 3 дугаар байранд орж, нийслэлийн Засаг даргын Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/301 дүгээр захирамжийн дагуу 2017 оны 5 дугаар сарын 20-ний өдрийг “Автомашингүй өдөр” болгон зарласантай холбогдуулан тус арга хэмжээнд оролцогчид болон хүрэлцэн ирсэн иргэд, олон нийтэд зориулан Эко бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээг зохион байгууллаа. Сүхбаатарын талбайд зохион байгуулсан Олон улсын марафон гүйлтийн арга хэмжээнд оролцогч гадаад дотоодын тамирчид, иргэд олон нийтэд зориулан халуун хоол, цай, эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх аж ахуй нэгжийг сонгон шалгаруулж, дүүргийн тэргүүний үйл ажиллагаатай Номадс хоспиталити ХХК-ийн Модерн номадс ресторан, БЖЦ ХХК-ийн Романсе ресторан, Шүр хишиг ХХК-ийн Зөгийн үүр бэйкери, Серж интернейшнл ХХК-ийн Милая кафе, Бигүрү ХХК-ийн Намасте ресторан, Кофе мания ХХК-ийн Бивон зэрэг 6 ресторан хоолны үйлчилгээ, Баттрейд Си ХХК, Хаан жимс ХХК-ийн Чацарганы охь бренд, Гэрэлт шонхор ХХК Хатан цай бренд, Тод оймс ХХК, Сүхбаатар дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн бойжигчдын урласан монгол үндэсний хувцас, бэлэг дурсгалын үзэсгэлэн гаргаж, амтат хоолны үйлчилгээ, амталгаат болон хямдралтай, бэлэгтэй, урамшуулалттай худалдаа, үйлчилгээг зохион байгуулсан.</p> <p>Хичээлийн шинэ жилийн өргөтгөсөн худалдааг Белло индиго ХХК-тай хамтран Драмьн</p>	
--	--	--

		<p>театрын арын талбайд 2017 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 2017 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл зохион байгуулж, нийт 30 гаруй аж ахуйн нэгж, иргэнийг түр ажлын байраар хангаж, сургууль цэцэрлэгийн хүүхэд багачуудад зориулсан хичээлийн хэрэгсэл, сурагчийн дүрэмт хувцас, хүүхдийн хувцас, ариун цэврийн хэрэгсэл зэрэг төрөл бүрийн бараа бүтээгдэхүүний худалдаа гаргаж, нийслэлчүүдийн хичээлийн шинэ жилийн бэлтгэл хангахад тодорхой хувь нэмэр орууллаа. Өргөтгөсөн худалдааны хог тээврийн асуудлыг нийслэлийн Хот тохижилтын газартай ярилцан, хөнгөлөлттэй нөхцлөөр төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэж, Улаанбаатар Их дэлгүүр, Метро молл, Аса цирк, Сарны титэм зэрэг томоохон худалдааны төвүүдэд ажлын байран дээрх өргөтгөсөн худалдааг зохион байгуулсан.</p> <p>Нийслэл Улаанбаатар хот үүсч, хөгжсөний 378 жилийн ойг тохиолдуулан эдийн засгийн хүндрэлийг даван туулах, улс эх орныхоо тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлэх арга хэмжээний хүрээнд төр, засгаас хэрэгжүүлж байгаа бодлогыг дэмжин, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, нийслэлчүүддээ урамшуулалттай, үнийн хөнгөлөлттэй, бэлэгтэй үйлчилгээ үзүүлэхийг уриалсан Нийслэлийн Засаг даргын Уриалгыг дэмжиж, энэхүү уламжлалт арга хэмжээг 2017 оны 10 дугаар сарын 10-29-ний өдрийн хооронд “Их хотын хямдрал-378” нэртэйгээр ахуйн үйлчилгээний 27, хоол үйлдвэрлэлийн 4, худалдааны томоохон 11 төвүүдийн ажлын байран дээр зохион байгуулж, 10-90%-ийн хямдралтай, бэлэгтэй, урамшуулалттай худалдаа, үйлчилгээг үзүүлж, нийслэлчүүддээ бэлэг барилаа. Ойн баярыг тохиолдуулан дүүргийн нутаг дэвсгэрт ахуйн үйлчилгээ, зочид буудал, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Жон Ми Жэ, Р.Оюун захиралтай “Авдар өргөө” ХХК-ий хамт олон нийгмийн хариуцлагынхаа хүрээнд Сайн санааны аянд нэгдэж, нийслэл хот, дүүргийнхээ цэвэр цэмцгэр байдлын төлөө цаг наргүй ажилладаг “Сүхбаатар дэвшил” ОНӨААТҮГ-ын 140 ажилтанд халуун сэтгэлийн бэлэг барьж, дүүргийн Тод оймс үйлдвэрийн тэмээний ноосон нурууны бүс, өвдгөвч, эх орны Улаанбаатар гурил ХХК-ийн Улаанбаатар гурил, ургамлын тос зэрэг хүнсний бүтээгдэхүүний багцыг Натурал ресторандаа зочлох эрхийн бичгийн хамт гардууллаа. Энэхүү үйл ажиллагааг дэмжиж Б.Баяржаргал захиралтай “Тод оймс” үйлдвэрийн хамт олон багцад орсон бүтээгдэхүүндээ 20%-ын хямдрал олгож, Сүхбаатар дэвшлийн хамт олонд баяр хүргэлээ.</p>				
<b>5.3 Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлнэ.</b>						
147	5.3.1. Гадаад харилцааг өргөжүүлэн уламжлалт харилцаатай улс орны хот, дүүрэгтэй хамтран ажиллах хамтын ажиллагааг бэхжүүлж, шинээр улс орны хот, дүүргүүдтэй харилцаа тогтооно.	Хүүхэд солилцооны хөтөлбөрийг өргөжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	100%
		Япон Улсын Нагано мужийн Сакү хот “Сурагч солилцоо хөтөлбөр” Уламжлалт Сурагч солилцоо хөтөлбөрийн дагуу 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс 10-ны өдрүүдэд Сүхбаатар дүүргийн ЗДТГ-н 1 хэлтсийн дарга, 1 мэргэжилтэн, 7 сурагч, Япон улсын Сакү хотод 7 хоногийн танилцах аялалыг амжилттай зохион байгууллаа. Хөтөлбөрт хамрагдсан сурагчид Япон орны түүх, зан заншил, соёлтой танилцан Сакү хотын Бага, дунд сургуулийн бүтэн өдрийн хичээлд суун япон сурагчдын хичээл хэрхэн явагддаг талаар суралцаж ирлээ.				

148		Уламжлалт харилцаатай хот дүүрэгтэй хамтын ажиллагааг үргэлжлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	
		<p>1. <u>БНСУ-н Сөүл хотын Жонгно дүүрэг</u></p> <p>Сүхбаатар дүүргийн Засаг дарга Х.Болормаа албаны дөрвөн хүний хамтаар 2017 оны 09 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд Солонгос улсын Сөүл мужийн Жонгно дүүргийн Засаг дарга Ким Ён Жоны урилгаар ажлын айлчлал хийгээд ирлээ. Энэхүү албан айлчлалын бүрэлдэхүүнд дүүргийн ЗДТГ-ын дарга Н.Энхболд, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч П.Жавзмаа, Х.Батжаргал, болон ЗДТГ-ын Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжлэгээний хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч М.Бямбасүрэн нар багтсан болно.</p> <p>Айлчлалын бүрэлдэхүүн хөтөлбөрийн дагуу 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн үдээс хойш Incheon Free Economics zone хоттой танилцсан юм. IFEZ хот нь санхүү, аялал жуулчлалын бүс нутаг төдийгүй, залуусын чөлөөт цагаа өнгөрөөхөөр зорин ирдэг газрын нэг ажээ. Газар нутгийн хувьд 123.8 квкм бөгөөд 2022 он гэхэд 540 мянган хүн амьдрах төлөвлөлт бүхий бүс нутгийнхаа томоохон хот болон хөгжих зорилго тавьжээ. IFEZ хотын 30 хувь нь ногоон байгууламж байхаар төлөвлөгдсөн байна.</p> <p>Мөн айлчлалын үеэр Жонгно дүүргийн хогний менежменттэй танилцаж туршлага судлан Сүхбаатар дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд ил задгай хог хаягдал үүсэх, хогийн савны өнгө үзэмж муудаж, багтаамж муутай байгаагаас хог хаягдал багтахгүй гадуур асгарах, хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын тээвэрлэх хувиараас зөрж хог хаях зэрэг асуудлуудыг цэгцлэхээр Сүхбаатар дүүрэгт эхний ээлжинд 25 байршлыг сонгон шинэчилж, 24 цагийн камертай диспетчерын хяналт тавихаар болжээ.</p> <p>Тус дүүргийн Засаг даргын Тамгын газар болон нийт хэлтсүүд салбар бүрт орон нутгийн онцлогт тохирсон шийдэлтэй менежмент хэрэгжүүлэх судалгаа шинжилгээ, эрэл хайгуул хийдэг. Энэ удаа хог хаягдлын менежментийг ухаалаг болгох зорилт дэвшүүлэн бэлтгэл ажил 100 хувь хангагдан гүйцэтгэл 45 хувьтай байна. <b>Энэхүү төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж байна.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Хогийн савны суурь хэсэг болон эргэн тойрны хэсгийг бетондож хөрсний бохирдлоос сэргийллээ.</li> <li>-Хогийн сав байрлуулсан орчныг бүрэн гэрэлтүүлэх гэрэлтүүлэг хийнэ.</li> <li>-Хяналтын камер байршуулж ил задгай хог хаягдал үүсгэх, хогийн савны гадуур хаях, орчин бохирдуулах, хог хаягдлыг цаг тухайд нь тээвэрлэж байгаа эсэхэд хяналт тавих, мөн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийнэ.</li> <li>-Камер 24 цагийн турш диспетчерын хяналтанд байснаар хамтын хариуцлага дээшилнэ.</li> </ul> <p>Мөн “Амьдралын буруу хэв маягаас урьдчилан сэргийлэх” төслөөс артерийн даралт ихсэлтийн талаарх иргэдийн мэдлэг хандлагыг үнэлэх судалгааг 80 хүнээс авч дүгнэлт хийн, 32 эмч, сувилагч нарын ур чадварыг нэмэгдүүлэх багц сургалтыг зохион байгуулсан. Төслийн хүрээнд 60ш алхаа хэмжигч, 20ш давс хэмжигчийг нийлүүлж, артерийн даралт ихсэлттэй 60 хүнд алхаа</p>				90%

		хэмжигчийг ашиглаж, хөдөлгөөний идэвхийг тодорхойлох судлгаа хийж байна. Давс хэмжигчийг ашиглан дээрх судалгаанд оролцож буй иргэдэд дасвны хэрэглээний талаарх зөвлөгөө өгсөн. Судалгааны үр дүнгийн боловсруулалт хийгдэж байна. Мөн 10 дугаар сард 1 эмч, 2 сувилагч, Япон улсын Китами хотод сургалтад хамрагдсан. Энэхүү төсөл нь 2017-2019 онд хэрэгжинэ.				
149	5.3.2. Харилцаат хот, дүүргүүд рүү албан хаагчдыг албан айлчлал, сургалт, хурал, үзэсгэлэн, туршлага судлах аялалд хамруулж мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.	Харилцаат хот дүүргүүд рүү албан хаагчдыг албан томилолт болон сургалт, уулзалтад хамруулах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	
		<p>1. Япон Улсын Нагано аймгийн Саку хот Сүхбаатар дүүргийн Засаг дарга Х.Болормаа албаны дөрвөн хүний хамтаар 2017 оны 05 дугаар сарын 1-нээс 5-ны өдрүүдэд Япон улсын Нагано мужийн Саку хотын Засаг дарга Сэйжи Янагидагийн урилгаар ажлын айлчлал хийгээд ирлээ. Энэхүү албан айлчлалын бүрэлдэхүүнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Д.Мөнхбаяр, Р.Чогжмаа, М.Алимаа болон ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Засаг даргын зөвлөлийн хурал, Удирдах ажилтны шуурхай, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн О.Ууганжаргал нар багтсан болно.</p> <p>2. БНХАУ-н Бээжин хотын Дунчөн дүүрэг Сүхбаатар дүүрэг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотын Дунчөн дүүрэгтэй 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн Санамж бичиг байгуулсны дагуу Дунчөн дүүргийн Засаг даргын урилгаар Сүхбаатар дүүргийн Иргэдийн Хурлын тэргүүлэгч, Засаг даргын орлогч П.Давхарбаяр, тэргүүлэгч Ш.Батдорж, төлөөлөгч С.Очирбат, Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтсийн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Ц.Өнөрчимэг нарын бүрэлдэхүүнтэйгээр 2017 оны 06 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд албан айлчлал хийв. Сүхбаатар дүүргийн төлөөллийг Дунчөн дүүргийн дарга Li Xianzhong, орлогч дарга Zhao Lingyun, салбар хариуцсан захирал Luo Haisen, Liu Jian, Rao Jngdong нарын бүрэлдэхүүнтэйгээр хүлээн авч уулзан 2 талын цаашдын хамтын ажиллагаа, нийгэм, соёл, боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх ажлуудын талаар санал солилцов. Мөн Дунчөн дүүргийн Түн Шийн Олимпын биеийн тамир, соёлын төв, Сүлжээний менежмент үйлчилгээний төв, 4-р бага сургууль, 171-р дунд сургууль, Ge Hua Шинжлэх ухааны паркттай танилцсан бөгөөд үүнд Цахим үйл ажиллагаа эрхэлдэг Vision vera Co.,Ltd, Хятадын CCTV телевизийн хүүхдийн кино, нэвтрүүлгийн CCTV animation Inc, кино урлагийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлдэг The one media group зэрэг байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан бөгөөд Паркийн дарга Cai Yong болон дээрх байгууллагууд нь олон улсын соёлын үйл ажиллагааг дэмжин ажиллахаа илэрхийлсэн.</p> <p>3. БНСУ-н Сөүл хотын Жонгно дүүрэг Сүхбаатар дүүргийн Засаг дарга Х.Болормаа албаны дөрвөн хүний хамтаар 2017 оны 09 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд Солонгос улсын Сөүл мужийн Жонгно дүүргийн Засаг дарга Ким Ён Жоны урилгаар ажлын айлчлал хийгээд ирлээ. Энэхүү албан айлчлалын бүрэлдэхүүнд дүүргийн ЗДТГ-ын дарга Н.Энхболд, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч</p>				100%

		<p>П.Жавзмаа, Х.Батжаргал, болон ЗДТГ-ын Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжэлгээний хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч М.Бямбасүрэн нар багтсан болно.</p> <p>Айлчлалын бүрэлдэхүүн хөтөлбөрийн дагуу 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн үдээс хойш Incheon Free Economics zone хоттой танилцсан юм. IFEZ хот нь санхүү, аялал жуулчлалын бүс нутаг төдийгүй, залуусын чөлөөт цагаа өнгөрөөхөөр зорин ирдэг газрын нэг ажээ. Газар нутгийн хувьд 123.8 квкм бөгөөд 2022 он гэхэд 540 мянган хүн амьдрах төлөвлөлт бүхий бүс нутгийнхаа томоохон хот болон хөгжих зорилго тавьжээ. IFEZ хотын 30 хувь нь ногоон байгууламж байхаар төлөвлөгдсөн байна.</p> <p>4. Япон Улсын Нагано мужийн Саку хот “Сурагч солилцоо хөтөлбөр”</p> <p>Уламжлалт Сурагч солилцоо хөтөлбөрийн дагуу 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс 10-ны өдрүүдэд Сүхбаатар дүүргийн ЗДТГ-н 1 хэлтсийн дарга, 1 мэргэжилтэн, 7 сурагч, Япон улсын Саку хотод 7 хоногийн танилцах аялалыг амжилттай зохион байгууллаа. Хөтөлбөрт хамрагдсан сурагчид Япон орны түүх, зан заншил, соёлтой танилцан Саку хотын Бага, дунд сургуулийн бүтэн өдрийн хичээлд суун япон сурагчдын хичээл хэрхэн явагддаг талаар суралцаж ирлээ.</p> <p>5. БНСУ-н Засгийн газрын тэтгэлэгээр Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, шагнал хариуцсан мэргэжилтэн А.Буянхишиг нь 2017 оны 11 дүгээр сарын 29-ны өдрөөс 12 дугаар сарын 03-ныг хүртэл LOGODI буюу /Орон нутгийн удирдлагын хөгжлийн хөтөлбөр/-т хамруулахаар боллоо.</p> <p>6. Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны “Дэвжин дээшлэх Сүхбаатар дүүрэг” хөтөлбөрийн хүрээнд хамтын ажиллагаатай Жонгно дүүрэгт туршлага солилцохоор Засаг даргын орлогч Ц.Шижир болон ЭМТ-н дарга Л.Баярхүү нарын тэргүүтэй баг бүрэлдэхүүнийг 2017 оны 11 дүгээр сарын 29-ны өдрөөс 12 дугаар сарын 02-ны өдрүүдэд Жонгно дүүргийн Дэд бүтэц, тохижилт мөн Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаатай танилцахаар бэлтгэл ажил хангагдан ажиллаж байна.</p>				
150	5.3.3. Дүүрэгт хэрэгжүүлж болох үр ашигтай гадаадын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллана.	<p>Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй АДРА-Монгол олон улсын байгууллагын Тогтвортой тариалан төсөл, Дэлхийн зөн олон улсын байгууллагын Нэн эмзэг, олон хүүхэдтэй эхчүүдийг дэмжих Хүлэмж төсөл, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгээр Монголын фермер эмэгтэйчүүдийн холбоо төрийн бус байгууллагын Монгол ногоо төслүүдийг үргэлжлүүлэн ажиллана.</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	ТЗУХ	ХХҮХ
		<p>Дүүргийн иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор өрхийн тариалан эрхлэлтийг дэмжин, АДРА-Монгол Олон улсын байгууллагатай хамтран “Өрхийн тогтвортой тариалан” төсөл, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгээр Монголын фермер эмэгтэйчүүдийн холбоо ТББ-аас хэрэгжүүлж буй Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл, маркетингийн “Монгол ногоо” төсөл, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран Хүлэмж төслүүдийг амжилттай үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Дэлхийн зөн, АДРА-Монгол ОУБ-аас хэрэгжүүлж буй</p>				100%

		төслүүдийн хугацаа 2017 онд дуусгавар болж байгаа бөгөөд, АДРА-Монгол ОУБ-аас төслийн арга хэмжээг 1 жилээр сунгаж, 2018 онд үргэлжлүүлэн хамтран ажиллах саналыг хүлээн авч, дүүргийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгасан.	
--	--	--	--

ТАНИЛЦСАН:

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Х.БОЛОРМАА

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

НЭГТГЭСЭН:

ТГХШХ-ийн МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТЦЭЦЭГ